# ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН 2014 ОНЫ ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТОВЧООН

2014 оны 12 дугаар сарын 08

| д/д | Агуулга | | | бүгд | Зорилго 1 Агаар нь цэвэр дүүрэг | Зорилго 2 Амины сууцтай дүүрэг | Зорилго 3 Ажилтай орлоготой дүүрэг | Зорилго 4 Аюулгүй, амгалан дүүрэг | Зорилго 5 Авлигагүй дүүрэг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | | | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1 | Нийт заалтын тоо | | | **163** | **27** | **12** | **45** | **50** | **29** |
| 2 | Биелсэн /100 %/ | | | 144 | 22 | 8 | 44 | 45 | 25 |
| 3 | Хэрэгжилтийн явц | Хэрэгжих шатандаа | | **19** | **5** | **4** | **1** | **5** | **4** |
| | | Үүний дотор: | 90.0% | 13 | 4 | 4 | 1 | 4 | 0 |
| | | | 70.0% | 5 | 1 | 0 | 0 | 1 | 3 |
| | | | 50.0% | | | | | | |
| | | | 30.0% | | | | | | |
| | | | 10.0% | 1 | | | | | 1 |
| 4 | | | 0% | | | | | | |
| 5 | | Хугацаа болоогүй | | | | | | | |
| Нийт хувь | | | | **97,7%** | 97,4% | 96,6% | 99,7% | 98,6% | 94,4% |

ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН 2014 ОНЫ ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Дүүргийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт | 2014 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хариуцах хэлтэс | Хугацаа |
|---|---|---|---|---|
| **НЭГ. АГААР НЬ ЦЭВЭР ДҮҮРЭГ** | | | | |
| *1.1.* ***Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр*** | | | | |
| 1 | 1.1.1 Дүүргийн төвийн гудамж, цэцэрлэгт ногоон байгууламжууд, хиймэл нуур, цөөрөм, усан оргилууруудыг байгуулах замаар агаарын чийгшилтийг нэмэгдүүлнэ. | Тохижилт, ногоон байгууламж болон бичил цэцэрлэг байгуулах газрын асуудлыг шийдвэрлэнэ. | ДБТХ | 100% |
| | | Дүүргийн нутаг дэвсгэрт хийгдэж байгаа тохижилт, бүтээн байгуулалтын ажлын явцад ажлын трасст орж байгаа зөвшөөрөлгүй барьсан өргөтгөл, хайс хашааг дүүргийн өмч газрын харилцааны албатай хамтран албадан буулгах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. | | |
| 2 | | Сэлбэ цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг эхлүүлнэ. | ДБТХ | 90% |
| | | Хоёр ангиртын рашааны орчмын 1,2 га газарт орчин үеийн архитектурын шийдэлтэй, ногоон байгууламж, усан оргилуур, утасгүй интернэтийн орчин бүхий соёл, спорт, амралтын цогцолбор байгуулахаар зураг төслийг нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газраар хийлгэж байгаа ч тодорхойгүй хугацаагаар хойшлоод байна. | | |
| 3 | | Нутаг дэвсгэрийн усан оргилууруудыг хэвийн ажиллагаатай болгох, шинээр усан оргилуур бий болгоно. | ДБТХ | 100% |
| | | Дүүргийн нутаг дэвсгэрт ажиллаж байгаа 13 усан оргилуурын ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллаж байгаа байгууллагуудад усан оргилууруудын хэвийн ажиллагааг хангаж, хуваарийн дагуу тогтмол ажиллуулж байх тухай үүрэг даалгавар өгөөд байна. Мөн дүүргийн орон сууцны хороолол дундахь ажиллагаагүй 2 дугаар хорооны 32 дугаар байрны усан оргилуур, 10 дугаар хороо 31 дүгээр байрны 2 усан оргилуурыг засварлах ажлыг “Термо электтрейд” ХХК 100 хувь хийж гүйцэтгээд байна. | | |
| 4 | 1.1.2 Гэр хорооллыг дахин төлөвлөх замаар айл, өрхүүдийг төвлөрсөн болон бие даасан эрчим хүчний эх үүсвэрт холбох ажлыг нийслэлийн холбогдох байгууллагуудтай хамтран үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 15, 16, 17 дугаар хорооны инженерийн байгууламж барих ажлыг эхлүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана. | ЭЗТХ | 70% |
| | | Нийслэлийн Засаг даргын А/57 дугаар захирамжийг хэрэгжүүлж 15 дугаар хорооны дахин төлөвлөлтийн ХЕТ-д тусгагдсан 1.2 км авто зам, 2х24 у/м гүүр, 1.2 км ус зайлуулах шугам сүлжээ, 1.2 км-ийн гэрэлтүүлэг, 260 у/м ус зайлуулах далангийн ажлын зураг төсвийг Ерөнхий төлөвлөгөөний газар боловсруулж байна.<br>15 дугаар хороо, дамбадаржаа орчмын дахин төлөвлөлтийн инженерийн байгууламж барихаар зураг төсөл нь хийгдэж батлагдах шатандаа явж байна. Зураг төслийг Мон Энержи Консалт ХХК, Тэш өргөө ХХК нар хийж байна. 16, 17 дугаар хорооны инженерийн байгууламжийн зураг төсөл нь хийгдээгүй байна. | | |
| 5 | | Дамбадаржаагийн дахин төлөвлөлт хийсэн гэр хорооллын айл өрхүүдийг бие даасан эрчим хүчний эх үүсвэрт холбоно. | ДБТХ | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилтод батлагдсан бөгөөд нийслэлийн Засаг даргын А/57 дугаар захирамжаар дахин төлөвлөлтийн байршил дахь инженерийн байгууламжийн зураг төслийг гаргах хөрөнгийг шийдвэрлэж, 15 дугаар хорооны Гоодойн болон Дамбадаржаагийн 80 дугаар гудамжны, 16 дугаар хорооны 15 дугаар гудамж, 71 дүгээр сургуулийн урд амны, Бэлхийн 2, 33 дугаар гудамж, Цээнэ, Гүнж, Хадат, Цуурайтын хөндий, 19 дүгээр хорооны Майхан толгойн айл өрхүүдийг цахилгаан эрчим хүчээр хангах ажлын зураг төслийг хийж дуусгалаа. | | |
| 6 | 1.1.3 Иргэдийг эдийн засгийн аргаар дэмжих замаар дүүргийн ногоон байгууламжийг нэмэгдүүлж, “Дүүргийн экологийн ажилтан ажиллуулна. | Ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна. | ДБТХ ХҮХ | 100% |
| | | Ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд дүүргийн 13, 14,15 дугаар хорооны 20 иргэнийг Байгаль орчин ногоон хөгжлийн яам, Ногоон хөгжлийн голомт үндэсний төвөөс хамтран зохион байгуулсан Ногоон хөгжлийн төлөөлөгч бэлтгэх сургалтанд хамруулсан. Мөн мод үржүүлгийн чиглэлээр дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг иргэд ААНБ-н үйл ажиллагааг дэмжих зорилгоор, 1 дүгээр хорооны нутаг дэвсгэр Хүүхдийн ордны хойд талбайд мод,бутны үзэсгэлэн худалдааг 2014 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс 05 сарын 13-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулсан. Үзэсгэлэн худалдаанд 16, 18 дугаар хороодын 8 иргэн, дүүргийн нутаг дэвсгэрт мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 4 аж ахуй нэгж байгууллага оролцлоо | | |
| 7 | | Дүүргийн аж ахуйн нэгж байгууллагуудыг гадна орчиноо тохижуулах, ногоон байгууламжтай болгох ажлыг зохион байгуулна. | ДБТХ | 100% |
| | | Дүүргийн нутаг дэвсгэрт газар эзэмшиж, ашиглаж байгаа Иргэн, ААНБ, Хуулийн этгээдүүдийн эзэмшил газрынхаа 30-аас доошгүй хувьд нь тохижилт бүтээн байгуулалт, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн арчлалт хамгаалалт, хог цэвэрлэгээг хийлгэх хяналт тавьж ажиллах дүүргийн Засаг даргын 2013 оны 257 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн гаргасан судалгааны дагуу үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар газар эзэмшиж байгаа иргэн, аж ахуй нэгж байгууллагад өгсөн албан даалгаврын биелэлтийг хангуулахаар ажиллаж байна. Мөн орчныхоо ногоон байгууламж, зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээ, арчлалт хамгаалалтыг сайжруулах, тогтмол хийж хэвшүүлэх тухай Засаг даргын 2014 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 04 тоот албан даалгаврыг хүргүүлэн биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. | | |
| 8 | | Эко ажилтанг үргэлжлүүлэн ажиллуулна. | ДБТХ | 100% |
| | | Экологийн ажилтанг ажиллуулснаар байгаль орчин, ногоон байгууламж, орчны бохирдол, аж ахуйн нэгж байгууллагын гаднах орчны цэвэрлэгээ үйлчилгээнд тавих хяналт эрс сайжирсан. 2014 оноос хойш 36,700,000 төгрөгний урамшууллыг ажлын гүйцэтгэл, тайланг харгалзан олгосон байна. | | |
| 9 | 1.1.4 Агаарын бохирдлыг бууруулах олон хувилбарт эрчим хүчний эх үүсвэрийг хэрэглээнд нэвтрүүлсэн иргэд, аж ахуйн нэгжийг урамшуулах тогтолцоог бий болгоно. | Дулааны эх үүсвэрээ орчин үеийн технологиор шийдвэрлэсэн айл өрхийг цахилгааны үнийн хөнгөлөлтөнд хамруулах ажлыг зохион байгуулна. | ДБТХ | 100% |
| | | Агаарын бохирдлыг бууруулах төслийн хүрээнд эрчим хүчний хэмнэлтэт бүтээгдэхүүн хэрэглэж буй айл өрхөд цахилгааны үнийн хөнгөлөлт эдлүүлэх журмын дагуу 2014 оны халаалтын улиралд нийт 5413 айл өрхийг хамруулсан. | | |
| 10 | | Дулааны хэмнэлттэй, бүрэн шаталттай зуухны төсөлд айл өрхийг хамруулах ажлыг үргэлжлүүлнэ. | ДБТХ | 90% |
| | | 2014 оны 10 сараас дулааны хэмнэлттэй, бүрэн шаталттай зуухны төсөлд айл өрхийг хамруулах ажил үргэлжлэн хийгдээд явж байна. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 11 | 1.1.5.Хотын тоосжилтыг бууруулах зорилгоор сул шороон хөрс бүхий гудамж, талбайг зүлэгжүүлэх эсхүл хатуу хучилттай болгох журам гаргаж мөрдүүлнэ. | Журам батлуулах бэлтгэл ажлын хүрээнд сул шороо бүхий газрын судалгаа гаргах, хучилт хийх ажлын зургийг гаргана. | ДБТХ | 90% |
| | | Ногоон байгууламж хийх шаардлагатай 3600м$^2$ талбай бүхий 54 байршлыг хороодын Засаг даргын ажлын албатай хамтран гаргаж, 77315 м$^2$ талбайд ногоон байгууламжийн ажил хийхээс дэргэдэх хэлтэс албад 11 байршилд, хороодын засаг даргын ажлын албад 20 байршилд ногоон байгууламж шинээр хийх болон нөхөн сэргээх ажлыг хариуцан гүйцэтгэж байна. Гэр хорооллын сул шороон хөрс бүхий 21 байршилд орон нутгийн төсвөөс хайрган хучилттай зам тавина.<br>Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/670 захирамжаар баталсан ногоон байгууламж нэмэгдүүлэх ажлын хүрээнд хийсэн тохижилтын ажлыг хүлээн авах ажлын комисст холбогдох мэргэжилтнийг томилон Байгаль орчин, ногоон хөгжлийн газартай хамтран ажиллаж байна. | | |
| 12 | 1.1.6. Усан халаалтын болон технологийн зориулалт бүхий зуухнуудад бүртгэл хяналтын тогтолцоо нэвтрүүлж, технологийн шинэчлэлийг Нийслэлийн холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ. | Усан халаалт болон технологийн зориулалт бүхий зуухнуудыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлнэ. | ДБТХ | 100% |
| | | Нам даралтын зуухтай айл өрхийг орчин үеийн дэвшилтэт технологиор дулааны хангамжаа шийдвэрлэх талаар мэргэжлийн байгууллагуудтай хамтран заавар, зөвлөгөө өгөх, санал тавих зэрэг ажлуудыг зохион байгуулж 2014 онд захиалга өгсөн 558 айл өрхийг “Хүрд” ХХК-иас нийлүүлж буй утаа бага гаргагч усан халаалтын зуухаар хангасан. | | |
| | | ***1.2 Хөрс болон орчны бохирдлыг бууруулах чиглэлээр:*** | | |
| 13 | 1.2.1 Дүүргийн нийтийн эзэмшлийн зам талбайн арчилгаа, цэвэрлэгээг тусгай зориулалтын техник, хэрэгслээр хийж гүйцэтгэнэ. | Цас хусагч, цэвэрлэгч авто машин, техник хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, холбогдох байгууллагуудтай хамтран зам талбайн цэвэрлэгээг зориулалтын техник хэрэгслээр хийнэ. | ДБТХ | 90% |
| | | Хог тээврийн 3-5 машин худалдан авахаар сонгон шалгаруулалтын шатанд Худалдан авах ажиллагааны албанд өгсөн. | | |
| 14 | 1.2.2 Дүүргийн хог хаягдлын менежментийг сайжруулна. Хог хаягдлыг ангилан боловсруулах хөтөлбөрийг шинэчлэн хэрэгжүүлж, хоггүй цэвэр орчинг бүрдүүлнэ. | Дүүргийн хог хаягдлын менежментийг эрчимжүүлэхэд гадаад орны туршлагыг нэвтрүүлнэ. | ДБТХ | 100% |
| | | Азийн сан, Байгальд ээлтэй хөршүүд ТББ, хог тээвэрлэгч байгууллагуудтай хамтран хог тээврийн календарьчилсан хуваарийг хэвлүүлж 14, 15, 17, 18 дугаар хороодын айл өрхүүдэд тараан хуваарийг мөрдүүлэн ажилласны үр дүнд 14, 15, 17 дугаар хороодод хог тээврийн хуваарь мөрдөл хангалттай хэмжээнд хэвшсэн. 18 дугаар хороо нутаг дэвсгэр том, айл өрх ихтэйгээс хог тээврийн хуваарийг шинэчлэн мөрдүүлэх шаардлага гарч, арга хэмжээ аван ажиллаж байна.<br>Нийслэлийн захирагчийн ажлын алба, Азийн сантай хамтран Загвар хороо төслийг 14 дүгээр хороонд амжилттай хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд хог хаягдал тээвэрлэлтийн явцад ажлын зураг авалт хийж баталгаажуулсан. 14 дүгээр хороонд хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах талаар хороо, дүүрэгтэй хамтран ажиллах 4 иргэдийн бүлгийг байгуулсан. Иргэдийн бүлгээр орчны хог хаягдлыг багасгах, тохижилт бүтээн байгуулалтын 2 төслийг бичүүлж, санхүүжилт 14,0 сая төгрөгийг Азийн сангаас олгуулж хогийн цэг байсан 2 байршилд хүүхдийн тоглоомын талбай, сагсан бөмбөгийн талбай зэрэг тохижилтын ажлыг хийлгэж хүлээлгэж өгсөн. Мөн төслийн хүрээнд хог тээврийн машин | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | явахад хүндрэлтэй байсан 2 гудамжийг хайрган хучилттай болгож янзлуулсан. | | |
| 15 | | Хог хаягдлын шинэ менежментийн ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | ДБТХ | 100% |
| | | Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар дүүргийн хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөрийг хэлэлцүүлэн 2014 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 57 дугаар тогтоолоор батлуулж биелэлтийг ханган ажиллаж байна.<br>Хог тээвэрлэгч байгууллагын хог тээвэрлэлтэнд хяналт тавих зорилгоор Цагаан давааны хогийн цэгт сар бүр ажиллаж хог хаягдлаа дутуу ачсан, хогоо асгахгүй гарч дахин орох, тонн жингээ илүү бичүүлэх зэрэг зөрчлүүдийг газар дээр нь илрүүлж таслан зогсоож хариуцлага алдсан жолооч, ачигч нарт цалингийн хувь хасах, сануулах, ажлаас халах хүртэл арга хэмжээг авахуулж ажилласны үр дүнд хог тээврийн хяналт сайжирч дээрх зөрчлүүд гарахгүй болсон.<br>ДИТХ-ын иргэний оролцооны хэлтэс, хог тээвэрлэгч байгууллагууд, хороодын засаг даргын ажлын алба, ААНБ, иргэдтэй хамтран 1, 4, 5, 6, 8, 10, 14, 15 дугаар хороодын нийт 18 байршлын ил задгай хогийн цэгүүдийг бүрэн устгасан.<br>Азийн сан, Байгальд ээлтэй хөршүүд ТББ, хог тээвэрлэгч байгууллагуудтай хамтран хог тээврийн календарьчилсан хуваарийг хэвлүүлж 14, 15, 17, 18 дугаар хороодын айл өрхүүдэд тараан хуваарийг мөрдүүлэн ажилласны үр дүнд 14, 15, 17 дугаар хороодод хог тээврийн хуваарь мөрдөл хангалттай хэмжээнд хэвшсэн. 18 дугаар хороо нутаг дэвсгэр том, айл өрх ихтэйгээс хог тээврийн хуваарийг шинэчлэн мөрдүүлэх шаардлага гарч, арга хэмжээ аван ажиллаж байна.<br>2014 оны 1-4 сард 36018 өрхөд 2,215,270 ширхэг хогны уутыг тараасан.<br>Нийслэлийн Засаг даргын 2014 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/287 дугаар захирамжийн хүрээнд хог хаягдлын уутны хэрэглээг үргэлжлүүлэх эсэхийг тодорхойлох санал асуулгыг 2014 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр дүүргийн 1-20 дугаар хороодын 5000 айл өрхийн дунд явуулсан. Судалгааны ажилд Дэд бүтэц, тохижилтын хэлтэс бүрэн бүрэлдэхүүнээрээ, Оюутны холбооны судалгааны багийн 20 оюутан, хотын хөгжлийг дэмжих “Шинэ тосгон хөдөлгөөн” ТББ-ын 5 ажилтан хамтран ажиллаж нийслэлийн захирагчийн албаны мэргэжилтнүүдэд санал асуулгын хуудас болон нэгдсэн дүн мэдээг хүлээлгэн өгсөн.<br>Санал асуулгын дүнгээр иргэдийн 60 гаруй хувь нь хогны уутыг хэрэглэх санал өгсөн тул 2014 оны 9 дүгээр сараас хог хаягдлын уут тараах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж 2,162,340 ширхэг хогны уутыг дүүргийн айл өрхөд худаг, хүнсний дэлгүүр, хороо, СӨХ зэрэг 205 цэгээр дамжуулан тарааж хэрэглээг хэвшүүлэх талаар арга хэмжээ авч ажилласны үр дүнд хог хаягдлын уутны хэрэглээ 95,2 хувьтай байна.<br>Дүүргийн нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээний журмын дагуу орон сууц болон гэр хороолол дундах нийтийн эзэмшлийн авто болон явган зам, талбай нийт 398,987 $м^2$ талбайн цэвэрлэгээ, үйлчилгээг “Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ-аар гүйцэтгүүлэн, гүйцэтгэлд хяналт тавьж сар бүр 72,292,855 сая төгрөгний санхүүжилтыг олгож байна. 2014 оны 03 сараас 11 сарыг дуустал нийт 640,0 гаруй сая төгрөгний санхүүжилтийг олгосон. Зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээний ажил хангаттай түвшинд хийгдэж хог хаягдалгүй цэвэр орчинг бүрдүүлэн ажиллаж байна.<br>Гэр хороодын гудамжинд байршуулах зөөврийн битүүмжилсэн 4 ширхэг хогийн функерийг хийлгүүлж ашиглалтанд өгсөн.<br>Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс баталсан эко ажилтан ажиллуулах журмын дагуу 1-20 дугаар хороодод 20 эко ажилтанг ажиллуулан сар бүр ажлын тайланг хянаж урамшууллыг олгон ажиллаж байна. | | |
| 16 | 1.2.3 Зуслангийн бүсүүдэд | Зуслангийн бүсийн болон гэр хороодын айл өрхийн жорлон бохирын цооног, бохирдсон хөрс, хогийн | ДБТХ | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хөрсийг бохирдлоос хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, бие даасан инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц бий болгох арга хэмжээг авч ажиллана | цэгүүдэд ариутгал халдваргүйтгэлийн ажлыг хийнэ. | | |
| | | Дүүрэг, Хороодын Засаг даргын ажлын албанаас гэр хороодын айл өрхийг хашаандаа зориулалтын бохирын цооногтой байх, нийтийн эзэмшлийн гудамж талбайд бохир асгахгүй байх талаар албан мэдэгдлийг хороодоор дамжуулан хүргүүлж биелэлтэд хяналт тавин ажилласан.<br>Дүүргийн 1-20 дугаар хороодын нийтийн эзэмшлийн гудамж талбайн хогийн сав, цэг, бохирдсон хөрстэй гудамж, далан, гуу жалганы нийт 38050 мкв талбайд хөрсний ариутгал халдваргүйтгэл ажил хийлгэхээр сонгон шалгаруулалт явуулж шалгарсан “Орхон овоот” ХХК-тай гэрээ байгуулан 2014 оны 06 сарын 09-ний өдрөөс 06 сарын 18-ний өдрийн хооронд ариутгал, халдваргүйтгэлийн ажил хийлгэсэн.<br>Аритугал, халдваргүйтгэлийн ажилд хороодын Засаг даргын ажлын алба, Дүүргийн мэргэжлийн хяналтын хэлтэс, Онцгой байдлын хэлтэсүүдтэй хамтран хяналт тавин ажиллаж 19, 922, 980 төгрөгний санхүүжилтыг гүйцэтгэлээр олгосон.<br>Дүүргийн 12 дугаар хорооны үерийн далангийн бохирдсон хөрсийг цэвэрлэж 3 машин хөрсийг тээвэрлүүлсэн.<br>Нийслэлийн захирагчийн ажлын албатай хамтран Чингисийн талбайн урд хонхтой цэцэрлэгт нийтийн бие засах газар Сити тойлет бариулж ашиглалтанд оруулсан.<br>Дүүргийн гэр 9, 11-20 дугаар хороодын 19820 айл өрхийн жорлон, бохирын цооногт ариутгал халдваргүйтгэлийн ажил хийх байгууллагыг сонгон шалгаруулж 1-р багц 9, 11-14 дүгээр хороодод Бакс-Анд ХХК, 2-р багц 15-20 дугаар хороодод Ди-Юу-Ди ХХК шалгарсан. Сонгон шалгаруулалтанд шалгарсан компаниудын ариутгал, халдваргүйтгэлийн ажлын гүйцэтгэлд 2014 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 17-ны өдрийн хооронд байнгын хяналт тавьж ажиллан 138,740,000 төгрөгийн санхүүжилтыг олгуулсан. | | |
| 17 | 1.2.4 Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж буй үйлдвэрийг хотоос гадагш төвлөрүүлэн байгуулах шат дараалсан арга хэмжээг авна. | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглаж байгаа болон байгаль орчинд хортой нөлөө үзүүлж болзошгүй үйлдвэрийн судалгааг гаргаж, байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг хийлгэнэ. | ДБТХ | 100% |
| | | Дүүргийн нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглаж байгаа иргэн аж ахуй нэгж байхгүй болсон. | | |
| 18 | 1.2.5 Дүүргийн зуслангийн бүсийн байгаль орчныг хамгаалах, энэ бүсэд дахин төвөлөлт хийх замаар ая тухтай, цэвэр агаар бүхий ногоон суурьшлын бүс болгон хөгжүүлнэ. | Ойн менежмент бүхий төлөвлөгөөтэй иргэд, нөхөрлөлийн бүлгүүдтэй хамтран ажиллаж, үйл ажиллагаанд нь иргэдийн оролцоотойгоор хяналт тавиулна. | ДБТХ | 100% |
| | | Сүхбаатар дүүргиийн Засаг даргын 2014 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн А/200 тоот захирамжийн дагуу 6-р дугаар сарын 5-ны өдөр 19, 20-р хорооны ногоон бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөлүүдийн үйл ажиллагаа, зохион байгуулсан ажилтай танилцаж, ногоон бүсэд хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулаа. | | |
| 19 | | Зуслангийн газрыг өмчлөх ажлыг эхлүүлнэ. | ӨГХА | 100% |
| | | Нийслэлийн Засаг даргын 2011 оны 03 дугаар сарын 21 өдрийн ХЕТ-2011/12 тоот захирамжаар Улаанбаатар хотын зуслангийн амуудын ерөнхий төлөвлөгөөг батлуулсан. Тус дүүргийн 20-р хороо Бэлхийн Цээнэ, Цолмонгийн ам, 15-р хороо Архустайн амуудын газар өмчлөлийн материалуудыг авч эхлээд байна. | | |
| 20 | | Зуслангийн газрыг өмчлөхтэй холбогдуулан хаягжуулалт хийнэ. | ӨГХА | 100% |
| | | Зуслангийн зориулалтаар эзэмшүүлсэн газрыг өмчлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд НИТХ-н 2014 оны 06 дугаар сарын | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 26-ны өдрийн 100 дугаар тогтоолоор зуслангийн хаягжилтыг батлаад байна. | | |
| ***1.3 Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр:*** | | | | |
| 21 | 1.3.1 Улаанбаатар хотын цэцэрлэгжилтийн мастер төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана. | Дүүргийн нутаг дэвсгэрийн ногоон байгууламжийн зураг схемийг гарган мэдээллийн санд оруулна. | ДБТХ | 100% |
| | | Дүүргийн нутаг дэвсгэрийн 1-10 дугаар хорооны ногоон байгууламж бүхий талбайг Дэд бүтэц, тохижилтын хэлтэст ArcGis 10.2.1 програм хангамж ашиглан мэдээллийн сан  үүсгээд байна. | | |
| 22 | | Тохижилт бүтээн байгуулалтын ажлын хүрээнд ногоон байгууламж бүхий бичил тохижилт хийнэ. | ДБТХ | 100% |
| | | 1-20 дугаар хорооны 47 байршилд тохижилт бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулж гүйцэтгэл 100 хувьтай байна. Захиалагчын хяналт тавьсан | | |
| 23 | | Тохижилт бүтээн байгуулалт, ногоон байгууламжийн ажлуудын нөхөн сэргээлт болон засвар үйлчилгээг хийнэ. | ДБТХ | 100% |
| | | Дүүргийн хэмжээнд 1-20 дугаар хорооны нутаг дэвгэрт төсвийн хөрөнгөөр хийгдсэн тохижилт бүтээн байгуулалтын ажлын арчлалт хамгаалалт, нөхөн сэргээлтийг гэрээгээр 6 байгууллагад хариуцуулан гүйцэтгэлд нь хяналт тавьж ажилласан. Цэвэрлэгээ үйлчилгээний зардлыг сар бүрийн гүйцэтгэлээр олгосон болно. | | |
| 24 | 1.3.2 Нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалтад иргэд байгууллагын оролцоог нэмэгдүүлж, тэдний идэвх санаачлагыг дэмжиж урамшуулна. | Аж ахуй нэгж байгууллагуудын дунд шилдэг ногоон байгууламжтай аж ахуй нэгж шалгаруулах уралдаан зохион байгуулна. | ДБТХ | 100% |
| | | Өөрийн эзэмшил газартаа ногоон байгууламжийн ажил хийж нийслэл, дүүргийн өнгө үзэмжийг сайжруулахад өөрийн хувь нэмрээ оруулж байгаа аж ахуй нэгж байгууллагуудыг Нийслэлийн өдрийг тохиолдуулан шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж хороодоос шилдэг тохижилттой ААНБ-ын холбогдох мэдээллийг нийслэлийн Захирагчийн ажлын албанд хүргүүлсэн. Нийслэл хот байгуулагдсаны 375 жилийн ойг угтаж шилдэг тохижилттой хороо, аж ахуй нэгж байгууллага, дүүрэг шалгаруулах уралдаанд тус дүүргийн 5 дугаар хорооны “Талст” худалдааны төв, Айти март дэлгүүр, "Айти центр" дэлгүүр, "Топаз" үйлчилгээний төв, 7 дугаар хороо  Экологийн боловсролын төв, 8 "Окей" ХХК, “Шангрила Улаанбаатар” ХХК, 10 дугаар хороо "New world plaza" ХХК, 11 дүгээр хороо "Цог тулга трейд" ХХК, "Хүннү" ХХК, "Гурван богдын нуруу" ХХК, 12 дугаар хорооны тохилог гудамж болон төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж тохижилт бүтээн байгуулалтын ажлын мэдээ мэдээллийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. | | |
| 25 | | Хороолол дундах тохижилт ногоон байгууламжийн арчлалт хамгаалалтыг байгууллага, иргэдэд хариуцуулна. | ДБТХ | 100% |
| | | Дүүргийн орон сууцны болон гэр хорооллын дундах тохижилт ногоон байгууламж бүхий талбайн арчлалт хамгаалалтыг 6 аж ахуй нэгж байгууллагад гэрээгээр хариуцуулан нөхөн сэргээлт, арчлалт хамгаалалтын ажлыг хийлгэн, хяналт тавин ажиллаж байна. Санхүүжилтийг сар бүр олгож ажилласан. | | |
| ***1.4 Усны эх үүсвэрийг хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр:*** | | | | |
| 26 | 1.4.1 Сэлбэ голын усны урсацыг нэмэгдүүлэх, сэргээх, голын ай сав газрыг | Сэлбэ голын ай сав газрыг хамгаалах, эргийн дагуу ойжуулалт хийх ажлыг зохион байгуулна. | ДБТХ | 100% |
| | | Монгол Улсын Ерөнхийлөгчийн  2010 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн  Мод тарих үндэсний өдрийг зарлах тухай 63 дугаар зарлиг хангах ажлын хүрээнд Бүх нийтээр мод тарих өдрийг 2014 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 19-ний өдрүүдэд дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд амжилттай зохион байгуулсан. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба, Засаг даргын Тамгын газрын 148 ажилтан, албан хаагчид 13 дугаар хорооны нутаг дэвсгэр Сэлбэ голын эрэгт 800 ширхэг мод тарьж, цаашид арчлалт хамгаалалтыг Мөнх ногоон төгөл ТББ-т хариуцуулан өглөө. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 27 | хамгаална. | Нутаг дэвсгэрийн рашаан булгийг хамгаалж тохижуулна. | ДБТХ | 100% |
| | | Дүүргийн орон нутгийн хөгжил сангийн хөрөнгөөр 19 дүгээр хорооны нутаг дэвсгэр Санзайн рашааны эхийг, Майхан толгойн булгийн эх, Санзайн булгийн эх, Хандгайтын булгийн эх, Шарга морвтын булгийн эх, 20 дугаар хороо Гүнжийн булгийн эх гэх 5 рашаан булгийн эхийг хамгаалалтанд авч тохижуулах ажлыг иргэдийн бүлгүүдээр хийлгэж, гэрээ байгуулан, ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаа. Ажлын гүйцэтгэл 100% дуусч тохижилтын ажлыг ашиглалтанд хүлээн аваад байна. | | |
| **ХОЁР. АМИНЫ СУУЦТАЙ ДҮҮРЭГ** | | | | |
| ***2.1. Хот төлөвлөлт, газрын харилцааг нээлттэй, ил тод болгох чиглэлээр:*** | | | | |
| 28 | 2.1.1 Иргэдийн оролцоотойгоор газар зохион байгуулалт, төлөвлөлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, барилга, обьект барихдаа тухайн нутаг дэвсгэрийн оршин суугчдын саналыг заавал авдаг журамд шилжинэ. | Газар зохион байгуулалттай холбоотой санал хүсэлтийг хороодоор дамжуулан хэлэлцүүлж, санал хүсэлт авна. | ӨГХА | 90% |
| | | Нийслэлийн Засаг даргын 2014 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн А/97 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2014 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн А/87 дугаар захирамжийн дагуу 12, 13, 14 дүгээр хорооны иргэдтэй уулзаж санал хүсэлт тавин, газрыг чөлөөлсөн бөгөөд уг газарт тохижилтын ажил хийгдэж эхлээд байна.16 дугаар хорооны байранд өмч, газрын асуудал хариуцсан мэргэжилтэн 4 удаа очин иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч, иргэдэд зөвлөгөө өгсөн. 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний саналыг хороодоос авч төлөвлөгөөнд тусгасан. | | |
| | | Дүүргийн ерөнхий төлөвлөгөөг хотын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан шинэчилнэ. | ӨГХА ЭЗТХ | 100% |
| | | Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газраас иргэдэд шинээр өмчлүүлэх 52 байршил сонгон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан. Тус дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт Тоосгоны үйлдвэрийн орчимд байршуулан 64.0 га, 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт Тоосгоны үйлдвэрийн орчимд байршуулан 23.0 га газруудыг иргэдэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгохоор төлөвлөөд байгаа бөгөөд 2014-2016 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан олголтыг хийх юм. /Тайлбар: Ихэнх талбайд айлууд суурьшсан тул бодит байдалд ойролцоогоор 3.6 га газар байгаа/<br>Дүүргийн 2014 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 16 дугаар хороо тоосгоны үйлдвэр орчимд цэцэрлэг барихаар төлөвлөсөн. Уг төлөвлөгөөний дагуу дүүргийн Засаг даргын 2014 оны А/79 дүгээр захирамжаар 16 дугаар хороо Ойчдын гудамжинд 1609 $м^2$ газрыг хүүхдийн цэцэрлэгийн барилга барих зориулалтаар дүүргийн Засаг даргын Тамгын газарт эзэмшүүлэх эрх олгоод байна.<br>Дүүргийн 2014 оны 06 сарын 16-ны өдрийн А/290 дүгээр захирамжаар Хүүхдийн цэцэрлэгийн барилга барих зориулалтаар 0.24 га газрыг СБДТГ-т газар эзэмшүүлэх эрхийг баталгаажуулан олгосон. Мөн Нийтийн эзэмшлийн гудамж, талбайг хэсэгчлэн төлөвлөх ажлын хүрээнд 2015 онд орон сууцны 1-8, 10 дугаар хорооны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийлгэх гэж байгаатай уялдуулан 7 блок байршилд хуваасан ба нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газраар зургийн ажлын даалгавар батлуулан авч ажлын зураг, төсөв гүйцэтгүүлсэн. Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газар, нийслэлийн газрын алба, дүүргийн газрын албатай хамтарч хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийж байгаа 3, 5 дугаар хорооны байршлууд дээр газар дээр нь судалгаа хийлээ.<br>Мөн нийслэлийн зураг төслийн хүрээлэнгээс бага тойруугийн ашиглалтын шаардлага хангахгүй барилгын ТЭЗҮ хийж дуусч нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газарт хүлээлгэн өгөөд байна. | | |
| 30 | | Зөвшөөрөлгүй барьсан гараж, хашаа, чингэлгүүдийг буулгаж, нийтийн эзэмшлийн газруудыг | ӨГХА | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | чөлөөлнө. | | |
| | | НЗД-ын 2014 оны 02 сарын 17-ны өдрийн “Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай” А/97 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2014.03.03-ны өдрийн “Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай” А/87 дугаар захирамж, “Албадан буулгаж газар чөлөөлөх тухай” дүүргийн Засаг даргын 2014 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/89 дүгээр захирамжуудын дагуу нийтийн эзэмшлийн зам талбай, явган хүний зам дээр байршуулсан объект, ТҮЦ, контейнер, хашаа, хаалтыг чөлөөлж ажиллаа. Уг захирамжуудын хэрэгжилтийг хангахаар 12 дугаар хороонд түлээ нүүрс борлуулж байсан 2ш павильон, 1ш 20 тн контейнер, “Гор газ” ХХК сэндвичэн барилга, 3ш дугуй засвар, 2ш ТҮЦ зэргийг нүүлгэн газрыг чөлөөлөөд байна. Чөлөөлсөн газар дээр дүүргийн ДБТХ, ЭЗТХ-ээс тохижилтын ажлыг хийж гүйцэтгээд байна.<br>“Албадан буулгаж газар чөлөөлөх тухай” дүүргийн Засаг даргын 2014 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/204 дүгээр захирамжын хүрээнд 1-20 дугаар хорооны 135 байршилд зөвшөөрөлгүй барьсан айлын хашаа, шон, ТҮЦ, контейнер, вагончик, цементэн хаалт, байрны өргөтгөлийг албадан буулгаж нийтийн эзэмшлийн газрыг чөлөөллөө. Тус ажлыг эрчимжүүлэхээр долоо хоногийн 2, 4 өдрүүдэд ажилласан.<br>“Албадан буулгаж газар чөлөөлөх тухай” дүүргийн Засаг даргын 2014 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн А/363 дугаар захирамжийн хүрээнд 8-р хорооны нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн зам талбайг хаасан зөвшөөрөлгүй баригдсан болон байршуулсан объект, гараж, хашаа, өргөтөл зэрэг 28 иргэн, аж ахуйн нэгжийн байгууллагад хугацаатай албан шаардлага хүргүүлээд байна. | | |
| 31 | 2.1.2 Дүүргийн иргэдийг газраа өмчлөх ажлыг эрчимжүүлж, ил тод нээлттэй болгоно. | Дүүргийн иргэдийн газраа өмчлөх ажлыг хууль журмын дагуу үргэлжлүүлнэ. | ӨГХА | 100% |
| | | 2014 оны 12-р сарын 02-ны байдлаар “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай” хуулийн дагуу нийслэлийн Засаг даргын 15 удаагийн захирамжаар 296 иргэнд 14.1 га газрыг иргэний гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа үнэгүй өмчлүүлээд байна. Мөн 4 иргэнд 159 $м^2$ илүү талбайг үнээр өмчлүүлсэн. Өмчилж авсан газраа гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлсэн, өмчлөгдсөн газрын кадастрын зурагт өөрчлөлт орсон 421 иргэний хүсэлтийг шийдвэрлээд байна. | | |
| 32 | 2.1.3 Эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны загвар стандартыг мөрдүүлэн дүүргийн гэр хороололд хэрэгжүүлнэ. | Эрчим хүчний хэмнэлттэй орон сууц үйлдвэрлэгч байгууллагуудтай хамтран ажиллана. | ЭЗТХ | 90% |
| | | Нийслэлийн гэр хорооллын хөгжлийн газар, Барилгын эрчим хүч хэмнэлтийн мөн /09/301 төслийн хамт олонтой хамтран ажиллаж сургалт зохион байгуулсан.<br>Барилгын дулаалгын материалын шинэ стандартууд, Барилгын хашлага бүтээц, зангилаа уулзварын дулаан тусгаарлалтын нэг маягийн хэсэглэл, Орон сууц, олон нийтийн барилгын төлөвлөлтийн галын аюулгүйн шаардлагууд, Барилга байгууламжийн гал унтраах төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл, Дулаалгын материалын физик механик шинж чанарыг тодорхойлох стандартуудын тухай, Галыг усаар унтраах системийн талаархи БНбД-ийн холбогдох заалтууд, Барилгын материалын галын аюулын ангилал, гал тэсвэрлэлтийн зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгууллаа.<br>Хувийн орон сууц, хаусын нэг маягийн зураг, төсөв Веер.mn сайтад байрлуулж, иргэд, аж ахуй нэгжүүдэд үнэгүй татаж авч, ашиглах нөхцөлийг хангаж өглөө. | | |
| ***2.2. Гэр хорооллыг тохилог амины орон сууцны хороолол болгон хөгжүүлэх чиглэлээр:*** | | | | |
| 33 | 2.2.1 Гэр хорооллыг дахин төлөвлөх замаар дэд бүтэц, ногоон байгууламж бүхий амины орон сууцны | 9, 11, 12 дугаар хорооны гэр хорооллыг дахин төлөвлөхөд иргэдийг мэдээллээр хангаж ажиллана. | ЭЗТХ | 100% |
| | | 9, 11, 12-р хорооны ажлын албаар дамжуулан иргэдэд дахин төлөвлөлт, түүний ажлын явцын талаар мэдээлэл өгч ажиллалаа. Сонгогдсон компаниуд ажлаа эхлүүлсэн ба 2014 онд дараах төлөвлөгөөтэй ажиллаж байна.<br>“Бэрэн групп” ХХК | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хорооллыг байгуулна. | Төлөвлөлтийн талбай: 54 га<br>Ерөнхий төлөвлөлт: 9600 айлын орон сууц<br>Эхний ээлжийн барилгажилт: 16 давхар<br>Ашиглалтанд орох хугацаа: 2014 оны IV улирал<br>Төлөвлөж буй сургууль, цэцэрлэг 2014-2015 онд 180, 120 ортой цэцэрлэг.<br>“Заг” ХХК<br>Төлөвлөлтийн талбай: 79 га<br>Ерөнхий төлөвлөлт: 480 айлын орон сууц<br>Эхний ээлжийн барилгажилт: 12 давхар 4 блок<br>Ашиглалтанд орох хугацаа: 2014 оны IV улирал<br>Төлөвлөж буй сургууль, цэцэрлэг 2015 онд-940 хүүхдийн сургууль<br>“Асар-өргөө” ХХК<br>Төлөвлөлтийн талбай: 45.8 га<br>Ерөнхий төлөвлөлт: 240 айлын орон сууц<br>Эхний ээлжийн барилгажилт: 1080 айлын орон сууц<br>Ашиглалтанд орох хугацаа: 2014 оны IV улирал | | |
| 34 | | 14, 15 дугаар хороог дахин төлөвлөхөд иргэдийг мэдээллээр хангаж ажиллана. | ЭЗТХ | 100% |
| | | 15-р хороо, Дамбадаржаа, 58-р сургууль орчим, 17-р хороо, Дамбадаржаалин хийд орчмын дахин төлөвлөлт болон ажлын явцын талаар хорооны ажлын албатай хамтран иргэдэд мэдээлэл өгч ажилласан. Тус байршлуудад Цэлмэг-Ази ХХК шалгарсан бөгөөд 2014 онд дараах төлөвлөгөөг гарган ажиллаж байна.<br>“Цэлмэг ази” ХХК<br>Төслийн талбайд 2 хэсэг (14 айл) дээр чөлөөлөлт хийгдсэн. Дэд бүтэцтэй холбоотой техникийн нөхцөл гаргуулах, бусад зураг төслийн ажлуудыг гүйцэтгэж байна.<br>Ерөнхий төлөвлөлт: 250 айлын орон сууц<br>Эхний ээлжийн барилгажилт: --<br>Ашиглалтанд орох хугацаа: 2014 оны IV улирал<br>Төлөвлөж буй сургууль, цэцэрлэг 2015 онд-180, 120 ортой цэцэрлэг. | | |
| 35 | | Шинээр дахин төлөвлөлт хийх санал санаачлагыг дэмжин холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана. | ЭЗТХ | 100% |
| | | 2014 онд гэр хороололд айл өрхүүд нэгдэн нийлж газраа зөв зохион байгуулснаар ашиглалтгүй талбайнаасаа нөөц газар бий болгон түүнийгээ эдийн засгийн эргэлтэд оруулах зорилготой газар шинэчлэн зохион байгуулалтын ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна. Гэр хорооллын орон сууцжуулах төсөлтэй хамтран 12, 13-р хорооны иргэдтэй газар шинэчлэн зохион байгуулах талаар уулзалт зохион байгуулсан. Одоогоор 13-р хорооны Рашааны 7, 8, 9-р гудамжны айл өрхүүдэд газар шинэчлэн зохион байгуулахаар бүлэг үүсгээд байна. | | |
| 36 | 2.2.2 Гэр хорооллын иргэдийн инженерийн нэгдсэн болон хэсэгчилсэн | 17 дугаар хорооны гадна инженерийн шугам сүлжээний хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана. | ЭЗТХ | 100% |
| | | 17-р хороо, Дамбадаржаалин хийд орчимд дахин төлөвлөлт хэрэгжиж байгаа хорооны иргэдэд ажлын явцын талаар | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хангамжтай болох чиглэлээр хэрэгжүүлсэн санал санаачлага, үйл ажиллагааг дэмжинэ | мэдээлэл өгч ажиллаж байна.<br>Мөн Ерөнхий төлөвлөгөө: 2013.10.15-нд батлагдсан. Цахилгаан хангамж: Техникийн нөхцөл 2014.02.12 гарсан. Ажлын зургийн трасс НЕТГ-тай 2014.05.15 зөвшилцсөн ба үүний дагуу ажлын зураг хийж байна . Ажлын явц 60% тай Цэвэр бохир усан хангамж: : Техникийн нөхцөл 2013.03.20 гарсан. Үүний дагуу ажлын зургийн трасс 2013.11.25 сонгосон ба НЕТГ-тай зөвшилцсөн. Явц 60% тай /Техникийн нөхцөл өөрчлөхөөр ус сувагт хүргүүлсэн баталгаажаагүй байна. Дулаан хангамж: Өөрийн эх үүсвэрээс хангахаар төлөвлөсөн. Зураг төсөл хийгдэж байна. Ажлын явц 60% -тай 1. 2014 оны 08 дугаар сарын 26-ны байдлаар Дулаан хангамжийн ажлын зураг бүрэн дууссан үүний дагуу төсөв хийгдэж Хангагч байгууллагуудтай зөвшилцөж дууссан. Барилгын хөгжлийн төвд хянагдаж байна. 2. 2014 оны 08 дугаар сарын 26-ны байдлаар Цахилгаан хангамжийн ажлын зураг бүрэн дууссан үүний дагуу НЕТГ, цахилгаан түгээхтэй зөвшилцсөн. Барилгын хөгжлийн төвд хянагдаж байна. 3. 2014 оны 07 дугаар сарын 08-ны байдлаар Цэвэр бохир усан хангамжийн хувьд техникийн нөхцөл 2014 оны 06 дугаар сарын 19-нд шинэчлэн гарсан. Хорооллын бохир, Цэвэр усны зураг бүрэн дууссан. Хангагч байгууллагатай зөвшилцсөн Барилгын хөгжлийн төвд хянагдаж байна. 4. Цэвэрлэх байгууламжийн хувьд ажлын зураг хийгдэж дуусаагүй байгаа. УСУГ-аас Төвийн системд холбохоор техникийн нөхцөл гаргаж үүний дагуу хийх хүсэлт гарган судалгааны ажил хийгдэж байна. | | |
| ***2.3. Орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр:*** | | | | |
| 37 | 2.3.1 Гэр хорооллыг барилгажуулах, хуучин орон сууцыг шинэчлэх ажлыг концессын гэрээгээр хийж гүйцэтгэх замаар орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ. | 7 дугаар хорооллын бүтээн байгуулалтанд авто зам, инженерийн байгууламжийг нэмэгдүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана. | ЭЗТХ | 90% |
| | | 9, 11, 12 дугаар хорооны ажлын албаар дамжуулан дахин төлөвлөлтийн талаар мэдээллийг иргэдэд хүргэлээ.<br>СБД, 11-р хороо, Дулаан хангамжийн ДХ-12-оос ДХ-7 хүртэлх ф426 мм-ийн диаметртэй 564 метр шугам сүлжээний трасс өөрчлөлтийн зураг төслийн ажил, СБД, 11-р хороо, Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний “К” хэсгийн дулааны шугамын трассын өөрчлөлтийн зураг төслийн ажил, СБД, 11-р хороо, Дулаан хангамжийн ДХ-5-аас УДДТ-“Г” хүртэлх ф325 мм-ийн 480 метр, ЭӨ-1-ээс ДХ-5 хүртэлх ф426 мм бүхий 191 метр, нийт 571 метр дулааны шугамын трассыг VII хорооллын хөрсний ус зайлуулах шугамтай уялдуулан өөрчлөлтийн зураг төслийн ажил, СБД, 11-р хороо, ПГ-18-аас УА-4 хүртэл хийгдэх ф300мм диаметр бүхий 876 м урт цэвэр усны шугамын өөрчлөлтийн зураг төслийн ажил тендерийн шатандаа явж байна. | | |
| 38 | | Сэлбэ дэд төв байгуулахад төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллана. | ЭЗТХ | 90% |
| | | 14, 15-р хорооны иргэдэд дахин төлөвлөлтийн ажлын явцын талаар мэдээлэл өгч ажиллаж байна. Улаанбаатар хотын гэр хорооллын дэд төвийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр (Хөрөнгө оруулалтын хөтөлбөр)-ийг бэлтгэхэд нь Монгол улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлэхээр Азийн Хөгжлийн Банк (АХБ) ба GHK Consulting Limited (ICF GHK)-ийн хооронд байгуулсан гэрээний дагуу бэлтгэгдэж ажлын эцсийн тайлан бэлэн болоод Засгийн газарт өргөн бариад байна. | | |
| ***2.4. Дэд бүтцийн хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр:*** | | | | |
| 39 | 2.4.1 Цахилгаан эрчим хүчний хангамжийн тоног төхөөрөмж, хүчин чадлыг сайжруулж, айл өрхийн дулааны зарим хэрэглээг | Гэр хороодын гэрэлгүй айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах, хүчдэлийн уналттай айл өрхийн цахилгаан эрчим хүчний хангамжийг сайжруулах талаар мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана. | ДБТХ | 100% |
| | | 15 дугаар хорооны Ар хустай орчмын гэрэл, цахилгаангүй 178 өрхийг нийслэлийн төсвөөс Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-тай хамтран цахилгаанд холбож, 60 өрхийн хүчдэлийг нэмэгдүүлэхээр агаарын 6 дэд станцад их | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | цахилгаанаар хангах нөхцөл бүрдүүлнэ. | засвар хийж, 0,4 кВ-ын 452 ширхэг модон тулгуур болон байгальд ээлтэй төмөр бетон тулгууруудыг шинээр суурилуулж, цахилгаан дамжуулах агаарын шугамын 11,6 км АС утсыг бүрээстэй СИП утсаар солилоо. | | |
| **ГУРАВ. АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ ДҮҮРЭГ** | | | | |
| ***3.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр:*** | | | | |
| 40 | | Томоохон аж ахуйн нэгж байгууллагуудтай гэрээлэн электрон биржийг олон нийтэд сурталчилна. | ХХ | 100% |
| | | Нийт 18 удаагийн өдөрлөг, семинарын үеэр цахим бирж ажиллаж байгаа талаар иргэдэд мэдээллэсэн. СБ дүүргийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн мэргэжилтэнтэй хамтран цахим биржийн хүртээмжтэй байдлын талаар судалгаа цахим биржээр үйлчлүүлж байгаа иргэдээс авсан. | | |
| 41 | 3.1.1 Дүүргийн хөдөлмөрийн биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэн байнгын, түр, цагийн ажлын байраар хангах, зөвлөгөө өгөх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ. | Хороодын электрон биржийн үйл ажиллагааг өргөтгөнө. | НХХ<br>ХХ | 100% |
| | | Дүүргийн хэмжээнд нийт 20 хороод, хэлтсийн байр, Сэргээн засалт хөгжлийн төвд нийт 23 цахим бирж байгаа бөгөөд уг цахим биржүүд 2014 оны 07 дугаар сараас эхлэн 11 сарын 7-ны хооронд 8471 цаг ажиллаж, нийт 4068 иргэн хандаж, 2146 иргэн ажлын байрны зар хэвлэж авсан. Цахим биржийн тогтмол үйл ажиллагааг байнга шалган, цахим бирж дэх мэдээллийн санг тухай бүрт шинэчилж, эвдрэлтэй, ажиллахгүй байгаа хороодуудын цахим биржүүдийг засварласан.<br>Мөн 1-20 дугаар хороонд 6 мэргэжилтэн бүсчилсэн хэлбэрээр байрлан ажиллаж байгаа бөгөөд Хөдөлмөрийн хэлтсийн хороо хариуцсан мэргэжилтэн хороодын цахим биржийн хэвийн ажиллагааг хангаж байна. Хөдөлмөрийн төв бирж улсын хэмжээнд нэгдсэн журмаар Цахим биржийн мэдээллийн байнга шинэчилдэг. Цахим биржийн мэдээллийн санд шинээр Хөдөлмөрийн хэлтсүүд, Хөдөлмөрийн хувийн бирж, Төсөл, хөтөлбөр, ЖДҮ-ийн хөнгөлөлттэй зээл, цагийн ажил зэрэг мэдээлэл оруулж, иргэдэд мэдээллийг шуурхай хүргэж байна.<br>Дүүргийн Хөдөлмөрийн хэлтсийн мэдээлэл, технологи дотоод сүлжээ хариуцсан мэргэжилтэнтэй хамтран санал асуулгын маягт боловсруулан 200 иргэдээс түүвэр судалгаа авч, нэгтгэн дүгнэлээ. | | |
| 42 | 3.1.2. Шаардлагатай ажил мэргэжлийн жагсаалтыг хэрэгцээний дараалаар гарган ажил, мэргэжилгүй иргэдийг мэргэжил олгох болон мэргэшүүлэх давтан сургалтанд хамруулан тэдгээрийн байнгын ажлын байраар хангана | Шаардлагатай ажил мэргэжлийн жагсаалтыг гарган, хороодоор дамжуулан иргэдэд байнга мэдээлнэ. | ХХ | 100% |
| | | Монгол улсын хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй байгаа ажил мэргэжлийн жагсаалтыг гаргаж хороод болон ерөнхий боловсролын сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрийн төвүүдэд сургалт, зөвлөгөө зохион байгуулахдаа мэдээллийг хүргэж байна. Хамгийн эрэлттэй мэргэжлээр Нано технологич, гидро инженер, сургуулийн өмнөх насны боловсролын багш, сантехникч зэрэг нийт 10 мэргэжлүүд орсон байна. Нийт 3130 иргэнд эдгээр мэргэжлийн талаар мэдээлэл хүргэсэн. | | |
| | | | | |
| 43 | | Ажил мэргэжилгүй иргэдэд мэргэжил олгон, үйлдвэрлэл дээрх сургалтанд түлхүү хамруулж ажлын байраар хангах ажлыг үргэлжлүүлнэ. | ХХ<br>НДХ | 100% |
| | | Санхүүжилтийг НХГ-аас гаргаж иргэдийг сургалтанд хамруулж байгаа бөгөөд 2014 оны эхний 10 сарын байдлаар 216 иргэнийг 49 байгууллагад сургасан. Үйлдвэр дээрх сургалтын Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв нэгдсэн байдлаар зохион байгуулж байгаа бөгөөд үйлдвэр дээрх сургалтанд Сүхбаатар дүүргийн 23 иргэнийг хамруулсан. | | |
| 44 | 3.1.3. “УБ агро парк”-ийн 100 га талбайд ажилгүй иргэд туслах аж ахуй эрхлэхэд нь дэмжлэг | Ажилгүй 100 иргэнийг агропаркад бойжигчдын туршлагыг судлуулан туслах аж ахуй эрхлэхэд нь дэмжлэг үзүүлж ажлын байртай болгоно. | ХХ | 100% |
| | | 40-өөс дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 40-өөс дээш насны нийт 192 иргэнийг түр ажлын байраар хангасан. Үүнээс 100 иргэн төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах төсөлд хамрагдаж | | |

<table>
<tr><td></td><td>үзүүлнэ.</td><td colspan="3">Нийслэлийн хэмжээнд бүх дүүргийн иргэд нийт 446,5 тн төмс, 14280 кг өргөст хэмх, 780 кг улаанлооль хураан авсан.</td></tr>
<tr><td rowspan="2">45</td><td rowspan="4">3.1.4. Ахмад насны болон нийгмийн эмзэг бүлгийн иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон эхчүүдэд амьдрах орчноо сайжруулах, байгаль орчноо нөхөн сэргээх ногоон ажлын байр бий болгох, хамтарч ажиллах боломжийг бүрдүүлнэ.</td><td>Ахмад настан, өрх толгойлсон эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг бүх талаар дэмжин, төсөл хөтөлбөрт хамруулах, бүтээгдэхүүн борлуулалтанд нь дэмжлэг үзүүлж, ажлын байраар хангана.</td><td>НХХ<br>ХХ</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="3">Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ төслийн хүрээнд 30 баг бүлгийн 90 ахмад иргэд, 170 иргэнд мэдлэг ур чадвараа ашиглан зөвлөгөө үйлчилгээ үзүүлээд байна.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хувиараа хөдөлмөр эрхлэдэг хөгжлийн бэрхшээлтэй 20 иргэн аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамрагдаж, 16 иргэн нь санхүүгийн буцалтгүй тусламжинд хамрагдсан. Мөн 40 сая төгрөгний санхүүжилтийн хүрээнд 35 төсөл шалгарч, 40 хөгжлийн бэрхшээтэй иргэн байнгын ажлын байртай болсон. Мэргэжлийн ур чадварын сургалтанд 5 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдаж, 2 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажилтай болж, 1 иргэн хувиараа хөдөлмөр эрхлэж байна. Ажил олгогчыг дэмжих арга хэмжээний хүрээнд “ Номин холдинг “ ХХК-д ажил олгогчын урамшуулалын мөнгө 2,304,000 мянган төгрөгийг шилжүүлж, 3 байгууллагатай ажил олгогчдын гэрээ хийгээд байна.</td></tr>
<tr><td rowspan="2">46</td><td>Эмнэлэг, хөдөлмөр магадлах комиссын үйл ажиллагааг сайжруулна.</td><td>НДХ</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="3">Эмнэлэг хөдөлмөр магадлах Төв комиссоос улсын хэмжээнд Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйлчилгээний чанарыг сайжруулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын чанарын аян”-ыг 2014 оны 10 дугаар сарын 01-ээс 2 сарын хугацаатай зохион байгуулан явуулж байна.<br>Нийгмийн даатгалын сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр шинээр тогтоолгосон болон шилжин ирсэн мэдээллийг дүүргийн эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын мэдээллийн сантай тулган шалгаж үр дүнг тооцон ажиллаа. Дүүргийн нийгмийн халамжаас 112 иргэн, шилжин ирсэн 24 нийт 136 иргэний жагсаалт үүсгэн ЭХМК мэдээллийн сантай тулгахад 126 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын ямар нэгэн зөрчилгүй ба 10 иргэний мэдээлэл нь ЭХМК мэдээллийн санд бүртгэгдээгүй байсан. Зөрчилтэйд тооцогдсон уг 10 иргэнээс 6 нь сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын хурлаар хөдөлмөрийн чадвар алдалтын асуудлаа шийдвэрлүүлсэн, 2 иргэн өөр дүүрэг болон орон нутгаас шилжин ирсэн, 2 иргэн нь СБД-ээс шилжин явсан тул дүүргийн эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын програмд мэдээлэлгүй байсан байна.<br>Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудад Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах олон улсын өдрийг угтсан “Даатгуулагчид ээлтэй-нийгмийн даатгал” сарын аяны хүрээнд Дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн нарийн мэргэжлийн эмч болон хороодын эрүүл мэндийн төвийн ахлах эмч зэрэг 40 гаруй хүн оролцсон сургалтыг 2014 оны 10 дугаар сарын 30-нд 29 дугаар сургуулийн хурлын танхимд “Эмнэлэг, хөдөлмөрийн магадлалын үйлчилгээний чанар ба шинэчлэл” –ийн талаар зохион байгуулав.<br>2014 оны 10 дугаар сарын 6-нд Дүүргийн эрүүл мэндийн нэгдэлтэй хамтран өрхийн эмнэлэг болон, нарийн мэргэжлийн эмч нарыг хамруулсан сургалтыг зохион байгуулж Магадлагч эмч Ш.Батцэнгэл мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө. Уг сургалтанд 58 эмч хамрагдсан.<br>“Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах хууль, эрх зүй” “Нийгмийн халамж үйлчилгээний тухай хууль” Эрүүл мэндийн төв Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарт сургалт зохион байгуулав. Сургалтанд нийт 119 эмч хамрагдаж, харилцан санал солилцож эмнэлэг хяналтын болон эмнэлэг хөдөлмөр магадлах коммисын хуралд тулгамдаж буй асуудлыг хэлэлцсэн нь үр дүнтэй арга хэмжээ боллоо.</td></tr>
</table>

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл дээр байрлах ЭХМКомиссын хурлын байрны нөхцөл сайжруулахад болон иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох нэн шаардлагатай байгаа тоног төхөөрөмжийн судалгаар жагсаалтаар гарган 2013 оны 4 дүгээр улиралд дүүргийн Засаг даргад уламжлан хүсэлт гаргасан. Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн нарийн мэргэжлийн эмч нартай хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эмчлэн, эрүүлжүүлэх, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбоотойгоор хяналтын картыг тогтмол хөтлүүлж, ЭХМК-ын хурлаар хөдөлмөрийн чадвар алдагдлыг тогтоох, сунгах үед үр дүнг нь тооцон, хянат тавин ажиллаж байна. Эмнэлэг хяналтын комиссын үйл ажиллагааг ЭХМК-ын хурлын үйл ажиллагаатай уялдуулж ажлыг сайжруулахын тулд салбар амбулатори бүр дээр сард 1 удаа очин зөвлөгөө, зөвлөмж өгч ажиллаж байна<br>Энэ онд ЭХМК нь нийт 48 удаа 222 цаг хуралдаж 2950 даатгуулагч иргэний асуудлыг шийдвэрлэв. Үүнээс 311 даатгуулагчид ХЧА-ыг шинээр тогтоож, 2378 даатгуулагчийн хугацааг сунган, шилжиж ирсэн 154, шилжин явсан 25, нас барсан 64, цуцласан 140, үүнээс хугацаагүй сунгасан 54, 170 даатгуулагчийн хувийг нэмэгдүүлэн, 52 даатгуулагчийн хувийг бууруулан, материал нь шаардлага хангаагүй болон группт орох шаардлагагүй 50 даатгуулагчийг буцаав. Хөдөлмөрийн нөхцөл сольсон 4 даатгуулагч байна. ЭХМК-ын хурлаар орох иргэдэд хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхийн тулд хуваарь, жагсаалт гарган иргэдэд үйлчилгээ үзүүлсэн нь тодорхой үр дүнтэй ажил болж байна. | | |
| 47 | | Ахмад настан болон нийгмийн эмзэг бүлгийн үүсгэл санаачлагын бүлгийг дэмжиж, бүлгийн зохион байгуулалттайгаар хөдөлмөр эрхлүүлэн 20 хорооны 80 бүлэгт төсөл хэрэгжүүлнэ. | НХҮХ | 100% |
| | | Гэр бүл, ахмад настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих төрийн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, үйлчилгээний шинэ төрлүүдийг хөгжүүлэн ажиллаж ирлээ.<br>Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйл, 18.1.9 заалтыг үндэслэн Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээний хүрээнд нийгмийн халамжийн дэмжлэг шаардлагатай 2 ба түүнээс дээш өрх, иргэд өөрсдийн санаачлагаар нэгдэн бүлэг болж орлогоо нэмэгдүүлэх зорилгоор төсөл боловсруулах ажлыг Дүүргийн 20 хороонд зохион байгуулан ажилласан. Хороодын халамжийн мэргэжилтэн, АДЗ-ийн гишүүдэд бүлгийн зохион байгууллалтай төсөл хэрэгжүүлэх үйлчилгээний хүрээнд арга зүйн зөвлөгөө өгч, удирдамж гарган хороодын мэргэжилтнүүдэд тарааж өгч ажилласан.<br>Бүлгийн зохион байгуулалттай төсөл хэрэгжүүлэх үйлчилгээний хүрээнд нийт 15 хорооноос 58 бүлгийн төсөл ирүүлсэн. Хороодоос ирсэн төслийг ажлын хэсэг гарган, бүлгийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, үнэлгээний хорооны хурлаар хэлэлцүүлэн хянаж үзээд, 30 бүлгийн хэрэгжих магадлалтай төслийг санхүүжүүлэн ажиллаж байна. Дээрх бүлгүүдийг дэмжлэг авч хэрэгжүүлж буй төслийн чиглэлээр авч үзвэл. эсгий урлал, оёдол, гар урлал, мужаан, хүнсний ногоо, засвар үйлчилгээ, бэлэг дурсгал, жижиг дунд үйдвэрлэл гэсэн чиглэлтэй үйл ажиллагаа явагдсан.<br>Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны харъяа хэлтэс, агентлагуудын зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөгт төсөл хөтөлбөрт хамрагдсан бүлгүүдийг оролцуулж, үзэсгэлэн гаргасан. Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хүрээнд өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан ажиллах 102 өрхийн 283 иргэн өдөрлөгийн арга хэмжээнд оролцож, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнээс санхүүгийн дэмжлэг авсан тус дүүргийн 6-р хорооны “Сайн хөрш” бүлгийн бүтээлүүдээр үзэсгэлэн гарган олон нийтэд сурталчиллаа. Монгол улсын Засгийн газраас 2014 оныг “Гэр бүлийн хөгжлийг дэмжих” жил болгон зарласантай холбогдуулан дүүргийн хороодын халамжийн мэргэжилтнүүдийн хороо бүрт зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөгт бүлгийн зохион | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | байгууллалттайгаар хөдөлмөр эрхэлж байгаа өрх, иргэн өөрсдийн бүтээлээрээ оролцсон.<br>Үр дүн: Төсөл хэрэгжсэнээр нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх-иргэдийг зохион байгуулалттай хөдөлмөр эрхлүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох зэргээр ядуурлаас гаргахад дэмжлэг болох юм.<br>2014 оны жилийн эцсийн Нийт 30 бүлэгт төсөл хэрэгжиж 93 өрх хамрагдаж 300 гаруй иргэний амьдралд тодорхой ахиц гарч нэг өрх сард дунджаар 120,0-160,0 мян төгрөгийн тогтмол орлоготой болсон. | | |
| 48 | | Өрхийн хэрэгцээ, чадавх, санаачлагыг дэмжих орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тогтоох судалгааны үндсэн дээр дүүргийн эмзэг 60 өрхийг чадавхижуулан ядуурлаас бүрэн гаргах төсөл хэрэгжүүлнэ. | НХҮХ | 100% |
| | | 1. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны ажлын асуулгыг мэдээллийн санд шивж оруулах ажил 2014 оны 03 сарын 01-нд дууссан. Алдааны тайлан дээр ажиллах үйл явц 2014 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөр дуусгавар болсон. Мэдээллийн санд 34266 өрх орсоноос бүрэн шалгаж дууссан 34256 өрх, үлдсэн 10 өрхийн гишүүдийн регистрийн дугаар алдаатай засварлагдах боломжгүй байгааг иргэний бүртгэл мэдээллийн албатай хамтран шийдвэрлэхээр ажиллаж байна. Салбар дундын мэдээллийн санд орсон өрхүүдэд тулгалт хийж, өрхийн амьжиргааны түвшингийн оноо бодох ажил дууссан. Сүхбаатар дүүргиийн нийт өрхийн амьжиргааны түвшний үнэлгээг 20 түвшинд бодож гаргасан. 1-р түвшинд 278 өрх, 2-р түвшинд 419, 3-р түвшинд 379 өрх, 4-р түвшинд 525 өрх, 5-р түвшинд 540 өрх, 6-р түвшинд 591 өрх, 7-р түвшинд 660 өрх, 8-р түвшинд 803 өрх, 9-р түвшинд 849 өрх, 10-р түвшинд 986 өрх, 11-р түвшинд 1154 өрх, 12-р түвшинд 1142 өрх, 13-р түвшинд 1275 өрх, 14-р түвшинд 1377 өрх, 15-р түвшинд 1565 өрх, 16-р түвшинд 1650 өрх, 17-р түвшинд 1886 өрх, 18-р түвшинд 2524 өрх, 19-р түвшинд 2557 өрх, 20-р түвшинд 6889 өрх тус тус үнэлэгдсэн байна. Засгийн газрын тогтоосон босго оноонoос доогуур үнэлэгдсэн 1-р түвшний 278 өрхөөс 243 өрхийн 1535 иргэн хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан. Том хүн 797, хүүхэд 737 тус үйлчилгээг авч байна. Үлдсэн 35 өрх нь үндсэн хаягандаа байхгүй, нүүсэн зэрэг шалтгаанаар хамрагдаагүй болно.<br>2. "Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хүрээнд Гэр бүлийн хөгжлийн тулгамдсан асуудал, гэр бүлд чиглэсэн нийгмийн үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг иргэд, олон нийттэй хамтран ярилцлага зохион байгуулсан. Энэ ярилцлагаар гэр бүлийн хөгжилд тулгамдаж байгаа асуудал түүний бодит шалтгааныг тодохойлж, гэр бүлд чиглэсэн нийгмийн үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг хэрхэн шийдвэрлэх үүднээс Дүүргийн засаг даргын дэргэдэх хэлтэсүүдтэй хамтран гэр бүлийг ядуурлаас гаргах ажлын төлөвлөгөө гарган ажилласан. Энэ ажлын эхлэл болгож нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай Өрхийн амьжиргааны түвшин доогуур эмзэг бүлгийн эхний 60 өрхийг хороо бүрээс сонгон авч нөхцөл байдлын үнэлгээ хийж, өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хорооны засаг даргатай хамтран гаргаж албаны даргаар батлуулан ажилласан.<br>3. Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамнаас 2014 оныг "Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан Дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсээс "Бид нэг гэр бүл" сэдэвт 45 хоногийн аян зохион байгууллаа. Аяны хүрээнд 6, 9, 18, 20 дугаар хорооны "Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрт"-т хамрагдаж буй нийт 191 өрхөөс хороо бүр нэг гэр бүлийг сонгон авч, гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлэх, хамтач сэтгэлгээг бий болгох, өрхийн гишүүдийг идэвхжүүлэх, нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд зорилготойгоор уралдаан зохион байгууллаа.<br>4.Төлөвлөгөөний дагуу нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай 60 өрхөд "Кейс менежер"-ийн үйлчилгээ үзүүлэх дэд төлөвлөгөө боловсруулан бүх өрхөд нөхцөл байдлын үнэлгээ хийж, өрхийн гишүүдийн | | |

| | | |
|---|---|---|
| | | дэлгэрэнгүй судалгаа гаргаж, өрх бүрт хийх ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлсэнээр өнөөдрийн байдлаар 45 өрхийн кейсийг 100 хувь амжилттай хааж үлдсэн өрхүүдтэй 2015 онд үргэлжлүүлэн ажиллахаар болсон.<br>Жишээ: Дүүргийн 20 дугаар хорооны Цээнэ 4-13 тоотод оршин суугч Батаа овогтой Эрдэнэчимэг нь ам бүл 4, эх С.Жавзандулам, 4-7 насны 3 хүүхдийн хамт 5 ханатай гэрт амьдардаг. Нөхөр Б нь байнга архи хэтрүүлэн хэрэглэж, эхнэр хүүхэддээ агсан тавьж, зоддог байсан тул салсан. Б.Эрдэнэчимэг нь өөрийн гэсэн гэр оронгүй.<br>Б.Эрдэнэчимэг нь 2004 онд БХИС-ийн нягтлан бодогч мэргэжлээр баклаварын зэрэгтэй төгссөн. Дээд боловсролтой. Том охин Э.Хонгорзул нь Сүхбаатар дүүргийн 71 дүгээр сургуулийн 2 дугаар ангид суралцдаг.<br>2014 оны 3 дугаар сард хорооны амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүд уг өрхөд нөхцөл байдлын үнэлгээ хийж Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5.8-д гурав ба түүнээс дээш тооны 14 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/ гэж заасны дагуу жилд нэг удаа олгох мөнгөн тэтгэмжинд хамруулсан.<br>Тус хорооны Засаг даргад хүсэлт гарган хүү Э.Эрдэнэбаярыг 2014 оны 9 дүгээр сараас тус хорооны үйл ажиллагаа явуулж эхлээд байгаа “Цасан гоо” хувийн цэцэрлэгт үнэ төлбөргүйгээр 2 хүүхэд болох Э.Сайханбилэг, Э.Эрдэнэбаяр нарыг хамруулсан. Цэцэрлэгийн сарын төлбөр нэг хүүхдэд 300 000 төгрөг. Тус өрхөд сарын орлогоос 600 000 төгрөг хэмнэж чадсан.<br>Тус өрхөд гэр олгоход хүндрэлтэй байгаа. Учир нь тэнэмэл өрх, иргэн гэсэн хуулийн заалтанд тохирохгүй, цаашид ямар арга хэмжээ авч ажиллах талаар судлаж байна. Б.Эрдэнэчимэгийг хэсгийн ахлагчаар ажилд оруулах санал тавьж ажилд оруулж 180,000 мянган төгрөгийн байнгын орлоготой болсон.<br>**Үр дүн:** 4 иргэнийг ажилтай, тогтмол орлоготой<br>6 иргэнийг бичиг баримттай<br>3 иргэнийг сургуульд оруулж, мэргэжил олгох<br>38 өрх иргэн хүнсний хөтөлбөрт хамруулж<br>8 өрхөд гэр олгож<br>5 иргэнийг байнгын ажлын байраар хангасан<br>5. Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн үйл ажиллагааг эрчимжүүлэх “Нээлттэй хаалганы өдөр”-т тус дүүргийн иргэд болон хэлтсийн хамт олон амжилттай оролцлоо.<br>Нийслэлийн нийгмийн халамж үйлчилгээний газраас ирүүлсэн удирдамжийн дагуу ажлын төлөвлөгөө гарган 41 мэргэжилтний бүрэлдэхүүнтэй өдөрлөгт оролцсоноос гэр бүлтэйгээ оролцсон 23 мэргэжилтэн байсан.<br>Иргэдийн асуун сонирхож байгаа асуулт нь ахмад настны амралт, рашаан сувилал, орон сууц болон түлээ нүүрсний хөнгөлөлттэй холбоотой асуудлууд байлаа.<br>**Үр дүн**. Салбар дундын мэдээллийн санд бүх 34265 өрх бүртгэлтэй болж өрхийн амьжиргааны түвшин тогтоосон<br>2014 оноос эрхийн бичгийн үнийн дүнг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын баталсны дагуу 0-16 хүртэлх насны хүүхдэд 5000 төгрөг, 16-аас дээш насны иргэнд 10000 төгрөгийн талон олгохоор ажиллаж сар тутам 1535 иргэнд хүнсний талон олгогдож байна<br>Халамжийн үйлчилгээний талаар мэдээлэл, зөвлөгөө хүссэн 244 иргэдийг шаардлагатай мэдээллээр хангаж ажиллалаа<br>Эдгээр арга хэмжээнд нийт 300 гаруй өрх, 2800 гаруй иргэн хамрагдсан байна |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 49 | 3.1.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах, хөгжүүлэх төвийг байгуулна. | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах хөгжүүлэх төвийн байрны зураг төсвийг баталгаажуулна. | НХҮХ | 100% |
| | | Дүүрэгт байгуулах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах, хөгжүүлэх төвийн газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр ажилласан.<br>1.Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын яамнаас "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах хөгжүүлэх төв"-ийн барилгын нэг маягийн зураг 1,4 тэрбум төгрөгийн төсвийг баталж өгсөн.<br>Газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр 29-р тусгай сургуулийн хашаанд барихаар удирдлагатай уулзан тохиролцож, Нийслэлийн боловсролын газраас зөвшөөрөл авч Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Өмчийн харилцааны газарт шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэн өгөөд байна.<br>2.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах, хөгжүүлэх төвийг дүүрэг бүрт байгуулах барилгын газрын асуудлаар Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газарт хандсан.<br>3. Хэлтсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг мэргэжилтнүүдийг дохионы хэлний шаталсан сургалтанд хамруулахаар сэргээн засах үндэсний төвд саналаа хүргүүлээд байна<br>**Үр дүн:** Төвийн зураг, төсөв батлагдаж гарсан, газрын асуудлаар өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн дээд шатны байгуллагад өргөн барьсан шийдвэрлэх шатандаа явж байна.<br>Хороо хариуцсан 20 мэргэжилтэн дохионы хэлний сургалтанд хамрагдана. | | |
| | | ***3.2. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр:*** | | |
| 50 | 3.2.1. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд Бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлнэ. | ЖДҮ эрхлэгч ахуйн үйлчилгээ, хоршоо, нөхөрлөлийг бизнес эрхлэх бүх төрлийн сургалтанд хамруулж төсөл хөтөлбөрт зуучилна. | ХХ | 100% |
| | | ЖДҮХДСан, ХЭДСангийн төсөл хөтөлбөрт тавигдах шаардлагын дагуу ЖДҮ эрхлэгч,ахуйн үйлчилгээ, хоршоо, нөхөрлөлийг мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх, хоршоо, нөхөрлөл олгох байгуулах үйл ажиллагаа явуулахад, төсөл бичих, хэрэгжүүлэх зэрэгт туслах сургалт сурталчилгаа явуулахыг заавал тавигдах шаардлагад оруулсанаар аж ахуйн нэгж, хувь хүмүүс сургалтын ач холбогдол бизнесээ өргөжүүлэх шинэ техник технологийг судлах, инноваци, маркетингийг ашиглах болсон нь чухал ач холбогдолтой. | | |
| 51 | | Зээлд хамрагдсан иргэдээс ЖДҮ-ийг дэмжих төвд ажлын байраар хангах асуудлыг ЗДТГ, дэмжих төвтэй хамтран шийдүүлнэ. | ХХ | 90% |
| | | 2013 онд Жижиг, дунд үйлдвэрийн хөнгөлөлттэй зээлд шалгарсан "Эл Жей Би Ди" ХХК, 2014 оны Жижиг, дунд үйлдвэрийн зээлд шалгарсан иргэн Д.Наранцэцэг, С.Уранчимэг, "Хайрын шаглаа" ХХК нь дүүргийн ЖДҮДТ-д ажлын байртай болоход зуучлан ажилласан. | | |
| 52 | | ЖДҮ эрхлэгчдийн бүртгэлийг ангилж, мэдээллийн санг баяжуулна. | ХҮХ, ХХ | 100% |
| | | Дүүргийн хэмжээнд жижиг, дунд үйлдвэр, ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч байгууллага, аж ахуйн нэгжүүдийн бүртгэлийг нэгтгэж, мэдээллийн сан үүсгэж байна.<br>2014 оны ахуйн үйлчилгээний 559 цэг, үйлдвэрийн 155, өрхийн үйлдвэрлэл эрхлэгч 305 ААН, иргэнийг нийт 1019 үйлдвэрлэл, үйлчилгээний газруудыг дүүргийн бүртгэл мэдээллийн санд бүртгэсэн.<br>2014.04.21-нд Улсын бүртгэлийн ерөнхий газарт явуулсан Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчийн тусгай тэмдэглэгээтэй 145 аж ахуй нэгж, 2014 оны Татварын хэлтэст бүртгэлтэй, Жижиг, дунд үйлдвэрлэгчийн гэрчилгээтэй 6 иргэнийг | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | мэдээллийн санд бүртгэсэн. Мэдээллийн санг шинээр баяжуулах зорилгоор ХҮХ, ЖДҮДТ-тэй хамтран 2014 оны 10 сарын 16-нд дүүргийн 20 хорооны 180 гаруй хэсгийн ахлагч нарт судалгааг авах аргачлалыг зааж, нэгтгэлийг 12 сард багтаан эцэслэхээр шийдвэрлэн ажиллаж байна. | | |
| 53 | | ЖДҮ эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулах байнгын цэг ажиллуулж, гадаад дотоодын үзэсгэлэн худалдаанд гаргана. | ХХ | 100% |
| | | 2014.04.17-нд 2013 оны Жижиг, дунд үйлдвэрийн зээлд хамрагдсан “ВВСЕО”ХХК, ЖДҮДТ-д бойжиж буй үйлдвэрлэл эрхлэгч Ё.Бадруушийн хамт С1 телевизийн “Яг одоо” шууд нэвтрүүлэгт оролцуулсан.<br>6 сард “Olloo” телевизийн мэдээний албаны сэтгүүлч н.Чаминцэцэгтэй хамтран Дүүргийн үйлдвэрлэгчдийг мэдээллийн цагаар оролцуулах болж, 1-р ээлжинд “Дорнын эсгий”ххк-н захирал А.Баасансүрэн, 2-р ээлжинд 2013 оны хөнгөлөлттэй зээлд хамрагдсан “ВВСЕО” ХХК, 3-р ээлжинд Монголын урчуудын эвлэлд “Шахмал хүүхэлдэй” –н чиглэлээр үйлдвэр эрхлэгч Д.Доржхорлоог оролцуулсан.<br>2014.07.01-нд 2013 оны Жижиг, дунд үйлдвэрийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэн, аж ахуй нэгжийг олон нийтэд таниулах зорилгоор иргэн Д.Бямбасүрэнгийн тавилгын үйлдвэрлэлийг сонгон ETV, Айст монголиа, С1, МИ25 телевизийн мэдээллийн цагаар оролцуулсан.<br>2014.07.04-05-ны хооронд МҮЭСТО-нд болсон “Сүхбаатар дүүргийн үйлдвэрлэл эрхлэгчдийн үзэсгэлэн худалдаа”-нд зохион байгуулагчаар ажилласан.<br>2014.04.23-24-нд “Чингисийн талбай”-д зохион байгуулагдсан “Хөдөлмөрийн салбарын 7 хоног”-ийн арга хэмжээнд хүнну дээлний чиглэлээр н.Батнаран, эсгий эдлэлийг чиглэлээр А.Баасансүрэн, арьсан гутал үйлдвэрлэгч Р.Одгэрэл, туг далбаа оёдог Н.Манлайбаатар, загварын дээл үйлдвэрлэгч н.Ганбат, бэлэг дурсгал үйлдвэрлэгч Ё.Бадрууш, зөгийн бал, варень үйлдвэрлэгч Г.Эрдэнэтуяа нарын бүтээлийг үзэсгэлэн худалдаанд оролцуулсан.<br>Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвөөс зохион байгуулж буй “Алтанбулагийн худалдааны цэг”-т бүтээгдэхүүнээ борлуулах саналтай 6 аж ахуй нэгж, 2 иргэнийг бүртгэсэн.<br>2014 оны 10 сарын 25-ны өдөр Чингисийн талбайд зохион байгуулагдсан “Дүүргийн хөгжилд-Иргэний оролцоо” өдөрлөгт дараахи үйлдвэрлэл эрхлэгчдийг оролцуулсан. Үүнд: Г.Тунгалаг “Хүрэм, дээл", Д.Баярхуяг “Бэлэг, дурсгал, үнэт эдлэл”, Д.Доржхорол “Бэлэг дурсгал, хүүхэлдэй, морь”, И.Энхтуяа “Сүлжмэл эдлэл”, “Сувд бадмаараг” ХХК “Ноос, ноолууран оймс, ширэн улавч”, 2013 оны Жижиг, дунд үйлдвэрийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан “Эл Жэй Би Ди” ХХК “Савхин бээлий”.<br>Нийслэлийн ЖДҮДТ-өөс зохион байгуулж буй “Улаанбаатарт үйлдвэрлэв-2014” үзэсгэлэнд худалдаа 11 сарын 21-23-нд зохион байгуулагдахтай холбоотой дүүргийн үйлдвэрлэл эрхлэгчдэд мэдээлэл хүргэн ажилласан. | | |
| 54 | | Инноваци, гаалийн нэмүү өртгийн албан татвараас чөлөөлөгдсөн тоног төхөөрөмж болон шинэ техник технологийн мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлнэ | ХХ | 100% |
| | | Монгол улсын Засгийн газрын 2012 оны 193 дугаар тогтоолын дагуу ГАТ болон НӨАТ-аас чөлөөлөгдсөн Жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг 2014 онд Хөдөлмөрийн хэлтсээс тодорхойлолт авсан 3 байгууллага, дэд комиссоос дэмжигдсэн 1 аж ахуйн нэгж гаалийн хилээр нэвтрүүлсэн байна.<br>Тогтоолын хугацаа сунгагдсантай холбоотой Монгол улсын Засгийн газрын 2014 оны 06 сарын 14-ний өдөр батлагдсан 191 дугаар тогтоолыг иргэн, аж ахуй нэгжид танилцуулан, мэдээлэл хүргэн ажиллаж байна. | | |
| 55 | | Бизнесийн санаагаа хөгжүүлэх, бизнес төлөвлөгөө боловсруулах арга зүйг эзэмшүүлэх, бүтээгдэхүүн | ХҮХ | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | үйлдвэрлэлээ удирдах арга барил, тогтвортой авч явах чадвар эзэмшүүлнэ. | | |
| | | Дүүргийн Хөдөлмөрийн хэлтэстэй хамтран жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөнгөлөлттэй зээлд хамрагдахад тавигдах шаардлага, зээлийн батлан даалтын санд хэрхэн хамрагдах, төсөл бичих талаар 2 удаа сургалт зохион байгуулж, 130 гаруй жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг;<br>• Нийслэлийн ЖДҮ-г дэмжих төвтэй хамтран Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Бизнесээ эхэл, бизнесээ хөгжүүл” 3 өдрийн сертификаттай сургалтанд анхлан үйлдвэр эрхлэгч нийт 75 иргэнийг;<br>• БНХАУ-ын Эрээн хотод зохион байгуулагдсан модон эдлэлийн үйлдвэр эрхлэгчдийг дадлагажуулах 7 хоногийн сургалтанд Мятав ХХК, Интер стиль ХХК зэрэг модон эдлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 4 үйлдвэрлэл эрхлэгчдийг тус тус хамруулж, нийт давхардсан тоогоор 120 гаруй бизнес эрхлэгчийг сургаж, мэдлэг мэргэжлийг дээшлүүлэн, чадваржууллаа.<br>Үндэсний үйлдвэрлэлийг дэмжин, импортын бүтээгдэхүүнийг орлох чадвартай дотоодын бүтээгдэхүүнийг сурталчлах “Хорека–Улаанбаатар-2014”, Олон улсын “Жижиг, дунд үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ технологи-2014”, “Улаанбаатар түншлэл”, “Улаанбаатарт үйлдвэрлэв-2014” зэрэг үзэсгэлэн яармагуудад ноос, ноолуур, арьс шир, аяны хөнжил, бэлэг дурсгалын чиглэлээр үйлдвэрлэл эрхлэгч 100 гаруй ААНБ, иргэнийг хамруулж, борлуулалтын орлогыг нэмэгдүүлсэн.<br>Нийслэлийн ЖДҮ-г дэмжих төв, БНХАУ-н Эрээн хотын Засаг захиргаа, Олон Улсын дээд сургуультай хамтран үйлдвэрлэл эрхлэгчдийн дадлага сургалтыг зохион байгуулах гэрээний дагуу нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа модон эдлэл үйлдвэрлэгчдийг шилдэг техник, технологитой танилцуулах дадлага сургалтанд 4 иргэнийг хамруулж, дадлагажуулсан.<br>Хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгтэй хамтран “Хэрэглэгчийн өдөр”-ийг угтан ”Хэрэглэгчдийн таашаалд нийцсэн бүтээгдэхүүн“ шалгаруулах нийслэлийн шалгаруулалтанд Өгөөж чихэр боов ХХК, /Нэрс шанзтай Өнхрүүш” боов/, Аз хур ХХК /Монголын нууц товчоо/, Жин туул ХХК /Цэцэгт боов/, иргэн Б. Ганбат /Зүү ороож хатгасан дээл/, иргэн Б.Цамба / Жуулчдад зориулсан эмээл/ зэргийг нэр дэвшүүлснээс Өгөөж чихэр боов ХХК-ийн “Нэрс шанзтай Өнхрүүш” боов нь “Нийслэлийн хэрэглэгчдийн таашаалд нийцсэн бүтээгдэхүүн”-ээр шалгарсан.<br>Дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс, Хөдөлмөрийн хэлтэстэй хамтран хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны талаар үйлдвэрлэл эрхлэгчдэд сургалт явуулж, шинээр вакум цонх, блок, сүлжмэл оёдлын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч 30 гаруй иргэд хамруулсан.<br>• Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих ажлын хүрээнд гэр бүлийн харилцаа, хүүхдийн хүмүүжлийн талаар мэдлэг олгох, гэр бүлийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлт, өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд нь туслах зорилгоор өрхийн хөгжлийн төлөвлөгөө, өрхийн төсөв зөв боловсруулж сурах, өрхийн аж ахуй эрхлэх ур чадварыг эзэмшүүлэх сургалтанд нийт 185 иргэнийг;<br>• Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2013-2014 оны Улсын хэлэлцээр, Монгол Улсын Засгийн газрын 370 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх нийгмийн түншлэгч талууд, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор Нийгмийн түншлэл-баялаг бүтээгчдийн анхдугаар чуулганы дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хэлтэс, Ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэлтэй хамтран худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрлэлийн салбарын 280 гаруй байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг оролцуулсан. | | |
| 56 | 3.2.2 Сүхбаатар дүүрэгт жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх зээлийн санг | Нийслэлтэй хамтран хуваарилагдаж ирсэн зээлийг олон нийтэд ил тод сурталчлан мэдээлж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулна. | ХХ | 100% |
| | | 2014 оны 07 сарын 03-25-ны хооронд төсөл хүлээн авах зарыг дүүргийн 20 хороод, Хэлтсийн цахим хаягт байрлуулсан. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | нэмэгдүүлэн зээлийн хэмжээ, хугацаа, нөхцлийг сайжруулан үргэлжлүүлэн олгоно | ETV, ZA, TV10, Eagle, MN25, Монгол HD, TM, Olloo, Эко like телевизүүдээр төслийн зар, мэдээллийг явуулан ажилласан.<br>Жижиг, дунд үйлдвэрийн зээлийн мэдээллийг 104 иргэнд хүргэсэн. 2014 онд Сүхбаатар дүүрэгт 1.000.000.000 төгрөг хуваарилагдсан. Тус хэлтэст нийт 3.868.113.000 төгрөгийн санхүүжилт бүхий 59 төсөл ирсэн. Хөдөлмөрийн сайдын 2013 оны 03 сарын 19-ний өдрийн А/44 дүгээр журам, Хөдөлмөрийн сайдын 2014 оны 05 сарын 27-ны өдрийн 118 дугаар тушаалыг үндэслэн, дэд комиссын шийдвэрээр 20 төсөл шалгарсан. | | |
| 57 | | ЖДҮ-ийн тэргүүлэх салбарыг батлуулж, түүнд чиглэсэн зээл олгоно. | ХХ | 100% |
| | | Тэргүүлэх салбараар оёдлын салбар батлагдсан бөгөөд оёдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 6 иргэн, аж ахуй нэгж ЖДҮХСангийн хөнгөлөлттэй зээл авахаар дэд комиссоос батлагдсан байна. | | |
| | | ***3.3. Сургууль, цэцэрлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр:*** | | |
| 58 | 3.3.1 Улсын болон хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих замаар Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийг нэмэгдүүлэн хичээллэх ээлжийн тоог бууруулж, анги дүүргэлтийн стандартыг мөрдүүлнэ. | 3,11 дүгээр сургуулийн барилгын ажлыг эхлүүлнэ. | НХХ | 100% |
| | | 3-р сургуулийн 3 давхрын цутгалтын ажил дууcч, өрлөгийн ажил дуусах шатандаа ажлын явц 80% тай байна.<br>11-р сургуулийн барилгын тендер 2014.08.29-ны өдөр зарлагдаж, Фужи Алтай, Чойр Хайрхан ХХК шалгарч, гэрээ хийгдлээ. | | |
| 59 | | Цэцэрлэгийн өргөтгөл барих замаар орны тоог нэмэгдүүлнэ. | НХХ | 100% |
| | | 42-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилгыг ашиглалтанд хүлээн авч, үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.<br>Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 69-р цэцэрлэгт 8 бүлэгтэй, 240 хүүхдийн хүчин чадалтай барилгын гүйцэтгэгчээр “Бэлтэ “ХХК ажиллаж, барилгын ажил 2 давхрын цутгалтын шатандаа байна. | | |
| 60 | | Хуучин цэцэрлэгийн барилгын ашиглалтанд дүгнэлт гаргуулан, шинээр барих хөрөнгийг шийдүүлнэ. | НХХ | 100% |
| | | 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт 75 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажил газар чөлөөлөх шатандаа явагдаж байна.<br>16-р хороонд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 240 хүүхдийн хүчин чадалтай 8 бүлэгтэй, 2 давхар цэцэрлэгийн барилгын тендер зарлагдаж Чойсамбуу ХХК шалгарч барилгын ажил дууcч хүлээлгэж өгөхөд бэлэн болоод байна. | | |
| 61 | | Дэлхийн банкны хөрөнгө оруулалтаар барьж байгаа цэцэрлэгүүдийн үйл ажиллагааг эхлүүлнэ. | НХХ, БХ | 100% |
| | | **Улсын төсвийн хөрөнгө оруулалт:** 3 ба 11 дүгээр сургуулийн барилгыг шинээр барих, 109 дүгээр цэцэрлэгийн өргөтгөл ба 13-р хороонд 75 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилгын газрын асуудлыг шийдвэрлээд байна.<br>**Нийслэлийн хөрөнгө оруулалт:** 9-р хороонд бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор, 7-р хороонд бага сургуулийн болон 2 дугаар сургуулийн барилгын өргөтгөлийн барилгын ажилд нийт 6.400,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.<br>**Дэлхийн банкны хөрөнгө оруулалт:**<br>8-р хорооны 42-р цэцэрлэгийн 100 хүүхдийн хүчин чадалтай өргөтгөлийн барилга, 130-р цэцэрлэгийн 100 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилга шинээр ашиглалтанд орж 200 хүүхэд СӨБ-д хамрууллаа.17-р хорооны 205-р цэцэрлэгийн 100 хүүхдийн хүчин чадалтай барилгын ажил 90%-тай явагдаж байна. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 69-р цэцэрлэгийн 8 бүлэгтэй, 240 хүүхдийн хүчин чадалтай 2 давхар өргөтгөлийн суурийн ажил эхэлсэн<br>**Дүүргийн хөрөнгө оруулалтаар**<br>1,68,69 –р цэцэрлэгийн сантехникийн их засвар 3,4,16,35,45-р сургуулиуд болон 2, 14, 17, 40, 69-р цэцэрлэгийн ариун | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | цэврийн өрөөний их засварын ажил хийгдэж 69-р цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 16-р хороонд шинээр барих цэцэрлэгийн газрын асуудлыг тус тус шийдвэрлүүлсэн байна<br>14-р цэцэрлэгт гал тогооны тоног төхөөрөмж, 16,45,58-р сургуулиудад Сурагчийн чийрэгжүүлэлт, бялдаржуулалтын төвийн тохижилтын ажил<br>• **Төрийн** өмчийн 2.4.6.16.31.35.45.58.71 дүгээр сургуульд тус бүр нь 26 сая төгрөгийн өртөг бүхий эрэгтэй технологийн кабинетын тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн нийлүүлэгдэж, сурагчдын суралцах орчин нөхцлийг сайжрууллаа.<br>• Төрийн өмчийн 27цэцэрлэгт зөөлөн эдлэл, 4-р сургуулийн сагсан бөмбөгийн талбай, 2,11-р сургууль ба 135-р цэцэрлэгийн орчинд хурд сааруулагч тавих зэрэг бүтээн байгуулалтын болон сургалтын орчинг сайжруулах зэрэг дээрх ажилд нийт 3,793,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн байна.<br>• Боловсролыг дэмжих Олон Улсын Түншлэлийн сургуулийн өмнөх боловсрол төслийн хүрээнд 16-р хорооны нутаг дэвсгэр /130-р цэцэрлэг/ дээр иж бүрэн тавилга, тоног төхөөрөмж бүхий 100 хүүхдийн хүчин чадалтай /Канад модон байшин/ цэцэрлэгийн барилгыг ашиглалтанд хүлээн авлаа.<br>• 17, 20-р хорооны цэцэрлэгийн барилгын ажил 80%-тай байна. | | |
| 62 | | Цэцэрлэг бага сургуулийн цогцолборуудыг барих ажлыг эхлүүлэх арга хэмжээг авна. | ЭЗТХ | 100% |
| | | Дүүргийн 16 дугаар хороонд 240 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг барих ажлыг “Алтанбулаг трейд” ХХК, дүүргийн 17 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилгын болон суурийн холболтын зураг, төсөв боловсруулах ажлыг Төсөв төсөл ХХК, Набсан ХХК-ийн түшлэл, Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороо бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга барих ажлыг “Бэрэн” ХХК гүйцэтгэж байна.<br>Мөн 2015 онд Улс, нийслэлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр 54, 135, 109, 1-р цэцэрлэгүүдийн хуучин блокыг буулган шинээр барих, 8, 18, 19-р хороонд шинээр цэцэрлэг барих, 9, 12, 13-р хороонд сургууль, цэцэрлэгийн цогцолбор барих газрын байршлыг сонгон төлөвлөлтөнд оруулаад байна. | | |
| 63 | 3.3.2. Албан байгууллагуудын дэргэд болон гэр цэцэрлэг байгуулахыг дэмжинэ. | Хүүхэд харах үйлчилгээ, алслагдсан гэр хороололд цэцэрлэгийн салбар бүлэг байгуулах иргэд аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллана. | НХХ | 100% |
| | | Хувийн цэцэрлэг байгуулахыг хүссэн 7 иргэнд холбогдох бичиг баримт бүрдүүлэх, талаар зөвлөмж өгсөн.<br>Хотын төвөөс 18 км алслагдсан бүсэд буюу 20 дугаар хороонд 232 хүүхдийн багтаамжтай Цасангоо цэцэрлэг нээгдлээ. | | |
| 64 | 3.3.3. Эх оронч сэтгэлгээ, ёс суртахуун-тай иргэнийг төлөвшүү-лэх чиглэсэн “ Зөв Монгол Хүүхэд” төлөв-лөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ. | Боловсролын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ. | БХ | 100% |
| | | “Зөв Монгол хүүхэд“ бэлтгэх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор 1-5 дугаар ангийн 15000 сурагчид ,багш, эцэг эхчүүдэд “Сурагчдын хөгжил төлөвшлийн үнэлгээ”- г дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 132 дугаар тогтоолоор төрийн болон төрийн бус өмчийн сургуулиудад хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, дүүргийн ЗДТГ-аас 12 000 000 сая төгрөгийн санхүүжилтын дэмжлэг авч шинэчлэн боловсруулж туршин хэрэгжүүлж байна.<br>• Зөв Монгол хүүхэд” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн эрчимжүүлэх ажлыг СОССА33-ийн үйл ажиллагааны хүрээнд 3 багаар хэрэгжүүлж улирал бүр тайлангийн хурал хуралдуулж үр дүнд шинжилгээ хийж ажиллаж байна.<br>• -Боловсролын үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Ном” . “Авъяас”, “Багшийн хөгжил” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх 2014-2015 оны хичээлийн жилд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, сургууль цэцэрлэгүүдэд хэрэгжүүлж байна.<br>• Дүүргийн хэмжээнд НХХ-тэй хамтран “Бидний авъяас-2014” урлагийн их наадам зохион байгуулах удирдамжийг | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 65 | | Засаг даргын 2014 оны 11 сарын 18 ны өдрийн А/503 тоот захирамжаар баталж, зохион байгуулах үйл ажиллагаанд нийт 20 сургууль, 22 цэцэрлэг 7 төрлийн номинацаар оролцож, 31413000 төгрөгийг зарцуулсан байна.<br>• Ном хөтөлбөрийн хүрээнд ЕБС-ийн 1-5 дугаар ангийн сурагчдын унших, бичих, сэтгэн бодох , бие даан суралцах чадварыг дээшлүүлэх зорилгоор төрийн өмчийн сургуулиудад ангийн номын сан, сургуулийн номын санд баяжилт хийх зорилгоор номын багц хүргэсэн.<br>• Ангийн номын санд 1 анги-18, 2 анги-22, 3 анги-31, 4 анги-32, 5 анги-36 нэр төрөл бүхий номоор сургуулийн номын санг баяжуулсан байна. | | |
| 65 | | Сургалтын гадаад дотоод орчны стандартыг сайжруулна. | БХ | 100% |
| | | Хүүхдийн сурч боловсрох орчныг сайжруулах зорилгоор: сургууль цэцэрлэгүүдийн гадна, дотор талд дараахи ажлуудыг хийж гйүцэтгэж байна. Үүнд:<br>**Ариун цэврийн өрөөний засвар**<br>- 3, 4 /4-р сургуулийн 3-р давхрын ариун цэврийн өрөө /, 16, 35, 45-р сургуулиуд, 2, 14, 17, 40, 69-р цэцэрлэгүүдийн ариун цэврийн өрөөнд засвар хийж 45,929.1-76,400.0 мянган төгрөгийн зарцуулсан байна.<br>- МЭХСургууль “Хурган Мөнх” ХХК-ийн газар ашигласны нөхөн төлбөрөөр 5 нойл засуулж, гадна фасад, ногоон байгууламж хийлгэсэн. 4 анги, урлагын заалны шалыг шинээр хулдааслуулсан байна.<br>**Дотор талын нийтийн эзэмшлийн газрын тохижилт**<br>- 2014 оны урсгал засварын зардлаар бүх цэцэрлэг, сургуулиуд нийтийн эзэмшлийн газарт засвар хийж 12,627.4-105,957.5 мянган төгрөгийг зарцуулжээ.<br>**Гадна талын орчны тохижилт**<br>- Дүүргийн хөрөнгө оруулалтаар 4-р сургуулийн дэргэд сагсан бөмбөгийн талбай байгуулахад 67,220.9 мянган төгрөгийг, гадна талын фасад засварлахад 50,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулан хийж байна.<br>**Дүүргийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар:**<br>- 1, 68, 69 дүгээр цэцэрлэгүүдийн сантехникт их засвар хийж 23,430.5-51876.7 мянган төгрөг зарцуулж ажлыг бүрэн гүйцэтгэж дууссан.<br>**Улсын төсөв, Дэлхийн банкны хөрөнгө оруулалтаар**<br>- Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29-р, Харааны бэрхшээлтэй хүүхдийн 116 дугаар тусгай сургуулиудын сантехникт 37.9-126.0 сая төгрөгөөр, 25, 31-р сургуулиудын дээвэр, цонхонд тус бүр 90.0 сая төгрөгөөр, 31-р сургуулийн урлаг зааланд 117.4 сая төгрөгөөр тус тус их засвар хийж гүйцэтгэж байна. 25-р сургуулийн засвараас бусад засварын ажил 20-100 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна.<br>- 42-р цэцэрлэгийн өргөтгөлийн сургалтын тоног төхөөрөмж, зөөлөн эдлэл Дэлхийн банкнаас бэлтгэгдэж байна. Үүнд: компьютер 10ш, угаалгын машин 2ш, тоос сорогч 2ш, проектор 1ш, 100 хүүхдийн зөөлөн эдлэл, 4 ангийн хэвсэнцэр бэлтгэгдсэн байна.<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулиудын үйл ажиллагааг дэмжиж ажиллана.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд амжилттай сургаж буй сургууль, багшийн туршлагыг түгээн дэлгэрүүлэх сурталчлах ажлыг зохион байгуулж дүүргийн “Бүтээлч багшийн зөвлөгөөн”-ний үеэр алдаршуулан шагнаж урамшуулахаар бэлтгэж байна. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 66 | | Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэн төлөвшүүлэхэд онцгой амжилт гарган ажиллаж байгаа багш, удирдах ажилтанг урамшуулна. | БХ | 100% |
| | | Нийслэлийн хэмжээнд зохион байгуулсан Сургалтын чанар, хүртээмжийн үр дүнгийн индексийн үнэлгээгээр Боловсролын хэлтэс гаргасан ажлын үзүүлэлтээрээ бусад дүүргээ түүчээлэн НЭГДҮГЭЭР БАЙР эзэлж 10 сая төгрөгөөр шагнагдлаа. Энэ нь хэлтсийн хамт олны идэхи зүтгэл, дүүргийн удирдлагуудын зүгээс боловсролын салбарт оруулж буй дээр дурьдсан хөрөнгө оруулалт, хамтын ажиллагаа хийгээд дараах сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа, багш нарын гаргасан амжилт бүтээлтэй холбоотой юм. Тухайлбал: Сургалтын чанар, хүртээмжийн үр дүнгийн индексийн үнэлгээгээр 2014 онд дүүргийн 135,25,40, Хөгжил цэцэрлэг, 1 ба 2 дугаар сургуулиуд шалгарч тус бүр 5-10 сая төгрөгөөр , бага ангийн 10 багш, сургуулийн өмнөх боловсролын 8 багш, суурь болон бүрэн дунд боловсролын 14 багшийг 1-3,8 сая хүртэл төгрөгөөр тус тус шагнагдсан байна.<br>2014 онд багш нарын 48 дэх өдрөөр мэргэжил боловсролоо дээшлүүлж, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх үйл хэрэг, багшлах ажилдаа амжилт гарган ажиллаж буй сургууль, цэцэрлэгийн 25 “Багшийн сайн туршлага”, 19 “Бүтээлч багш” нарыг шалгаруулан сурталчилж дүүргийн “Хүндэт тэмдэг” болон “Хөдөлмөрийн алдар” медалиар шагнаж, урамшууллаа. Энэ үеэр МУ-ын Засгийн газрын шагнал “Ардын боловсролын тэргүүний ажилтан” цол тэмдгээр 39 багш, БШУЯ-ны “Жуух бичиг”- ээр 55 багш, Нийслэлийн Боловсролын газрын шагналаар нийт 192 багш шагнагдаж 39 багшийг төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор, 41 багшийг “Хөдөлмөрийн хүндэт” медалиар тус тус шагнуулахаар дэмжин тодорхойлсон байна. 2014 оны үйл ажиллагаагаар 71 болон “Сант” сургууль дүүргийн тэргүүний сургууль, 160 болон “Хөгжил” цэцэрлэг дүүргийн тэргүүний цэцэрлэгүүдээр, 11-р сургуулийн захирал Д.Энхжаргал, 160 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Цэрэндолгор нар тэргүүний удирдах ажилтнаар тус тус шалгарлаа. | | |
| 67 | | Сургууль-олон нийтийн хамтын ажиллагааг сайжруулна. | БХ | 100% |
| | | Сургууль-олон нийтийн хамтын ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд олон улсын жишигт тулгуурлан “Багш-Эцэг эхийн хамтын ажиллагааны зөвлөмж” боловсруулан хэлтсийн даргын албан даалгавраа нийт сургуулиудад хэрэгжүүлж эхлээд байна. Сургууль-олон нийтийн хамтын ажиллаагааны талаар удирдах ажилтан болон 35,58,71-р сургуулийн эцэг эхчүүдэд “Танай хүүхэд аль нь вэ?” сургалт, бага боловсролын цөм хөтөлбөрийн хүрээнд “Зочин багш” хэлбэрээр цуврал сургалтын хуваарь гарган хэрэгжүүлж байна. Дүүргийн Засаг даргын 2014 оны 05 сарын 29-ний өдрийн 235 тоот захирамжын дагуу 1000 цэцэгчин Эко ээж практик цуврал сургалт зохион байгуулан Боловсролын хэлтсээс Цээнийн төгөл ТББ-тай хамтран ажиллах гэрээ байгууллаа. Энэхүү ажлын хүрээнд 1,2, 3, 4, 6, 11, 31, 35, 45, 58, 71 –р сургуулийн сурагчдын 1000 ээжид ногоон байгууламж хийх, ногоон орчин бүрдүүлэх, тасалгааны цэцэг тарих, сургууль орчинд эко орчин бүрдүүлэх ажлыг хийж гүйцэтгэлээ. Гадаад хамтын ажиллагаа: АНУ дахь Олон улсын боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг болон Засаг дарга, дүүргийн Боловсролын хэлтсийн хооронд хүүхэд ба багш нэг бүрийг хөгжүүлэх хамтын ажиллагаа тогтоон тус нийгэмлэгээс Монголд зохион байгуулсан удирдах ажилтны сургалтыг хамтран зохион байгуулж, боловсролын удирдах ажилтныг дэлхий нийтийн чиг хандлагатай танилцууллаа.Япон улсын Саппоро хотын дунд сургууль, цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагааны туршлага судлах хөтөлбөрт дүүргийн 1, 3, 11, МЭХС ийн 6 багш, удирдах ажилтан, 14, 42, 69, 171, 175 –р цэцэрлэгийн эрхлэгч нарыг хамруулаа. Өсвөр үеийнхний ном унших сонирхлыг дэмжих, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх зорилгын хүрээнд АНУ-ын 4-н Хүүхдийн байгууллагын Монгол дахь салбар Монголын 4-Н хүүхэд залуучуудын байгууллага, Америкийн соёлын мэдээллийн төвтэй хамтран АНУ-ын ерөнхийлөгч Барак Обамагийн "Та нартаа дуулья“ номын дагуу 1-11 | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | ангийн сурагчдын дунд уралдаан зохион байгууллаа | | |
| 68 | | Боловсролын чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. | БХ | 100% |
| | | Элсэлт: 2014-2015 оны хичээлийн жилд 1дүгээр ангийн 132 бүлэгт 4003 сурагч шинээр элсэн суралцаж байгаа бөгөөд сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан 3717 хүүхэд байгаа нь сургуульд элсэн орсон хүүхдийн 92,8% - ыг эзэлж байна.<br>Төгсөлт: 2013-2014 оны хичээлийн жилд Сүхбаатар дүүргийн ерөнхий боловсролын 51 сургуулийн 3044 сурагчид суурь боловсролын гэрчилгээг, 2876 сурагчид бүрэн дунд боловсролын үнэмлэх тус тус олгосон байна.<br>Сургууль завсардалт: Хүүхдийг сургууль завсардалтаас урьдчилан сэргийлэх, иргэдийн бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэхэд анхаарч дүүргийн насан туршийн Гэгээрэлд хөгжлийн төв, хороодтой хамтарсан судалгаагаар нийт 7-32 насны 28 хүүхэд ба насанд хүрэгчдийг илрүүлж, сургууль завсардалт, бичиг үсгийн боловсролд хамруулах ажлыг холбогдох байгууллага, удирдлагатай хамтран ажиллаж байна. Зайн сургалтад 14 суралцагчийг хамруулсан байна.<br>2014-2015 оны хичээлийн жилд гурван ээлжээр хичээллэж буй 71,35.71 дугаар сургуулийн сургалтад ээлжийн тоог багасгах боломжийг судлан зарим зохион байгуулалт хийснээр гуравдугаар ээлжинд 10 бүлэгт 336 сурагч суралцаж байна.<br><br>• Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин 98%<br>• 1 дүгээр ангид элсэн ороод 5 дугаар анги хүртэл суралцагчдын хувь 72%<br>• Насан туршийн боловсролын хүрээнд 15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалтын хувь 86 % байна.<br>• СӨБ-ын хамрагдалт өмнөх оныхоос 2%-иар нэмэгдэж, 73,8%-тай байна. | | |
| 69 | 3.3.4. Хотын соёлыг төлөвшүүлэх асуудлыг ерөнхий боловсролын хөтөлбөрт тусгах ба иргэдэд хэвшүүлэх ажлыг зохион байгуулна. | Оюутан болж ирсэн хөдөөний залууст хотын соёлд суралцах, гэмт хэрэг, бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх сургалтыг нутаг дэвсгэрийн их дээд сургуулиудтай хамтран зохион байгуулна. | ЦХ<br>НХХ | 100% |
| | | Цагдаагийн хэлтсээс дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, оюун ухаан, авхаалж самбааг сорих, соёл ухамсарыг төлөвшүүлэх, хууль сурталчлах зорилгоор хариуцсан нутаг дэвсгэрт байрлах 11 сургууль, Үйлдвэр урлалын дээд сургуулийн нийт 480 оюутан, сурагчдын дунд танин мэдэхүйн “АХА” сургалт-тэмцээнийг сургууль тус бүр дээр 2014 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс 03 дугаар сарын 18-ны өдрийн хооронд амжилттай зохион байгуулсан.<br>Тэмцээнд зохион байгуулахад шаардагдах төсвийг Дүүргийн Засаг Даргын Тамгын Газрын Даргын 2014 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/23 тоот тушаалаар 656,000 төгрөгийг гаргуулсан.<br>Насанд хүрээгүй хүмүүс ялангуяа өсвөр насны охидыг бэлгийн мөлжлөгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Охид” арга хэмжээг зохион байгуулж, дүүргийн нийгмийн хөгжлийн хэлтэс, эрүүл мэндийн нэгдэл, ерөнхий боловсролын сургуулийн захиргаа хамтран оролцсон.<br>Арга хэмжээний хүрээнд дүүргийн 9-20-р хорооны нутаг дэвсгэрт 2013 он, 2014 оны эхний 10 сарын байдлаар бэлгийн мөлжлөгт өртөж хохирсон хүүхдүүдийн судалгаа гаргаж, ерөнхий боловсролын 3,4,16,29,35,58,71,119, АЗЭС, Найрамдал, Ертөнц, Галакси зэрэг нийт 12 сургуулийн өсвөр насны 1500 орчим охидын дунд “Бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх”, “Охидын нөхөн үржихүй, бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх”, “Охин | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | насаа хайрлая" сэдвээр сургалт зохион байгуулсан.<br>Мөн хариуцсан нутаг дэвсгэрт байрлах асрамж, халамжийн төвүүд, сүм, хийд, нийтийн байр, Вьетнам засварын газруудад үзлэг, шалгалтыг зохион байгуулж, гэр орноосоо дайжсан, бусдад уруу татагдсан, биеэ үнэлж эрсдэлд орж болзошгүй насанд хүрээгүй охидыг илрүүлэх чиглэлээр ажиллаж, 4 насанд хүрээгүй охиныг илрүүлж, бүртгэл судалгаанд авч, хууль эрх зүйн зөвлөгөө өгсөн.<br>НХХ-ээс Хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, авъяас чадварыг нээн илрүүлж, гоо зүйн мэдрэмжийг дээшлүүлэх, хотын хөгжил дэвшилд хүүхдийн оролцоог нэмэгдүүлэн, хүүхэд өөрийн үзэл бодлоо чөлөөтэй, бүтээлч байдлаар илэрхийлэхийг дэмжих зорилгоор ерөнхий боловсролын сургуулиудын хүүхдүүдийн дунд "Хотын соёл миний нүдээр" гар зургийн уралдааныг 04 дүгээр сарын 29-нд зохион байгуулж, нийт 11 сургуулийн 141 бүтээлээс шалгаруулллаа. Уралдаанд дүүргийн Засаг даргын тамгын газраас нийт 840,000 төгрөг зарцууллаа.<br>Цагдаагийн 2-р хэлтэс, ЭМН-тэй хамтран ЕБС-ийн дунд, ахлах ангийн сурагчдад бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулахаар бэлтгэл хангаад байна. | | |
| 70 | | Ахуйн болон харилцааны соёл, аюулгүй байдлаа хангах үүднээс нийтийн захиргааны дүрэм журмыг дагаж хэвшүүлэхэд дадал болгох арга хэмжээг сургалтын байгууллагуудтай хамтран зохион байгуулна. | НХХ | 100% |
| | | Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төвтэй хамтран тус дүүрэгт нийгмийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын төлөөлөл, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүд, сайн дурын ажилтан, нийгмийн ажилтануудад зориулсан "Гэр бүл- хөгжлийн үндэс" сэдэвт сургалтанд 230 хүн хамрагдаж, хандлагын тухай ойлголт, харилцааны ур чадварын талаар мэдээлэл өгсөн. Гэр бүлийн хөгжлийг дэмжих бүтээлч аяны 4-р сарын 21-нээс 6-р сарын 21 хүртэлх 2 сарын хугацаанд "Ахуйн болон харилцааны соёл" сэдэвт уулзалт, сургалтыг хороо бүр зохион байгуулж, нийт 500 гаруй хүүхэд, залуучуудыг хамрууллаа.<br>Залуучуудын ахуйн болон харилцааны соёл, аюулгүй байдлыг хангах үүднээс Сүхбаатар дүүргийн их дээд 6 сургуулиас нийт 150 оюутанд нийтийн захиргааны дүрэм журмыг дагаж хэвшүүлэхэд дадал болгох сургалтыг зохион байгуулахаар бэлтгэл ажил хангагдаад байна. | | |
| 71 | | Тодорхой сэдвүүдээр хугацаат аян зохион байгуулж, үр дүнг тооцох, хэвшүүлэх арга хэмжээ авна. | НХХ | 100% |
| | | -Дүүргийн Засаг даргын 2014.06.06-ний өдрийн А/247 дугаар захирамжийн дагуу ААНБ, иргэдийн дунд зарласан "Бүх нийтээрээ жингээ хасъя-Таны оролцоо чухал" аянд 9 байгууллага, 6 иргэн материалаа ирүүлснээс дүүрэгт "Golden gym" фитнес клуб, "Их оргилд" клуб, 9-р хороо Д.Тунгалаг, 6-р хороо В.Батнасан, 10-р хороо Б.Цэрмаа, 10-р хороо Э.Гэрэл, 15-р хороо Ё.Цолмон нар шалгарч, дүүргийн Засаг даргын өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнав.<br>-Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, Эрүүл мэндийн нэгдэл, хорооны Засаг даргын ажлын алба, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор "Хороо-өрхийн эрүүл мэндийн төв хамтдаа" аяныг 2014 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 6 сарын хугацаатай зохион байгуулж дүгнэлээ. Уг аяны ажлаараа 14,15,12 дугаар хороо шалгарч,Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.<br>-Эрүүл мэндийг дэмжигч байгууллагаар: 71-р сургууль, 16-р цэцэрлэг, Эрүүл мэндийг дэмжигч өрхөөр: 13-р хорооны Д.Барс, 18-р хорооны С.Нарантуяа, 9-р хорооны Л.Батдорж, Эрүүл мэндээ дэмжигч иргэнээр: 11-р хорооны М.Пүрэвсүрэн, 7-р хорооны Т.Аюуш, 14-р хорооны Д.Наранцэцэг нар шалгарч, дүүргийн Засаг даргын өргөмжлөл, | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | мөнгөн шагналаар шагнагдлаа.<br>-Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн ажлын хүрээнд гэр бүлийг чадавхижуулах, ахуйн болон харилцааны соёлыг хэвшүүлэх, иргэдийн идэвх эрмэлзэл, санал санаачилга, нийгэм дэх бүтээлч оролцоог хөхүүлэн дэмжих, хөдөлмөр эрхлээгүй, ажил сургуульгүй иргэдийг ажилд зуучлан оруулах, түр ажлын байраар хангах, мэргэжил олгох сургалтанд хамруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хороодод амьдардаг нэн ядуу эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх бодит тусламж нэмэгдүүлэх зорилгоор 4 дүгээр сарын 21-нээс 6 дугаар сарын 21 хүртэл 2 сарын хугацаатай болзолт аяны нээлтийн ажиллагаа зохион байгуулж, өдөрлөгт 20 хорооны 1200 гаруй иргэд оролцлоо. Аяны хүрээнд 138 хүнийг ажилд зуучилж, 8 иргэнийг мэргэжлийн сургалтанд хамруулж, 331 хүнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Аяны хугацаанд Монхорус Интернэйшнл ХХК, Сант Асар ХХК, Грийт Импайр ХХК зэрэг байгууллага, аж ахуйн нэгжид 25 ажлын байр шинээр бий болсон ба 1,5 дугаар хороод хувиараа хөдөлмөр эрхэлдэг 22 иргэдийн бүтээлээр үзэсгэлэн гаргалаа. 1-20 хороод давхардсан тоогоор 32 сургалт зохион байгуулж, 460 иргэнийг оролцуулж, мэдлэг мэдээллийг нэмэгдүүлсэн. Мөн “Угийн бичиг хөтлөхийн ач холбогдол” сургалтыг 20 хороо зохион байгуулж, 188 иргэн, хэсгийн ахлагчдыг хамруулсан. | | |
| 72 | | Олон нийтийн телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гэр бүлийн гишүүдэд хөдөлмөрлөх, өөрийгөө хөгжүүлэх амьдралын зөв зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр тогтмол нэвтрүүлэг явуулна. | НХҮХ | 100% |
| | | Кейс менежерийн үйлчилгээ үзүүлэх ажлыг бүх хороонд зохион байгуулж эхэлсэн бөгөөд хороо тус бүрт зохион байгуулсан ажлаараа телевизийн нэвтрүүлэг бэлдэн гаргахаар “ROYAL HD” залуусын телевизтэй хамтран ажиллах гэрээ байгуулан 8 дугаар хорооны хөгжлийн бэрхшээлтэй иргэн Нямдашийн Эрдэнэтуяагийн тухай “Хүний мөр” нэвтрүүлгийн 8 дугаар телевизээр цацагдаад байна.<br>“Итгэл сэтгэл” төсөлд хамрагдаж байгаа зарим иргэдэд зориулсан үзэсгэлэн худалдааг 2014 оны 01 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд “Моннис цамхаг” болон “Моннис бьюлдинг” оффест зохион байгуулсан. Энэ үзэсгэлэнд оролцсон СБД-ийн 11 дүгээр хорооны иргэн уран зураач, лимбэчин, авъяаслаг уран бүтээлч Т.Пүрэвбаатар, 13 дугаар хорооны хөгжлийн бэрхшээлтэй иргэн н.Ариунтуяа нарын бүтээсэн бүтээлийн үзэсгэлэнг МҮОНТ, ROYAL HD залуусын телевиз, ТҮ-9, ТҮ-5, МОНГОЛ HD телевизүүдийн мэдээгээр гаргаж сурталчилсан<br>Дүүргийн нийгмийн хөгжлийн хэлтэс, эрүүл мэндийн нэгдэлтэй хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралын чанарыг сайжруулья” өдөрлөгийг 2014 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгуулсан. Энэ арга хэмжээгээр 10 минутын радио ярилцлага бэлтгэж, нэвтрүүлгээ 2 удаагийн давтамжтайгаар цацсан. FM радиогийн ярилцлагад 1 удаа, телевизийн шууд болон захиалгат нэвтрүүлэгт 3 удаа оролцож, гарын авлага, сурталчилгааны материал тараасан. “Монгол телевиз”-тэй хамтран “Тодруулга” нэвтрүүлгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын хуулийн нэмэлт өөрчлөлт, Ахмад настаны нийгмийн хамгааллын тухай хуулиар мэдээлэл өгч иргэдийг мэдээллээр хангасан Халамжийн хэлтсийн 2014 онд хийж гүйцэтгэсэн ажлын талаарх танилцуулгыг NTV телевизийн тусламжтайгаар баримтат кино хэлбэрээр хийж нээлттэй хаалганы өдрүүд, хороодын зохион байгуулсан арга хэмжээнүүдэд гаргаж иргэдэд байгууллагаа сурталчилсан.<br>Байгууллагын үйл ажиллагааг иргэд олон нийтэд нээлттэй ил тод байлгахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам заавар болон үйлчилгээ авахад шаардлагатай бичиг баримтын жагсаалтыг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулж, салбарын хэмжээнд явагдсан арга хэмжээнүүдийн талаарх мэдээ мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлан нэвтрүүлэх | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | ажлын хүрээнд  доорхи ажлуудыг хийлээ.<br>1.“Роял” телевизтэй хамтран “Урилгагүй зочин” нэвтрүүлэгт  25 минутын  нэвтрүүлэг бэлтгэн  2014 оны 08 дугаар сарын 24, 25, 26 -ны өдрүүдэд давталттайгаар нэвтрүүлсэн.   Уг нэвтрүүлгийг  “Оллоо”, “За” телевизүүдээр дахин дамжуулсан.  Тус нэвтрүүлгээр Сүхбаататар дүүргийн 11-р хорооны хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй иргэдийн ярьж буй санал бодол, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар гаргасан.<br>2.Сүхбаатар дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн дарга Д.Сонгохбаяр  “Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хэрэгжилтийн  талаар  “eagle” телевизийн  Мэдээний зочны цаг шууд нэвтрүүлэгт  оролцсон<br>3. Сүхбаатар дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн Хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа хариуцсан судлаач мэргэжилтэн С.Алтансүх   Монголын үндэсний  олон нийтийн телевизэд “Хүнсний эрхийн бичгийн хэрэгжилт”-ийн талаар ярилцлага өгч, үндэсний телевизийн 18 цагийн мэдээгээр  давталттайгаар цацагдсан.<br>4.Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг иргэдтэй уулзах  уулзалтыг хороо бүрт бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулсан  14,19-р хорооны иргэдтэй  хийсэн уулзалт, иргэдийн  санал хүсэлтийг  “Эко” телевизийн 19 цаг 30 минутын мэдээгээр дамжуулсан.<br>5.“Ханлиг” студитэй хамтран дүүргийн 18-р хорооны хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг иргэн Ц.Санжаагийн гэр бүл болон тус үйлчилгээний талаар ярилцлага авч, нэвтрүүлэг хийсэн. Тус нэвтрүүлгийг 9 сард багтаан 10 телевизээр цацсан.<br>6.Хэлтсийн дарга Д.Сонгохбаяр нь Нийслэл таймс сонины 2014 оны 08 дугаар сарын 28-ны дугаарт  “Эрх нь үүссэн хүн бүр халамжийн үйлчилгээ авах боломжтой” сэдвээр ярилцлага өгсөн.<br>7. Дүүргийн 11-р хорооны хамгийн олон хүүхэдтэй   Даваанямын Энхтөрийн ар гэрээр орж “С-1” телевизийн “Хүүхдийн мөнгө ба цэцэрлэг” нэвтрүүлэгт хүүхдийн мөнгөний талаар ярилцлага өгүүлсэн. Д.Энхтөр нь 0-11 насны 8 хүүхэдтэй өөрөө спортын төв ордонд слесарээр ажилладаг 4 удаагийн төрөлтөөр 8 хүүхэдтэй болсон олон хүүхэдтэй өрх Зохион байгуулсан нэвтрүүлэг, ярилцлага, мэдээллийг  Өөрийн байгууллагын  вэб  сайт, ОЛЛОО.mn , ASSA.mn НЭЭЛТТЭЙ СҮХБААТАР.mn сайтуудад тавьж сурталчилсан. Даваанямын Энхтөрийн гэр бүлд хийсэн “Сайн дурын нийгмийн үйлчилгээ”-гээр “Амьдрах сайхан” телевизийн  4 цуврал нэвтрүүлэг хийсэн.<br>8. Өөрийн байгууллагын мэргэжилтэн Одончимэгийнхээ нийгмийн асуудлыг бүрэн шийдвэрлэсэн. Энэ ажлынхаа талаар ROYAL HD залуусын телевизтэй хамтран “Бид нэг гэр бүл” бүрэн хэмээний баримтат нэвтрүүлэг бэлдсэн. 2014 оны 12 дугаар сард телевизээр цацна. | | |
| 73 | 3.3.5 Үйлдвэр аж ахуйн нэгжид түшиглэсэн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг байгуулна. | Мэргэжлийн сургалт олгох байгууллагуудтай гэрээлэн ажлын байраар хангах сургалтыг зохион байгуулна. | ХХ | 100% |
| | | Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвөөс зохион байгуулж байгаа Үйлдвэр дээрх сургалтын арга хэмжээнд дүүргийн 23 иргэнийг хамруулж сургаж байна. Мэргэжилт олгох сургалтанд 249 иргэнд мэдэгдэл өгч үүнээс 216 иргэн 49 сургалтын төвд суралцаж байна. | | |
| 74 | 3.3.6 Багш нарын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх замаар боловсролын хөгжлийг дэмжинэ. | Сорил, оношлогоо, судалгаа сургалт арга зүйн зөвлөлийн /СОССАЗЗ/ ажлын хүрээнд багш нарыг сургаж хөгжүүлнэ. | НХХ<br>БХ | 100% |
| | | -2014 онд СОССАЗЗ-ийн Явуулын заах аргын зөвлөн туслах багаас зохион байгуулсан 21 төрлөөр 78 удаагийн мэргэжил дээшлүүлэх арга зүйн  сургалтад нийт  2915 багш хамрагдсан байна. | | |

- МУБИС-тай хамтран 7 профессор багшийг урьж боловсролын удирдлагын дэлхийн нийтийн чиг хандлага, хүүхэд бүрийг хөгжүүлэхэд удирдлагын манлайлалыг дээшлүүлэх чиглэлийн сургалтад 110 удирдах ажилтан багш нарыг хамрууллаа.
- Англи хэлний багш нарын мэргэжил боловсролыг дээшлүүлэхэд анхаарч ДЗТГ нь Talk Talk English сургалтын төвтэй гэрээ байгуулан гадаад багштай мэргэжил дээшлүүлэх зуны сургалтыг зохион байгуулж, дүүргийн 13 сургуулийн 64 багш үнэ төлбөргүй 40-60 цагийн сургалтад хамрагдсан байна.

Судлаач багийн ажлын хүрээнд:

-5 настай 2500 хүүхдийг оюуны үйлийн хэв шинжийг тодорхойлох судалгаанд хамруулан оношлох, тоглоомыг оюуны үйлийн хэв шинжээр нь ангилан нас тус бүрийн онцлогт тохирсон тоглоомын хувилбар боловсруулан хөгжүүлэх үйл ажиллагаандаа ашиглаж байна. Бага насны хүүхдийн оюуны үйлийн хэв шинжийг тодорхойлох “Хүүхдийг шинжихүй” гарын авлага боловсруулж, нийтийн хүртээл болголоо.

- СОССАЗЗ-өөс бага ангийн сургалтын хөтөлбөр боловсруулах багш нарын бүтээлч байдлыг дэмжиж 17500000 төгрөгний хөрөнгө оруулалтаар дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн бага ангийн 410 багшид үнэ төлбөргүйгээр түгээн нийтийн хүртээл болголоо.
- Сурагчийнхөгжилтөлөвшлийнүнэлгээ, багшийн ажлыг үнэлж дүгнэх аргазүйн хамаарлын тухай хэлэлцүүлэг зохион байгуулж 280 багш удирдлага, багш, эцэг эхийг оролцуулсан байна.
- Бага ангийн сурагчийн хөгжил төлөвшлийн үнэлгээ хэрэгжүүлэх арга зүйн сургалт зохион байгуулагдсан. Сургалтадтөрийнболонхувийнсургуулийнсекцбүрээс 2 багшбуюу 1-5 дугаарангийн 360 багшхамрагдсан.
- Багшийн сайн туршлага” –ын шалгаруулалтанд 25, 42, 135-р цэцэрлэгийн 3 багшийн ажил шалгаран , туршлагыг түгээн дэлгэрүүлсэн.
- Багш нарын судалгааны арга зүйг дээшлүүлэх ажлын хүрээнд 2014 оны шилдэг илтгэлийн уралдаан “Хичээлийн төлөвлөлт ба хүүхдийн хөгжил” сэдвийн дор явагдаж нийт 5 чиглэлээр ирүүлсэн 57 багш илтгэлийг хэлэлцүүлж, 12 багш, удирдах ажилтны илтгэлийг шалгаруулав. Шалгарсан багш нарын 34 % нийслэлийн уралдаанаас шалгарч улсын уралдаанд оролцох эрх аваад байна.
- Багшийн хөгжил хөтөлбөрийн хүрээнд мэргэжил боловсролоо дээшлүүлж, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх үйл хэрэг, багшлах ажилдаа амжилт гарган ажиллаж буй сургууль, цэцэрлэгийн 25 “Багшийн сайн туршлага”, 19 “Бүтээлч багш” нарыг шалгаруулан сурталчлах ажлыг зохион байгуулсан болно. .

2014-2015 оны хичээлийн шинэ жилд багш нарын мэргэжил боловсролыг дээшлүүлэхэд БМДИ-тэй хамтран 5, 10, 11 дэх жилдээ ажиллаж буй багш нарын хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх арга зүйн сургалтад бүрэн хамруулахаар статистик судалгааг гаргаж байна.

- ЕБС-ийн бага ангийн сургалтад шинэчилсэн цөм хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотой багш нарт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.
- Монголын багш нарын баярыг 10 сарын 5 нд тэмдэглэж болсон энэхүү 48 дахь өдөр , Нийслэл хот

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | байгуулагдсаны 375 жилийн ойг угтаж “Зүрх сэтгэлээ хүүхдэд зориулъя” боловсролын удирдах ажилтан, багш нарын чуулган, бүтээлч багшийн зөвлөгөөн, багшийн сайн туршлага дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах бэлтгэл ажил хийгдэж байна.<br>-Засаг даргын дэргэдэх “ЭМУССОЭСАЗЗЗ”-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэн, зөвлөлийн гишүүд бүрт хуваарийн дагуу ӨЭМТ-ийг хариуцуулан, үйл ажиллагаанд хяналт тавьж, хамтран ажиллаж байна. Өсвөр үе, хүүхэд залуучуудыг эрүүл мэндээ хамгаалах, тэдэнд эрүүл мэндийн чанартай боловсрол эзэмшүүлэх, хүүхэд бүрийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах, суралцах боломж, нөхцөл бүрдүүлэхэд Салбар хоорондын хамтын ажиллагааг чиглүүлэх зорилгоор “Монголын хүүхдийн ордон”-д “ӨСВӨР ҮЕИЙН ЭРҮҮЛ МЭНД БА ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД” сэдэвт зөвлөгөөн зохион байгууллаа.<br>МУ-ын Засгийн газрын боловсролын талаар баримтлах *шинэчлэлийн бодлого чиглэлийг Сүхбаатар дүүргийн* ЗДТГ-ын дэргэд байгуулагдсан Сорил оношлогоо, сургалт судалгаа арга зүйн зөвлөлийн үйл ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлж ирлээ. Тухайлбал, Багшийн мэргэжил боловсролыг дээшлүүлэх чиглэлээр “Явуулын зөвлөн туслах баг, Багшийн бүтээлч үйл ажиллагааг дэмжих, судалгааны арга зүйг эзэмшүүлэх чиглэлээр “Судлаач багш” баг, сурагчдын хөгжил төлөвшлийн асуудал-олон нийтийн оролцооны чиглэлээр “Хүүхэд нэг бүрийн төлөө төлөвшлийг баг” тус бүр тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна. | | |
| 75 | 3.3.7 Дүүргийн номын санг сайжруулан цахимжуулж, хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжих төвийг байгуулна | Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төв байгуулж үйл ажиллагааг жигдрүүлнэ. | НХХ | 100% |
| | | Дүүргийн Засаг даргын 2013 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 402 дугаар захирамжаар “Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төв”-ийг байгуулах, 403 дугаар захирамжаар тус төвийн даргыг томилов. Дүүргийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төв нь нийт 9 хүний орон тоо бүтэцтэйгээр НҮБ-ийн Хабитатын байранд байрлан үйл ажиллагаагаа явуулж байна. | | |
| **3.4. Мэдээлэл, технологийн тэгш хүртээмжийг хөгжүүлэх чиглэлээр:** | | | | |
| 76 | 3.4.1. Дүүргийн гэр хорооллыг интернэтжүүлэх ажлыг эрчимжүүлэхэд хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана. | Гэр хорооллыг интернэтжүүлэхэд хувийн хэвшлийн болон нийслэлийн холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана. | ЗХХ | 100% |
| | | ЖИ-МОБАЙЛ ХХК-тай хамтран гэр хорооллын 10-20 дугаар хороодын айл өрх, иргэдэд NP10 Вайрлес роутер-ийг гэрээ байгуулж зээлийн нөхцөлөөр 1 жилийн хугацаатай үнэгүй нийлүүлсэн. | | |
| 77 | 3.4.2. Гэр хорооллын өрхүүдийг олон сувгийн телевиз үзэх боломжоор хангах тоон системд шилжүүлэхэд шаардагдах арга хэмжээг авна. | Айл өрхүүдийг тоон системийн сувагт шилжүүлэх ажлыг Засгийн газрын болон нийслэлийн холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ. | ЗХХ | 100% |
| | | Нийслэлийн Мэдээллийн Технологийн Газартай тоон системийн сувагт шилжүүлэх ажлыг чиг хүлээн тухайн цагт хэрэгжүүлэн ажиллаж байна. | | |
| 78 | 3.4.3 Дүүргийн айл өрхүүдийг шуудангийн хайрцагаар хангаж, шуудангийн бүхий л | Гэр хороололд шуудангийн салбар байгуулах замаар шуудангийн байгууллагатай хамтран ажиллана. | ЗХХ | 100% |
| | | Дүүргийн Засаг даргын 2014 оны Нийгэм эдийн Засгийн зорилтод тусгагдсан “Гэр хороололд шуудангийн салбар байгуулах замаар шуудангийн байгууллагатай хамтран ажиллана” заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 15-р хороонд байрлах “Хүүхэд элгэмсэг ирээдүй” төвд шуудангийн 42-р салбараар 36, 20 дугаар хороонд 36 шуудангийн хайрцаг | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | төрлийн үйлчилгээг авах боломжоор хангана. | байрлуулснаас 25 хайрцгаар иргэд хэвлэл захиалга хүлээн авч байгаа нь гэр хорооллын иргэдэд буухиа шуудан, захидал, төлбөр тооцоог цаг алдалгүй хүргэх боломж, бололцоо нээгдэж байна. | | |
| 79 | | Шуудангийн хайрцаг эзэмшигчдийн судалгааг гаргаж, судалгаанд тулгуурлан шуудангийн хайрцгаар хангах талаар анхаарч ажиллана. | ЗХХ | 100% |
| | | 15, 20 дугаар хороо тус бүрд 36 шуудангийн хайрцаг байрлуулж иргэдэд буухиа шуудан, захидал, төлбөр тооцоог шуурхай хүргэх боломжтой боллоо. | | |
| ***3.5. Дүүргийн санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэх чиглэлээр:*** | | | | |
| 80 | 3.5.1. Улсын болон орон нутгийн тєсвийн орлогыг тогтвортой бааз суурийг єргєжїїлж, татвар хураалтыг эрчимжїїлэн тєсвийн бие даасан байдлыг хангана. | Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын жишигт нийцүүлсэн стандартыг мөрдүүлэхэд хяналт тавьж ажиллана. | СТСХ | 100% |
| | | И-Баланс веб сайтыг 2013 оны 1 дүгээр улиралд шинэчилсэн. Тус дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудын 2013 оны жилийн эцэс, 2014 оны 1, 2, 3 дугаар улирлын аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авч сангийн яамны нэгтгэлийн програмд нэгтгэн сангийн сайдын 83 дугаар тушаалын дагуу жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайланд залруулга хийж НББОУС болон СТОУС-ын дагуу Аж ахуй нэгж байгууллагуудад зөвлөгөө өгч, хяналт тавин ажиллаж байна.<br>2013 оны 4 дүгээр улиралд нийт татварын баазаар 12729 аж ахуй нэгж байгууллагын 87.3% буюу 11116 аж ахуйн нэгж байгууллагын тайланг хүлээн авч нэгтгэл хийсэн. Аудитын тухай хуулийн дагуу 3042 аж ахуй нэгж байгууллага аудитын компаниар тайлангаа баталгаажуулсан байна.<br>2014 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайлан ирүүлбэл зохих 13087 аж ахуйн нэгж байгууллагаас 10912 аж ахуйн нэгж байгууллага буюу 83.4 хувь, 2 дугаар улиралд санхүүгийн тайлан ирүүлбэл зохих 13041 аж ахуйн нэгж байгууллагаас 10445 аж ахуйн нэгж байгууллага буюу 80.1 хувь , 3 дугаар улиралд санхүүгийн тайлан ирүүлбэл зохих нь 13598 аж ахуйн нэгж байгууллагаас 10744 аж ахуйн нэгж байгууллага буюу 79.3 хувиас нь тайланг хүлээн авч нэгтгэлийг хийж хуулийн хугацаанд нь нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст мэдээг хүргүүлэн ажилласан.<br>Жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитын тухай хуулийн дагуу аудитаар 3450 байгууллага тайлангаа баталгаажуулах ёстойгоос 3042 байгууллага буюу 88,2 хувь нь тайлангаа баталгаажуулсан байна. 2013 оны жилийн эцсийн тайлан хоцроож ирүүлсэн 41 аж ахуйн нэгж байгууллагад 39,360,000.0 төгрөг 2014 оны 3 дугаар улирлын байдлаар хуулийн хугацааг хоцроож ирүүлсэн 54 аж ахуйн нэгж байгууллагад 51,840,000.0 төгрөгийн торгуулийн хариуцлага тооцон ажиллалаа. | | |
| 81 | | Дүүргийн хэмжээнд татвар төлөгчдөд татварын үйлчилгээг шуурхай хүргэж, иргэний бүртгэлийн мэдээллийн санг үүсгэж, татварын орлогын хэмжээг бодитойгоор нэмэгдүүлнэ. | ТХ | 100% |
| | | Монгол улсын Татварын багц хуулиуд болон бусад хууль тогтоомжийг үндэслэл болгон Татварын ерөнхий газраас 2014 оныг “ Татварын үйлчилгээ, технологийн дэвшлийн жил “ болгон зарлаж, татварын шинэчлэлийн хүрээнд орчин үеийн технологид суурилсан цахим татварын албыг бий болгох, татвар төлөлтийг хялбар, түргэн шуурхай болгон татвар төлөгчдөд соёлтой, боловсон үйлчилгээг хүргэх зорилт тавин ажиллаж байна. Татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлж буй нэг цэгийн үйлчилгээний танхимыг стандартын дагуу татварын албаны хэмжээнд нэг өнгө, төрхтэй болгон тохижуулж, дараалал зохицуулах систем , компьютер, үнэлгээний орчин үеийн техник, тоног төхөөрөмжийг суурилуулан ажиллаж байна. Мөн шинээр үүсгэн байгуулагдсан ААН, иргэдэд татварын тайлан шивэх аргачлалыг зааж өгөх, туслах зорилгоор татвар төлөгчдөд зориулсан 3 ширхэг комьютерийг суурилуулан зөвлөгөө өгч ажиллаж байна. | | |

| | | |
|---|---|---|
| | | Нэг цэгийн үйлчилгээнээс татвар төлөгчдөд дараах үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй, чанартай боловсон байдлаар хүргэн ажиллаж байна. Үүнд: Татвар төлөгчийг бүртгэх, нэмэлт өөрчлөлт хийх, татвар төлөгчид лавлагаа өгөх, тодорхойлолт гаргах, татвар төлөгчдөөс тайлан хүлээн авах, баталгаажуулалт хийх, хүсэлтийг шийдвэрлэх, татвар төлөгчдөд зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах ажлыг нэг цэгээс үзүүлж байна.<br>Татвар төлөгчийн бааз 2014.01.01-ны байдлаар 18685 байсан бол 2014.12.02- ны байдлаар 20681 буюу 1996 татвар төлөгч шинээр нэмэгдэж, 111 татвар төлөгч бусад татварын албанд шилжсэн буюу татан буугдсан шалтгаанаар бүртгэлийн баазаас хасагдсан байна.<br>Татварын алба нь бүртгэх байгууллага болон татвар төлөгчөөс ирүүлсэн мэдээллийг үндэслэн татвар төлөгчийн мэдээллийн бааз, хувийн хэрэгт нэмэлт,<br>өөрчлөлт оруулдаг ба 2014 оны 12 сарын 02-ны байдлаар ААН-ын захирал болон үүсгэн байгуулагчийн нэр хаяг өөрчлөгдсөн 447, оршин суугаа хаяг өөрчлөгдсөн 370, дансны өөрчлөлт 58, оноосон нэрийн өөрчлөлт 33, регистрийн дугаар 11, үйл ажиллагааны чиглэлийн өөрчлөлт 118, хөрөнгийн хэмжээ 26 хуулийн этгээдийн өөрчлөлтийг хийсэн. 2014 онд НӨАТ төлөгчөөр бүртгүүлвэл зохих ААН-ийн судалгааг гаргаж, 400 ААН –д НӨАТ төлөгчөөр бүртгүүлэх ТУБ –ийн шаардлага хүргүүлж ажилласан. 2014 оны 12 сарын 02- ны өдрийн байдлаар 664 татвар төлөгчийг НӨАТ төлөгчөөр бүртгэсэн байна.<br>Тайлан хүлээн авалтын хувьд 2014.01 улиралд ААН тайлан ирүүлбэл зохих 13627-аас ирүүлсэн 9794 буюу 71.9%-ийн ирцтэй баталгаажуулалтын хувь 96.7%-тай байна. 2014 оны 02 дугаар улиралд ААН тайлан ирүүлбэл зохих 14086-аас ирүүлсэн 9826 буюу 69.8%-ийн ирцтэй баталгаажуулалтын хувь 87.3%-тай байна. 2014.03 улиралд ААН тайлан ирүүлбэл зохих 14231-ээс ирүүлсэн 10032 буюу 70.5%-ийн ирцтэй баталгаажуулалтын хувь 90.3%-тай байна. Суутганы 01 дүгээр улиралд тайлан ирүүлбэл зохих 14635-аас ирүүлсэн 10109 буюу 69.10%-ийн ирцтэй баталгаажуулалтын хувь 99.1%-тай байна. 2014.02 улиралд тайлан ирүүлбэл зохих 15223-аас ирүүлсэн 10316 буюу 67.80%-ийн ирцтэй, баталгаажуулалтын хувь 96.1%-тай байна. 2014.03 улиралд тайлан ирүүлбэл зохих 15542-оос ирүүлсэн 10619 буюу 68.3%-ийн ирцтэй, баталгаажуулалтын хувь 93.7%-тай байна. 2014 оны 1-10 сарын НӨАТ-ийн тайлан ирүүлбэл зохих 37586 -аас ирүүлсэн 32925 буюу 87.6%-ийн ирцтэй баталгаажуулалтын хувь 99.4%-тай байна. 2014.01.01-2014.02.15-ний хооронд ТТҮТ нь 2013 оны иргэдийн ХХОАТ-н тайланг хүлээн авч үйлчилсэн. 2014 онд хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдахаар холбогдох баримт материалаа ирүүлж тайлангаа өгсөн иргэдийн судалгаагаар ХХОАТТХуулийн 16.1.12 дахь заалтаар 1558 иргэний, 24.6 дахь заалтаар 1083 иргэний, нийт 2641 иргэний 2,049,545.5 мянган төгрөгийн буцаан олголтын дүнтэй байна.<br>Лавлагаа тодорхойлолт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ Татварын ерөнхий хуулийн дагуу татвар төлөгчийн бичгээр ирүүлсэн хүсэлт болон бусад төрийн байгууллагын албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу 2014 оны 12 дугаар сарын 02- ны байдлаар хуулийн этгээдийн 15989 тодорхойлолтыг reference програмаас гаргаж үйлчилгээ үзүүллээ. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 82 | | Татвар төлөгч аж ахуйн нэгж, иргэн бүрт хүрсэн цогц үйлчилгээг бий болгож, мэдээллийг шуурхай хүргэх цэг бий болгоно. | ТХ | 100% |
| | | 1. Татварын алба нь тоон гарын үсгийн дэд бүтцийг байгуулан, програм хангамжийг боловсруулан татварын тайлан хүлээн авч байна. Тоон гарын үсэг нь ердийн гарын үсэгтэй адил хүчинтэйд тооцох тул цахимаар илгээсэн тайланг цаасаар баталгаажуулах шаардлагагүй болсон. Ингэснээр татвар төлөгчдийн цаг, хугацаа, зардлыг хэмнэх, татварын албанаас үзүүлж буй үйлчилгээг түргэн шуурхай авч, хүнд суртал алга болсон. Тус татварын хэлтэст | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | бүртгэлтэй нийт 20681 татвар төлөгчөөс тоон гарын үсэгт хамрагдвал зохих 15542 татвар төлөгчөөс 13468 татвар төлөгч буюу 86.6% нь тоон гарын үсгийн гэрээ байгуулсан байна.<br>2. Санхүүгийн тайланг цахим хэлбэрээр хардаг болсон. Ингэснээр татвар төлөгч санхүүгийн тайлангаа тушаасан эсэх болон тайлангийн үзүүлэлтүүдийг цахимаар хардаг болсон нь цаасгүй орчинг бүрдүүлж өгсөн.<br>3. Цахим тайлангийн мэдээллийн системийг нэвтрүүлсэн. Ингэснээр татвар төлөгч татварын бүх төрлийн тайлан, хавсралт мэдээ илгээх, хүсэлт илгээх, өөрийн тайлан тушаалт, татварын байдал, өрийг хянах, тайлан залруулах, буцаан олголтууд , төлөлттэй холбоотой аливаа үйл ажиллагааг заавал татварын албанд очилгүй шийдвэрлүүлэх боломжтой болсон бөгөөд татвар төлөгч болон татварын алба хоорондын харилцаа холбоо, үйлчилгээ сайжирч байна. 2014 оны 12 сарын 02-ны байдлаар 9105 татвар төлөгчийн цахимаар ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэж ажилласан байна.<br>4. Татварын төлбөр тооцоог интернэтээр, банкны вэб хуудсаар, мобайл банкны үйлчилгээг ашиглан хийх боломжтой болсон. Одоогоор Голомт банктай хамтарч ажиллаж байна.<br>5. Татварын албаны цахим хуудас /www.mta.mn/- наас татвар төлөгч татварын хууль, тогтоомж, дүрэм, заавар, аргачлал, маягт гэх мэт хэрэгтэй зүйлээ нэг дороос авах боломжийг бүрдүүлж өгсөн.<br>6. Татварын албаны талаарх мэдээ, мэдээлэл болон татварын хууль, тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэх асуудлаар олон нийтэд мэдээлэл түгээх үйл ажиллагаанд нийгэмд чиглэсэн интернэт мэдээллийн хэрэгсэл /facebook/ -ийг ашиглаж байна.<br>7. НТГ-ын цахим хуудас /www.nta.mn/- сайтад Сүхбаатар дүүргийн татварын хэлтэстэй холбоотой мэдээ, мэдээлэл, сургалт, татварын хууль, тогтоомж, дүрэм, зааварт орсон өөрчлөлтүүд гэх мэтчилэн 29 мэдээлэл, facebook-д 140 мэдээллийг сайтдаа байршуулаад байна. | | |
| 83 | | Дүүргийн хэмжээний үл хөдлөх хөрөнгийн мэдээллийн баазыг шинэчилж, иргэдийн татварт хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | ТХ | 100% |
| | | Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Татварын ерөнхий газрын даргын 2013 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн А/866/03 дугаар хамтарсан захирамж, тушаалаар зохион байгуулагдсан, Нийслэлд үл хөдлөх эд хөрөнгийн тооллого, татвар төлөгч иргэнийг бүртгэлжүүлэх ажлын үр дїнд үүссэн мэдээллийн баазыг баталгаажуулах, татвар төлөгчдийг татварт хамруулах, нийслэл, орон нутгийн төсвийн орлогын тогтвортой эх үүсвэрийг нэмэгдүүлэх, далд эдийн засгийг ил болгоход ахиц дэвшил гаргахад зорилго оршино.<br>Нийслэлийн хэмжээнд ажлын байр түрээслүүлэгч болон түрээслэгчдийн мэдээллийг баталгаажуулах, татварт хамрагдалтыг эрчимжүүлэх ажлыг 2014 оны 2-р улиралд уг ажлыг бүртгэж гүйцэтгэлээ.<br>Дүүрэг хорооны нутаг дэвсгэрийн хүрээнд хороо хариуцсан татварын байцаагчид газар дээр нь биечлэн очиж, обьекттой танилцан тодруулах хэлбэрээр зохион байгуулан ажилласан.<br>Ажлын байр түрээслэгч иргэний овог нэр, регистрийн дугаар, эрхэлж буй үйлчилгээ, үйл ажиллагааны чиглэл, түрээсийн талбайн хэмжээ, 1кв.м-ийн үнэ түрээсийн төлбөрийн хэмжээ сар, жилээр орлогын хэмжээг сар, улирал, жилээр татварын тайлан гаргадаг эсэх төлөлтийн байдал уг бүртгэлээс өмнө татварын албанд бүртгэлтэй байсан эсэх талаар, бүртгэлгүй байсан иргэн, хуулийн этгээдийг шинээр бүртгэлжүүлэн судалгаанд тусгав.<br>Судалгааны ажлын үр дүнгийн талаарх мэдээлэл:<br>Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт 715 обьект, 4338 ажлын байр байгаа ба үүнээс үйл ажиллагаа явуулж буй иргэд | | |

<table>
<tr><td></td><td></td><td colspan="3">хуулийн этгээдээр задруулбал дараах байдалтай байна.<br>- түрээслэгч иргэд 2525<br>- түрээслэгч хуулийн этгээд 2041<br>Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг иргэдийн албан татварын төрлийн задаргаа дараах байдалтай байна. /давхардсан тоогоор татвар төлөгчийн тоо орсон болно/<br>Төрөл ТТ Too Гүйцэтгэл<br>- Патент 3967 179 687.4<br>- Жишиг 736 65 596.2<br>- ААЭО 4560 4 845 670.1<br>- Үл хөдлөх 357 5 423 756,0<br><u>Нийт 10 514 709,7</u><br><br>Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт түрээсийн орлоготой 526 иргэн байгаагаас 309 нь ажлын байр түрээслүүлэгч, 217 орон сууц түрээслүүлэгч иргэд байна. Үүнийг задалвал:<br>-Ажлын байр түрээслүүлэгч 309 иргэний 130 иргэн нь орлогоо тайлагнан татвар төлдөг бөгөөд 179 иргэн орлогоо тайлагнадагггүй.<br>-Орон сууц түрээслүүлэгч 217 иргэний 12 иргэн нь орлогоо тайлагнан татвар төлдөг бол 205 иргэн орлогоо тайлагнадаггүй байна.<br>2014 онд нийт түрээсийн орлогоор 107 026,4 мянган төгрөгний татвар төлүүлсэн байна.<br>Энэ ажлын хүрээнд хорооны байцаагч нар 2014 оны 11 сарын 20-ноос 12 сарын 10 хүртэл удирдамжтай ажил явагдаж байгаа ба эхний ээлжинд Улсын бүртгэлийн ерөнхий газар, Дүүргийн бүртгэлийн газраас лавлагаа авсан бөгөөд үүнийхээ дагуу мэдэгдэх хуудас, дуудах хуудас өгч байна. Улмаар данс хаах, битүүмжлэх ажиллагаа хийгдэхээр ажиллаж байна.</td></tr>
<tr><td rowspan="2">84</td><td rowspan="2">3.5.2.Орон нутгийн болон нийтийн эзэмшлийн өмчийг бүртгэлжүүлж, эдийн засгийн эргэлтэнд оруулна.</td><td>Орон нутгийн болон нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн бүртгэлийг цахимжуулах ажлыг эхлүүлнэ.</td><td>СТСХ ЗХХ</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="3">Эд хөрөнгийн бүртгэлийг цахимжуулах ажлын хүрээнд 2014 оны 01-р сарын 10-ны өдөр СБД-ийн ЗДТГ-ын хурлын зааланд нийт төсөвт байгууллагын нягтлан бодогч нарын дунд Төрийн өмчийн хорооны e-spc.gov.mn сайтанд хөрөнгийн мэдээ шивэх сургалтыг зохион байгуулсан.<br>Дүүргийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангаар хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 05 сарын 05-ны өдрийн 66 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу 926,096,428.0 төгрөгийн 44 ажлыг хөрөнгийн данс бүртгэлдээ бүртгэж, Нийслэлийн өмчийн харилцааны газарлуу 121,600,000.0 төгрөгийн 2 ажлыг хөрөнгөнд бүртгэх зөвшөөрөл авч бүртгэлжүүлсэн. Мөн 1,047,133,536.48 төгрөгийн 24 ажлыг холбогдох байгууллагуудруу нь бүртгэж авах албан тоот явуулан бүртгэлжүүлж ажилсан байна.<br>2014 онд багтаан дуусгах хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэл 100% гарсан үед нь ондоо багтаан бүртгэлжүүлнэ.</td></tr>
<tr><td colspan="5">ДӨРӨВ. АЮУЛГҮЙ, АМГАЛАН ДҮҮРЭГ</td></tr>
<tr><td colspan="5">4.1. Хотын аюулгүй байдлыг хангаж, хэв журмыг сахиулах чиглэлээр:</td></tr>
<tr><td>85</td><td>4.1.1 Дүүргийн нутаг</td><td>Архи, тамхины борлуулалтанд хяналт тавих ажлыг зохион байгуулна.</td><td>ЦХ 1,2</td><td>100%</td></tr>
</table>

| | | | | |
|---|---|---|---|---|
| | дэвсгэрт архи, тамхины борлуулалтанд тавих хуулийн хяналтыг сайжруулна. | | МХХ ХҮХ | |
| | | **Цагдаагийн нэгдүгээр хэлтсээс:** Архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлж “Шалгалт””Хяналт-1,2,3,4”“Архигүй өдөр”, “Хяналт”, “Архи”, “Цохилт” арга хэмжээнүүдийг сард 2-оос доошгүй удаа зохион байгуулж “32 клуб”, “Даймонд” караоке, “Санстрит” караоке, “Лексор” караоке, “Рок шугар” ресторан, “Гүсто” ресторан, “Сева” паб “Лондон”,”Эра”, Брикс”,”Холливуд”, ”Голден“,“Вондерс” “Ривер саунд”, Блю Скай эйжиа ХХК-н Вегас, VIP, LUX, VILVT зэрэг нийт 326 баар цэнгээний газар, хүнсний дэлгүүрт АСТТХ-ийн дагуу 70.456.000 төгрөгний торгууль ногдуулж арга хэмжээ тооцсон. Шалгалтанд давхадсан тоогоор 1700 байгууллага аж ахуйн нэгж хамрагдлаа. “Архаг архичин””Албадан эмчилгээ” ”Журам” ”Баривчилгаа” арга хэмжээнүүдийг зохион байгуулж байнга архидан согтуурдаг захиргааны зөрчил гаргасан 175 хүнийг шүүхийн шийдвэрээр баривчлуулан 5 хүнийг архины албадан эмчилгээнд явуулсан.<br>**Цагдаагийн хоёрдугаар хэлтсээс:** 2014 оны эхний 11 сарын байдлаар архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр нийт 261 байгууллага, аж ахуйн нэгжийг давхардсан тоогоор 1217 удаа шалгаж зөрчил гаргасан 26 байгууллага аж ахуйн нэгж, иргэнийг 3,570,000 төгрөгөөр торгож, зөрчлийг арилгуулах талаар албан мэдэгдэл 245, сэрэмжлүүлэг 1254 ширхэгийг тараан өгч, удаа дараа цаг хэтрүүлэн ажилласан “Аврага чоно” ХХК-ны “Озон” баарны тусгай зөвшөөрлийг нь цуцлуулахаар Улаанбаатар хотын захирагчийн албанд санал хүргүүлж, тусгай зөвшөөрлийг цуцлуулсан.<br>9,11 дугаар хороонд үйл ажиллагаа явуулдаг “Жаргалант төмөр” ХХК-ний “We”, “Аврага чоно” ХХК-ны “Озон” баарнууд нь зохих зөвшөөрөлгүй удаа дараа үйл ажиллагаа явуулсан тул хууль бусаар олсон орлого 186,000 төгрөг, архи-68 шил, пиво-200 ширхэгийг СБД-н Засаг даргын Тамгын газарт улсын орлого болгуулахаар шилжүүлсэн.<br>Сар бүрийн нэгний өдөр архи худалдахгүй, түүгээр үйлчлэхгүй өдөр болон АСТТХ-ийн заалтыг дагаж ажиллах талаар согтууруулах ундаа худалддаг, түүгээр үйлчилдэг давхардсан тоогоор 876 аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаж, албан мэдэгдэл өгч, үр дүнг тооцон ажилласан.<br>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд хариуцсан хороодын нутаг дэвсгэрийн архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг, худалдан борлуулдаг аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран ажиллах зорилгоор “Хуулиа хэрэгжүүлье” уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулсан.<br>Арга хэмжээнд дүүргийн ХҮХ, 10-20-р хороодын засаг дарга, цагдаагийн хэлтсийн алба хаагчид, 125 аж ахуйн нэгж, байгууллагын эзэд, захирал хамрагдсан.<br>Архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгж, байгууллага, хүнсний дэлгүүрт хямд үнийн болон хуурамч лацтай архи худалдан борлуулж байгаа эсэхэт хяналт тавих, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор “Хуурамч, хямд архи” арга хэмжээг зохион байгуулан ажилласан.<br>Арга хэмжээний хүрээнд дүүргийн 10-20-р хорооны нутаг дэвсгэрт архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг, худалдан борлуулдаг 147 аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаж, 7 хүнсний дэлгүүрээс 0,75 литрийн “Буудай” архи 83 шилийг хурааж, 0,75 литрийн “Буудай” архи 125 шил, 0,75 литрийн “Их Монгол” 24 шил архийг тус тус битүүмжилж, тус бүрээс нь архины дээжийг шинжилгээнд явуулсан.<br>Сүхбаатар дүүргийн 14-р хороонд байрлах “Мини маркет” хүнсний дэлгүүр нь согтууруулах ундаа борлуулж байсныг илрүүлж, 155 шил архи, 65 лааз шар айргыг битүүмжилж, холбогдох хуулийн дагуу 200,000 төгрөгийн торгууль ногдуулж, зөрчлийг арилгуулсан.<br>Монгол улсын “Архидан согтуурахтай тэмцэх” тухай хуулийн хэрэгжилтийг хангах, урьдчилан сэргийлэх, хямд үнийн, хувийн үйлдвэрийн архи согтууруулах ундаагаар үйлчилдэг, худалдан борлуулдаг аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаа | | |

| | | |
|---|---|---|
| | | шалгах, зөвшөөрөлгүйгээр архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг аж ахуй нэгж, иргэдийг олж тогтоох, Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг шалгах ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Хяналт” нэгдсэн арга хэмжээг зохион явуулсан.<br>Монгол Улсын Архидан согтуурахтай тэмцэх тухай, Тамхины хяналтын тухай хууль, Монгол Улсын Засгийн газраас баталсан “Олон нийт- цагдаагийн хамтын ажиллагаа” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, насанд хүрээгүй хүмүүсийг архи, тамхины хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Сургууль, цэцэрлэг архи, тамхигүй бүс” сэдэвт сэрэмжлүүлэгт самбарыг ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн орчим байрлуулах талаар санал, төслийг дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, 6 сая 127 мянган төгрөгний төсвийг шийдвэрлүүлсэн.<br>Дүүргийн ГХУСАЗЗ-д санал хүргүүлэн, 2 сая төгрөгний санхүүжилтыг шийдвэрлүүлж, “Архидалтгүй амьдралын хэвшил бүрдүүлэхийн төлөө хамтдаа”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар иргэдийн үүрэг” зэрэг 5 төрлийн 4000 ширхэг зурагт хуудсыг өнгөтөөр хэвлүүлэн, иргэд олноор цугларч буй хүнс болон барааны зах, худалдааны төв, нийтийн хоол, үзвэр үйлчилгээний газрууд, автобусны буудал, байрны орц, гудамжинд байршуулсан.<br>**Сургалт сурталчилгааны талаар:**<br>Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Их дээд сургууль, Ерөнхий боловсролын сургуулийн оюутан сурагчдад “Архи, тамхигүй Монголын төлөө хамтдаа” арга хэмжээний хүрээнд дүүргийн 8 дугаар хороо МУИС-н дотуур байрны оюутан, ШУТИС-н нийт 154 оюутнууд, 4, 6, 45, 1 сургууль, Хөгжим бүжгийн коллеж, Монгол-Энэтхэгийн хамтарсан сургуулийн нийт 2161 сурагчдын дунд 1-9 дүгээр хорооны хэсгийн байцаагч нар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийж, нийт 956 санамж, сэрэмжлүүлэг өгч ажиллаа. Архины хор уршиг, түүнээс үүдэн гарах гэмт хэрэг зөрчил сэдвээр 2-р сургууль, Байгаль эх лицей сургууль, Орос-3 сургуулийн 260 гаруй сурагчдад сургуулийн нийгмийн ажилтантай хамтарч хууль сурталчилах яриаг зохион байгуулан архидан согтуурахын хор уршгийг харуулсан санамж, сэрэмжлүүлэг тараасан. Архины хор уршгийг харуулсан 3 төрлийн санамж, сэрэмжлүүлгийг шалгалтанд хамрагдсан байгууллага аж ахуй нэгжүүдэд болон 300 гаруй иргэдэд тараах ажлыг зохион байгуулсан. Мэргэжлийн хяналтын газар, Дүүргийн нэгдүгээр прокурорын газар, Үйлдвэр үйлчилгээний хэлтсийн удирдлагуудтай хамтарч уулзалт зөвлөгөөн зохион байгуулан 300 гаруй байгууллага аж ахуйн нэгжийн захирал ээзд ирж оролцож Монголын үнэн сонин, TM, UBS, MNC, Монгол HD, Royel HD телевизээр сурталчилж ажилласан. Архины хор уршиг, түүнээс үүдэн гарах гэмт хэрэг зөрчил сэдвээр их дээд сургуулиудын дунд “Архигүй Монголын төлөө хамтдаа” сэдэвт удирдамжийн дагуу Сити дээд сургуулийн 150 гаруй оюутанд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр болон архи, тамхины тухай хуулиар яриаг зохион байгуулан архидаг согтуурахын хор уршгийг харуулсан санамж, сэрэмжлүүлэг тараасан.<br>**Тамхины хяналтын талаар:** Тамхины хяналтын тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор нийт 345 байгууллага аж ахуй нэгжид шалгалт явуулж ТХТХ-ийг зөрчсөн 146 байгууллага аж ахуй нэгжид 7,405,000 төгрөний торгууль ногдуулж арга хэмжээ тооцсон.<br>**Худалдаа үйлчилгээний хэлтсээс:** Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулинд нэмэлт өөрчлөлт орохтой холбогдуулан Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албанаас зохион байгуулсан хуулийн хэлэлцүүлэгт оролцож, Захиргаа, хуулийн хэлтэстэй хамтран Согтууруулах ундааны хяналтын тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг 3 үе шаттайгаар нутгийн захиргааны байгууллага, худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэд болон төрийн бус байгууллагуудын ангиллаар нийт 400 гаруй төлөөллийн дунд зохион байгуулж, хэлэлцүүлэгт оролцогсдоос хуулийн талаар санал авч нэгтгэж, Нийслэлийн Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст |

| | | |
|---|---|---|
| | | хүргүүлсэн.Хэлэлцүүлгийн явцыг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр сурталчилсан.<br>Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн Ажлын албаны даргын баталсан “Согтууруулах ундаа худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудыг аттестатчилах” удирдамжийн дагуу дүүргийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад Монгол улсын “Төрийн хяналт шалгалтын тухай”, “Архидан согтуурахтай тэмцэх тухай”, “Тамхины хяналтын тухай” “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай”, “Хүнсний тухай”, “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай”, “Ариун цэврийн тухай” хуулиуд, “Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих Үндэсний хөтөлбөр”, НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2007 оны 71 дүгээр, 2009 оны 63 дугаар, 2012 оны 61 дүгээр тогтоол, Хоолны газрын ангилал, зэрэглэл үндсэн шаардлага MNS 4946:2005, Худалдааны газар, түүний үйлчилгээ MNS 5021:2007 стандартын хэрэгжилтийг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөх, илэрсэн зөрчлийг арилгуулах, орчны тохижилт, цэвэрлэгээний шаардлагыг хангуулах замаар хотын өнгө үзэмжийг сайжруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор дүүргийн 1-20 дугаар хорооны худалдааны 50, хоол үйлдвэрлэл үйлчилгээний 52 цэгийн үйл ажиллагаанд аттестатчиллын шалгалтыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, тохижилтын хэлтэс, Цагдаагийн хэлтэс, Хороодын Засаг дарга, дүүргийн Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн хамтарсан 2 Ажлын хэсэг явууллаа. Аттестатчиллын шалгалтанд хүнсний 26, нийтийн хоолны 25 цэг тэнцэж, тусгай зөвшөөрлийн хугацаа нь дууссан 7 хүнсний дэлгүүрийн согтууруулах ундаа худалдаалах үйл ажиллагааг зогсоосон. Мөн нийтийн хоолны салбарын хоолны газрын чиглэлээр цаг хэтрүүлэн ажилласан 5 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулж, стандартын шаардлага хангаагүй, архи, согтууруулах ундаагаар үйлчилж байсан 12 аж ахуйн нэгж үйл ажиллагааны чиглэлийг өөрчлүүлсэн.<br>Дүүргийн Захиргааны Зөвлөлийн шийдвэрээр Монгол Улсын хилээр хууль бусаар орж ирсэн, хаана үйлдвэрлэгдсэн нь тодорхойгүй, гарал үүслийн бичиггүй, хятад ханзаар бичсэн шошготой 2л, 500, 494 грамм савалгаатай 42-60%-ийн 8 нэр төрлийн 1381 ширхэг буюу 1 тонн 407 литр 128 грамм их хэмжээний архи согтууруулах ундаа, 4 нэр төрлийн 255 ш чанарын шаардлага хангаагүй тамхийг холбогдох журмын дагуу устгалд оруулж, тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулсан 3 ААН-ийн 108 архи, 544 пивыг хураан авч, улсын орлого болгосон.<br>Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албанаас зарласан Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх 1 сарын аяны хүрээнд Тамхины хяналтын тухай хууль болон Тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журмыг иргэд, аж ахуйн нэгжүүдэд сурталчлан, Эрүүл мэндийн яам, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас олгосон “Утаат тамхи татахыг хориглоно”, Тамхи татахыг хориглосон байршлуудыг заасан 1000 ш зурагт хуудас, бусад сурталчилгааны материалыг тарааж, Засгийн газрын 2013 оны 191 дүгээр тогтоолоор баталсан “Тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа үйлчилгээнд хяналт тавих журам”-ыг хэрэгжүүлэх, нийтэд сурталчлах зорилгоор мэдээллийн самбар хийж, хуулиар хориглосон тамхи худалдах болон татах газруудын байршил, зөрчил гаргасан аж ахуйн нэгж, иргэнд оногдуулах торгуулийн арга хэмжээний заалтуудыг бичиж, нийтэд анхааруулах хэлбэрээр хуулийг сурталчилж, ААНБ-дад Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран сургалт явуулж, Тамхигүй өдөр болох 5 дугаар сарын 31-ны өдөр хуулийн хэрэгжилтэнд хяналт тавин ажилласан. Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэстэй хамтран 10, 14, 16, 18, 20 дугаар хорооны нийт 14 хүнсний дэлгүүрийн үйл ажиллагаанд, Нийслэлийн Цагдаагийн газар, ТВ-9 телевизтэй хамтран 5, 6 дугаар хорооны худалдаа, үйлчилгээний газруудын үйл ажиллагааг шалгаж, Цахиур мандал ХХК-ийн хүнсний дэлгүүр, 5 дугаар хорооны ТҮЦ-үүд зөвшөөрөлгүй тамхи худалдаалж байсан зөрчлийг илрүүлэн, холбогдох арга хэмжээ авч ажиллалаа.<br>Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Тамхины хяналтын тухай хууль зөрчигдөж байгаа талаарх иргэдээс ирүүлсэн 4 удаагийн гомдол саналыг түргэн шуурхай барагдуулж, дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, Цагдаагийн хэлтэс, Хороодын Засаг дарга нартай хамтран газар дээр нь шийдвэрлэн, гомдол гаргасан иргэн болон мэдээллийн эх сурвалжуудад холбогдох хариуг утсаар болон албан бичгээр хүргүүлсэн. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 86 | | Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, охид эмэгттэйчүүдийг олж илрүүлэх, тэдэнд хамгааллын үйлчилгээ үзүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана. | НХХ | 100% |
| | | Нийслэлийн хүүхэд гэр бүл хөгжлийн төв, Сэтгэлийн учиг төрийн бус байгууллагатай хамтран сургагч багш бэлтгэх 2 өдрийн сургалтанд 1, 4, 5, 11, 8, 14, 16, 20 дугаар хорооны нийгмийн ажилтнууд хамрагдлаа.<br>FUN буюу хөршийн холбоо сургалтанд 1, 4, 5, 11 дүгээр хорооны нийгмийн ажилтнууд хамрагдсан.<br>8, 14, 16, 20 дугаар хорооны нийгмийн ажилтнууд хамтран “Амьдралд бэлэн клуб” нээн ажиллуулж, хорооныхоо иргэдэд 8 удаагийн сургалт зохион байгуулж, сургалтанд хараа хяналтгүй, гэмт хэрэг зөрчилд өртөж болзошгүй, гэмт хэрэгт өртсөн, хүчирхийлэлд өртсөн, хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд хамрагдсан. | | |
| 87 | 4.1.2 Гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээнд гардаг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн идэвхи санаачлагад суурилсан "хөршийн хамгаалалт" амгалан тайван байдлын тогтолцоо бүрдүүлнэ. | Иргэдийн идэвх санаачлагад тулгуурлан Хөршийн хамгаалалт амгалан тайван байдлын тогтолцоо бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | ЦХ-1, 2 | 100% |
| | | Цагдаагийн нэгдүгээр хэлтэс: 2014 оны 3 дугаар сарын 21-ний өдөр Дүүргийн 1-9 дүгээр хороонд үйл ажиллагаа явуулж байгаа 18 ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 850 сурагчдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хөршийн хамгаалалтын талаар мэдлэг олгох зорилгоор “Хөршийн холбоо” уриалгыг сурталчилж хуулийн зөвлөгөө өгч, “Бидний амьдрах нөхцөл тайван байх ёстой”, “Миний бодлоор цагдаа” зэрэг зохион бичлэгийн уралдаан зарлаж 10 хүүхдийг шагнаж урамшуулж ажилласан. 2014 оны 12-р сард СӨХ-үүдийн дунд “Хөршийн хамгаалалт”сэдэвт уралдаан зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>Цагдаагийн хоёрдугаар хэлтэс: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, эцэг, эхийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, дүүргийн 10-20-р хорооны нутаг дэвсгэрт оршин суудаг, байнга архидан согтуурч, гэр орондоо түгшүүр төрүүлдэг иргэдийн гэр бүл, үр хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор “Гэр бүлийн хүчирхийллээс сэргийлье” өдөрлөгийн арга хэмжээг Дүүргийн нийгмийн хөгжлийн хэлтэс, Хөдөлмөрийн хэлтэс, Эрүүл мэндийн нэгдэлтэй хамтран зохион байгуулж ажиллалаа.<br>Арга хэмжээний хүрээнд байнга архидан согтуурч, ар гэртээ хэрүүл маргаан үүсгэж, айлган сүрдүүлж, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулдаг, орчиндоо түгшүүр төрүүлдэг, архины хамааралтай болсон 103 иргэнийг хамруулсан.<br>Өдөрлөгийн арга хэмжээний хүрээнд “Жендер ба хүчирхийллийн тухай үндсэн ойлголт” , Монгол Улсын Эрүүгийн хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилгүй иргэдийг бүртгэх, ажлын байранд зуучлах, сул чөлөөтэй болон шинэ ажлын байр захиалах талаар зөвлөгөө, мэдээлэл өгч, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн 570 гаруй сул чөлөөтэй болон шинэ ажлын байрыг танилцуулж, ажил хайгч 12 иргэнийг бүртгэж, ном, хууль эрх зүйн сэтгүүл, гарын авлага, материал 103 ширхэгийг тарааж өгсөн. | | |
| 88 | | Гэр бүлд зөвлөгөө өгөх төв байгуулах төсөл боловсруулан хэрэгжүүлнэ. | НХҮХ | 100% |
| | | 1. 2014 онд сэргээн засах үйлчилгээг “Төгс ивээлт бахархал гэрэлт төв” ТББ, “Ивээлт орчлон” ТББ, “Алтан элч гэр бүлд зөвлөгөө өгөх төв” ТББ, “Ивээлт гэгээ” ХХК , “Монголын хөгжлийн бэрхшээлэй иргэдийн нэгдсэн холбоо” ТББ, “Анхны илгээлтийн ээзд” ХХК гэсэн 6 байгууллагатай гэрээ байгуулан ажилласан. Байгууллагуудын сэргээн засах, өдрийн үйлчилгээнд нийт 486 иргэн хамрагдсан үүнээс ахмад настан 233, хөгжлийн бэрхшээлтэй 120 иргэн хамрагдсан байна.<br>2. Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг “Таныг зорьсон буянтан” ТББ үзүүлж байгаа бөгөөд одоогийн байдлаар ахмад настан 50, хөгжлийн бэрхшээлтэй 20 иргэн нийт 40 иргэн хамрагдсан байна .<br>3. Сургалт зохион байгуулах үйлчилгээг “Увдис сэтгэл зүйн төв” ТББ нь Амьдралын итгэл үнэмшил, бие даан | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах үйлчилгээнд Сүхбаатар дүүргийн 20 дугаар хорооны хөгжлийн бэрхшээлтэй 25 иргэн хамрагдсан.<br>4. Түр байрлуулан асрамжлах үйлчилгээг "Хүчирхийлэлийн эсрэг үндэсний төв" ТББ нь: Жендерээс үүдэлтэй хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хохирогчдод төрөөс үзүүлэх үйлчилгээг чанартай хүргэх тэднийг хамгаалах механизм эрх зүйн оновчтой орчинг бүрдүүлэхэд нөлөөлөх зорилгоор түр байрлуулан асрамжлах үйлчилгээг үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна.<br>**Үр дүн:** Эдгээр үйлчилгээнд нийт давхардсан тоогоор 551 иргэн хамрагдсан | | |
| 89 | 4.1.3. Мансууруулах бодисын хорт нөлөөг таниулан, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна. | Мансууруулах бодисын хор хөнөөлийг таниулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна. | ЦХ-II | 100% |
| | | **Цагаадаагийн нэгдүгээр хэлтэс:** "Архи, тамхины хор хөнөөлтэй тэмцэх нь" нэгдсэн арга хэмжээний удирдамжийн хүрээнд тус хэлтсээс 2014 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс 09 дүгээр сарын 29-ны өдрийг хүртэл хугацаанд ажиллах салбар төлөвлөгөө гаргаж бие бүрэлдэхүүнд танилцуулан, арга хэмжээнд ажиллах алба хаагч нарт үүрэг чиглэл өгч 10 офицер, 8 Олон нийтийн цагдаагийн ажилтан, 32 урамшилт эргүүл, 9 станц, 1 автомашин хүн хүчтэйгээр зохион байгуулан ажиллалаа. Арга хэмжээний хүрээнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Тамхины хяналтын тухай хуулиудыг сурталчлах, Хар тамхи мансуурлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр МУБИС, ШУТИС, МУИС, Түшээ, Сити, Этүгэн, Соёмбо, Чингис хаан дээд сургуулиудын 1 дүгээр курсийн 1869 оюутануудад яриа таниулга хийж, оюутануудын санал хүсэлтийг авч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр санамж сэрэмжлүүлэг тараан өгч, ТМ, Ийгл, Шинэ дэлхий зэрэг телевизээр сурталчилан ажилласан.<br>Их дээд сургуулийн оюутнуудад Хар тамхи, мансууруулах бодисны хор уршиг, хэрхэн урьдчилан сэргийлэх талаар яриа таниулга, сургалт зохион байгуулж, 5 төрлийн 1300 ширхэг санамж сэрэмжлүүлэгийг тараан өгч, "Хэн ч, хэзээ ч, хаана ч худалдагдах ёсгүй" баримтат киног оюутануудад үзүүлсэн.<br>"Мансуурал" арга хэмжээг зохион байгуулж 1,45 дугаар сургуулийн 232 сурагчдад Гэр бүлийн хүчирхийллийн сэдвээр яриа таниулга хийж 2 төрлийн 48 ширхэг санамж, сэрэмжлүүлэг тарааж ажилласан. Хөгжим бүжгийн коллежийн 283 сурагч, Монгол-Энэтхэгийн хамтарсан сургуулийн 255 сурагч, Дүүргийн бүртгэлийн газрын 24 ажилтанд, ШУТИС, ЭМШИУС, ХҮДС-ийн оюутны байруудын 210 оюутанд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиар яриа таниулга хийж 6 төрлийн 190 ширхэг санамж, сэрэмжлүүлэг тарааж ажилласан.<br>**Цагдаагийн хоёрдугаар хэлтэс:** Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг архи, тамхи, мансууруулах бодис, PC тоглоомонд донтох хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хүүхдүүдийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан шинэлэг хэлбэрээр "Гэрэлт ирээдүйн төлөө хамтдаа" уриан дор "Сургууль-Хүүхэд-Аюулгүй орчин" арга хэмжээг ерөнхий боловсролын 4-р сургуулийн урлаг зааланд зохион байгууллаа.<br>"Гэрэлт ирээдүйн төлөө хамтдаа" уриан дор зохион байгуулсан жүжигчилсэн болон урлагийн тоглолтын арга хэмжээнд 4-р сургууль болон "Галакси" сургуулийн 6-11-р ангийн 620 гаруй сурагчид 4-н ээлжээр хамрагдсан.<br>Архи, тамхи, мансууруулах бодисын хор хөнөөлийг жүжигчилсэн болон урлагийн хэлбэрээр үзүүлсэн нь сурагчдад ойлгомжтой, сонирхолтой байсан бөгөөд сургуулийн удирдлага, багш, ажилчдаас талархалтай хүлээн авсан. | | |
| 90 | | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх эмээр үйлчлэх эмийн сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж, эмийн чанар аюулгүй байдлыг хангуулна. | МХХ<br>ЦХ-1,2 | 100% |
| | | **Цагдаагийн нэгдүгээр хэлтсээс:** Гэмт хэрэгтэй тэмцэх тасагтай хамтран үр зулбуулах эмийн хууль бус худалдааг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор "Илрүүлэлт" нэгдсэн арга хэмжээг зохион явуулж 15 төрийн болон хувийн | | |

<table>
<tr><td></td><td></td><td colspan="3">эмэгтэйчүүдийн эмнэлэг , 41 эмийн сангийн судалгааг гарган, шалгалт хийж үр зулбуулах эм худалдахгүй байх талаар албан мэдэгдлийг өгч ажилласан болно. Гар дээрээс үр зулбуулах эмнүүд худалдан авахгүй байх талаар сэрэмжлүүлэг мэдээллийг TV-9 телевизээр хийж ажилласан болно. Мансууруулах бодистой холбоотой эм тарианы худалдаанд хязгаарлалт тавих талаар холбогдох байгууллагуудад хүсэлт хүргүүлэн ажиллаж байна.<br>Цагдаагийн хоёрдугаар хэлтсээс: Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, цэнхэр спирт болон эмчийн жороор олгодог эмийн хууль бус худалдаа үйлчилгээтэй тэмцэх, илрүүлэх зорилгоор “Эмийн сан” арга хэмжээг зохион явуулж, дүүргийн 9-20-р хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 28 эмийн сангийн үйл ажиллагааг шалгахад Монгол Улсын хүн амын эмчилгээнд хэрэглэх, сэтгэцэд нөлөөлөх эм, эмийн бүтээгдэхүүн худалдаалах зөрчил илрээгүй.<br>Арга хэмжээний хүрээнд СБД-ийн 15-р хороо “Зэлмэ” төвд байрлах эмийн сан нь их хэмжээгээр цэнхэр спирт иргэдэд худалдаалж байгаа талаар мэдээлэл ирсэний дагуу шалгахад зөрчил илрээгүй тул тус эмийн санд Цагдаагийн байгууллагын 6 тоот албан мэдэгдлийг хүргүүлэн, хариуг авч, үр дүнг тооцсон.</td></tr>
<tr><td rowspan="2">91</td><td rowspan="4">4.1.4. Дүүргийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, цагдаагийн байгууллагыг шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангана.</td><td>Дамбадаржаа дахь цагдаагийн хэлтсийн байрыг ашиглалтанд оруулна.</td><td>ЦХ-2</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="3">2013.12.30-ны өдөр дүүргийн цагдаагийн хоёрдугаар хэлтсийн шинэ байрны нээлтийн арга хэмжээ болж уг арга хэмжээнд Хууль Зүйн сайд Х.Тэмүүжин болон Дүүргийн Засаг даргын тамгын газрын ажилтанууд, НЦГ-ын удирдлагууд, дүүргийн иргэдийн төлөөлөл оролцсон хүндэтгэлийн арга хэмжээ явагдсан.<br>2014 оны 2 дугаар сарын 6-нд улсын комисс хүлээн авч хэлтсийн алба хаагчид ажлын шинэ байранд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд дүүргийн төсвөөс 41,3 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжөөр хангасан.</td></tr>
<tr><td rowspan="2">92</td><td>Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.</td><td>ЦХ-1,2<br>ЗЦТ</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="3">Цагдаагийн нэгдүгээр хэлтсээс Нийслэлийн цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах асуудал эрхэлсэн дэд даргын 2014 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 9в/1156 тоот Ажлын чиглэл, үүргийг алба хаагч нарт танилцуулж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Гамшгийн үед ажиллах” код 415-аар болон гамшгийн үед хэрхэн ажиллах талаар Дүүргийн онцгой байдлын хэлтсээс ахмад Н. Хишигбаатар албан хаагч нарт сургалт хийсэн. Мөн гамшгийн нөхцөл байдал үүссэн үед хэв журам сахиулах, албаны бэлэн байдлыг хангаж журмыг хэрэгжүүлж ажиллах талаар алба хаагч нарт үүрэг чиглэл өгч, гамшгийн үед ажиллах бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийж ажиллалаа. Ширүүн, усархаг бороо орж, голын түвшин нэмэгдэж байгаатай холбоотойгоор 9 дүгээр хорооны Ногоон нуурын үеийн далан дагуу хэв журмын урамшуулалт эргүүлээр 6 иргэнийг 13:00-19:00 цагийн хооронд яван эргүүл, Тамир-117 чиглэлийн офицер, цагдаа нарыг хөдөлгөөнт эргүүлийг тогтмол ажиллуулж байна. Хүн малын гоц, халдварт өвчин болон үер усны аюулын тухай мэдээ, мэдээллийг авмагц Нийтийн хэв журам хамгаалах хэлтэст нэн даруй мэдэгдэж удирдлагыг мэдээ, мэдээллээр шуурхай хангах талаар жижүүрийн хариуцлагатай зохицуулагч болон мэдээлэл хүлээн авагч нарт үүрэг чиглэлийг өгч, дуудлагаар очсон алба хаагчдад аюулгүй байдлаа хангаж, урьдчилан сэргийлж ажиллах талаар зааварчилгаа өгсөн.<br>Нийслэл хотын голын эрэг дагуу иргэд амарч зугаалах үедээ осолдож, амь насаа алдах тохиолдол бүртгэгдэж, голын түвшин нэмэгдэж байгаатай холбогдуулан ээлжийн амралт авсан алба хаагч нэг бүрт зөв зохистой амарч, өөрсдийн аюулгүй байдлыг хангах талаар зааварчилгаа өгч баталгаа гаргуулан авсан. Иргэд, олон нийтэд архи согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гол, усанд орохгүй байх, бага насны хүүхдээ хараа хяналтгүй орхихгүй байх, гарамгүй газраар</td></tr>
</table>

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | гол гатлахгүй, тээврийн хэрэгслээ гол усанд угаахгүй байх чиглэлээр TV-5, TV-1, Ийгл телевизээр сэрэмжлүүлэг өгч, 74 байр орон сууцны орцонд 223 ширхэг сэрэмжлүүлэг байршуулсан. Мөн 2 төрлийн анхааруулга, сэрэмжлүүлэг бэлтгэн хэв журмын урамшуулалт эргүүлээр ажиллаж байгаа 54 иргэнээр гудамж талбай, олон нийтийн газар, байр орон сууцны орцонд 1368 ширхэгийг тараалгуулан ажилласан. Хүн малын гоц, халдварт өвчин гарсантай холбогдуулан урьдчилан сэргийлэх чиглэлээр дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг томоохон худалдааны төв, захуудад 125 тоот албан мэдэгдлийг өгч дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран хяналт тавьж ажиллаж байна.<br>**Цагдаагийн хоёрдугаар хэлтсээс** Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх чиглэлээр "Байгаль орчин, Ногоон хөгжлийн яам"-ны холбогдох ажилтануудтай хамтран "Мод 2014", "Зөвшөөрөлгүй мод" зэрэг арга хэмжээнүүдийг зохион явуулж, иргэдээс ирүүлсэн мэдээллийн дагуу болон шалгалтаар нийт 20 зөрчил илрүүлж, холбогдох хуулийн дагуу шалгаж шийдвэрлэсэн.<br>Улсын онцгой комиссын 2014 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 1 тоот "Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний тухай" албан даалгаварыг хэрэгжүүлэх зорилгоор нийт 42 байгууллага, иргэдэд албан мэдэгдэл сэрэмжлүүлэг тараасан.<br>**Замын цагдаагийн тасгаас** Хулгайгаар мод тээвэрлэж байгаатай холбогдуулан дүүргийн цагдаагийн 2-р хэлтэстэй хамтран дулааны улиралд Шарга морьт чиглэлд явуулын пост байрлуулан 24 цагийн хяналт тавин илэрсэн зөрчил дутагдалыг харъяалалын дагуу шилжүүлж ажилласан. Мөн Дамбадаржаа руу салдаг замд байнгын постонд жижиглэнгээр болон ачааны автомашин ашиглан хулгайгаар мод тээвэрлэх тал дээр хяналт шалгалтыг эрчимжүүлэн ажиллаж байна. | | |
| 93 | | Дүүргийн хэмжээнд ажиллаж байгаа машинт эргүүлийн чиглэлүүдийг согтуурлын хэмжээг тогтоох багажаар хангана. | ЦХ-II | 70% |
| | | Тусгай зориулалтын багаж хэрэгслийг нийслэлийн төсвөөс хөрөнгө шийдүүлэхээр санал бэлтгэж байна. | | |
| 94 | 4.1.5.Хэв журам сахиулах гэмт хэрэг ба захиргааны зөрчилтэй тэмцэх ажлыг сайжруулна. | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ. | ЦХ-1,2<br>ЗЦТ | 100% |
| | | **Цагдаагийн нэгдүгээр хэлтсээс** Радио, FM 96,3, 102,5-тай хамтарч дүүргийн нутаг дэвсгэрт үйлдэгдэж байгаа автомашины эд анги хулгайлах гэмт хэрэг, халаасны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тус бүр 10 минутын шууд ярилцлаганд албан хаагч орж сэрэмжлүүлэгч өгч ажилласан. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр насанд хүрээгүй хүүхэд ахуйн хэрэглээний газ үнэрлэж байгаатай холбогдуулан 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 2,45,4,6-р сургуулийн ахлах дунд ангийн 992 сурагчдад газны хор уршгийн талаар мэдээлэл хийж ахуйн хүрээний газыг худалдан борлуулдаг 32 хүнсний дэлгүүрт албан мэдэгдэл өгч ажилласан. Энхсүндэр өрхийн эмнэлэгтэй хамтарч 2-р сургуулийн 9-11 ангийн 320 сурагчдад нийгмийн халдварт өвчний талаар болон тамхины хор хөнөөлийн талаар яриа таниулгыг хийж ажилласан. Дүүргийн 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр архи согтууруулах ундаагаар үйлчилдэг, худалдан борлуулдаг байгууллага аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах "Түншлэлийн гэрээ"-г 229 байгууллага аж ахуйн нэгжиийн удирдлагуудтай байгуулах ажлыг зохион байгуулж, 3 төрлийн 576 ширхэг санамж, сэрэмжлүүлэг тараан өгч арга хэмжээний талаар TV8 телевизэд яриа өгч, Zaluu.com сайтаар тус тус сурталчлан ажиллалаа. Хороодын Засаг дарга нарын "Байгууллага аж ахуй нэгжийн эргүүл" ажилуулах Захирамж гаргуулан "Эргүүл" тусгай арга хэмжээ зохион | | |

| | | |
|---|---|---|
| | | байгуулж 20 байгууллага аж ахуй нэгжийн 56 иргэнийг 27 гэмт хэрэг гарч болзошгүй цэгүүдэд алба хаагч нарын хамтаар ажиллуулж 6 төрлийн 210 ширхэг санамж, сэрэмжлүүлэгийг гудамж талбай, олон нийтийн газар тараан байршуулж, 65 айл өрхөөр орж 183 хүнд яриа таниулга хийн 42 автомашинд сэрэмжлүүлэг нааж, 8 хүнийг ар гэрт нь хүлээлгэн өгч, 39 мэдэгдлийг тарааж, зөрчил гаргасан 15 хүнийг 180,000 төгрөгөөр торгуулийн арга хэмжээ авч ажилласан.<br>“Иргэдийн эргүүл” тусгай арга хэмжээг 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт зохион байгуулж 14:00-19:00 цагийн хооронд гэмт хэрэг гарч болзошгүй 25 эргүүлийн чиглэлд 54 иргэнийг ажиллуулж 32 орцны жижүүрүүдийг шалгаж 32 санамж, сэрэмжлүүлэгийг тарааж ажилласан. Автобус-3 ХХК-тай хамтран Халаасны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 8 чиглэлийн 70 том оврын автобусны иргэдийн барьдаг бариулуудад нийт 700 ширхэг санамжийг байрлуулж ТҮ-8 телевизээр сурталчилсан.<br>3-р хорооны Засаг даргын ажлын албатай хамтарч 3-р хорооны иргэний танхимд 72 иргэн 8 СӨХ-ийн удирдлага 12 орцны жижүүрүүдийн дунд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр болон орон байрны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хууль сурталчилах” өдрийг зохион байгуулсан.<br>“Траншей” хэсэгчилсэн арга хэмжээг 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт зохион байгуулж 110 траншейг шалгаж 31 траншейг тагтай болгох талаар Дулааны шугам сүлжээ ХХК-уудад 8 албан мэдэгдэл өгч ажилласан. Хөрөнгө мөнгө ихээр төвлөрсөн банкны салбарууд, ШТС, байгууллага аж ахуй нэгжүүдэд гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх чиглэлээр албан мэдэгдэл 315-ыг өгч, хэсгийн байцаагч, машинт эргүүлийн алба хаагчид харуул хамгаалалтыг шалгаж заавар зөвлөмж өгч ажилласан.<br>Гадаадын иргэд ихээр зорчдог газрын ойр орчимд халаасны хулгайн гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлж, “Оюутан-цагдаа” хөтөлбөрийн дагуу ажиллаж байгаа 22 оюутныг жуулчин, гадаадын иргэдэд хуулийн зөвлөгөө сэрэмжлүүлэг тараалган ажиллуулсан.<br>“Үндэсний их баяр наадам” тусгай арга хэмжээг зохион байгуулж, дүүргийн нутаг дэвсгэрт урлаг соёл, үзвэр үйлчилгээ явагдах газар болон аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, гадаадын иргэд ихээр үйлчлүүлдэг 19 газрын судалгаа гаргаж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 117 тоот албан мэдэгдлийг өгч, “Халаасны хулгайчаас болгоомжил” сэрэмжлүүлэгийг 869 ширхэгийг тараан байршуулсан.<br>Урлаг соёлын арга хэмжээ явагддаг театруудын газруудыг эргүүлийн чиглэлд хамруулж машинт эргүүл, хэсгийн байцаагч нар үзвэр эхлэх, дуусах үеэр хяналтыг тавьж ажилласан.<br>“Бодис” тусгай арга хэмжээг 2014 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс 2014 оны 07 дугаар сарын 30-ны хооронд зохион явуулж Улсын баяр наадамтай холбогдуулан дүүргийн нутаг дэвсгэрт тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, химийн хорт бодис импортлодог, үйлдвэрлэдэг, хадгалдаг, тээвэрлэдэг, ашиглаж үйл ажиллагаа явуулдаг газруудад баярын өдрүүдэд харуул хамгаалалтыг сайжруулах талаар мөн 8 шатахуун түгээх станц болон 200 шингэрүүлсэн хийн газ ашигладаг байгууллага аж ахуй нэгжүүдийг шалгаж аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар 118 тоот албан мэдэгдлийг 217 иргэн, байгууллага аж ахуй нэгжид өгч 155 хариу авч үр дүнг тооцон ажиллалаа.<br>Иргэд, олон нийтэд архи согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гол, усанд орохгүй байх, бага насны хүүхдээ хараа хяналтгүй орхихгүй байх, гарамгүй газраар гол гатлахгүй, тээврийн хэрэгслээ гол усанд угаахгүй байх чиглэлээр TV-5, TV-1, Ийгл телевизээр сэрэмжлүүлэг өгч, 74 байр орон сууцны орцонд 223 ширхэг сэрэмжлүүлэг байршуулсан. Мөн 2 төрлийн анхааруулга, сэрэмжлүүлэг бэлтгэн хэв журмын урамшуулалт эргүүлээр ажиллаж байгаа 54 иргэнээр гудамж |

| | | |
|---|---|---|
| | | талбай, олон нийтийн газар, байр орон сууцны орцонд 1368 ширхэгийг тараалгуулан ажилласан.<br>“Харуул хамгаалалт” тусгай арга хэмжээний хүрээнд дүүргийн 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 520 иргэн, байгууллага аж ахуй нэгжид баярын өдрүүдэд харуул хамгаалалтыг сайжруулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж хариуцлагатай жижүүр томилон ажиллуулах талаар 107 тоот албан мэдэгдэл өгч, 620 ширхэг санамж тараан ажилласан.<br>Мөн гудамж талбай болон байр орон сууцны гэмт хэрэг гарч болзошгүй харанхуй гэрэлтүүлэггүй 39 газрын судалгааг гаргаж Дүүргийн Засаг даргын Тамгын газарт санал хүргүүлсэн. Гэмт хэргийн замаар алдагдсан эд зүйлийг олж тогтоох зорилгоор “Ломбард” нэгдсэн арга хэмжээг 2014 оны 10 дугаар сарын 06-наас 20-ны өдрүүдэд зохион байгуулан 52 барьцаалан зээлдүүлэх газрын үйл ажиллагааг шалгаж, шинэчилсэн бүртгэл судалгааг хийж фото зургаар баримтжуулан ажилласан.<br>Дүүргийн 1-8 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийт 42 ломбард үйл ажиллагаа явуулж байсныг шалгаж зөвшөөрөлгүй, харуул хамгаалалт, дохиолын системгүйгээр  үйл ажиллагаа явуулж байгаа газруудад албан мэдэгдэл өгч ажиллалаа.<br>Дүүргийн 1-8 дугаар хорооны ерөнхий боловсролын сургууль дээр ажиллаж байгаа “School police” хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр 2014 оны 10 дугаар сарын 20-ноос 27-ны өдрүүдэд “School police” тусгай арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. Энэ хугацаанд 1-8 дугаар хорооны “School police” хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа 29 сургуулийн үйл ажиллагааг шалгаж эргүүлийн хуваарь, рапортын дэвтэртэй танилцан, эргүүлээр ажиллаж байгаа эцэг эхчүүдтэй уулзаж тэдний санал хүсэлтийг сонсож 28 иргэнээс санал хүсэлтийг авч газар дээр нь түргэн шуурхай шийдвэрлэсэн.<br>“Барилга байгууламж” тусгай арга хэмжээг зохион байгуулан одоогоор 1-8 дугаар хорооны нутаг дэвсгэрт 57 барилга баригдаж байгаагаас 11 барилгын үйл ажиллагаа зогссон байна.<br>Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр, Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр бэлтгэсэн шторкуудыг урьдчилан бэлтгэж, өдөрлөгийн үеэр LED телевизээр гаргаж, цагдаагийн алба хаагчдын хувцас, тусгай хэрэгслээр үзүүлэн гаргаж сурталчилсан.<br>**Цагдаагийн хоёрдугаар хэлтсээс** гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, иргэдийг аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бий болгоход цагдаагийн байгууллага, иргэдийн хамтын ажиллагааны чадавхийг сайжруулах, энэ үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах зорилгоор дүүргийн 10-20 дугаар хорооны нутаг дэвсгэрт дүүргийн “Хэв журмын урамшуулалт эргүүл”, “Бүх нийтийн эргүүл”, “Оюутан эргүүл” зэргийг дүүргийн 9-20 дугаар хорооны нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй эмзэг цэг газруудад зохион байгуулан ажиллаж байна.<br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, төрийн байгууллага болон их дээд сургуулийн оюутан сурагчид, урамшилт эргүүл ажиллуулсанаар тухайн газар нутгийн байршил,  гэмт хэрэг, зөрчил гарч болзошгүй цаг хугацаа, эмзэг цэг, бүлэг бөөгнөрөл үүсгэж болзошгүй иргэдийн талаарх мэдээ, мэдээллийг авч, эдгээртэй уялдуулан эргүүлийн байршлыг тогтмол шинэчлэн ажиллаж байна.<br>Алба хаагч нараас хариуцсан нутаг дэвсгэрт байрлах ерөнхий боловсролын нийт 12 сургуулийн 12,000 гаруй сурагчдын дунд давхардсан тоогоор 25 гаруй удаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийж, сургуулийн сурагчдын өөрсдийн үүсгэл санаачлагын байгууллага, өсвөрийн цагдаагийн бүлгэмийн сурагчдын үйл ажиллагааг дэмжин, хууль эрх зүйн зөвлөгөөг байнга өгч байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Мөн хичээл орох, тарах цагуудад сургуулийн орчим эргүүл, шалгалтыг тогтмол зохион байгуулж, сургуулийн орчинд зохион байгуулагдаж байгаа аливаа арга хэмжээний дэг журмыг хангах ажилд сургуулийн өсвөрийн цагдаагийн бүлгэмийн сурагчдыг татан оролцуулж байна.<br>Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргын 2013 оны 10 дугаар сарын 25-ны өдөр баталсан “Сургуулийн орчинд үүрэг гүйцэтгэх School police эргүүлийн ажиллах журам”-ын хэрэгжилтийг хангах, эргүүлийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахтай холбогдуулан дүүргийн 10-20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах ерөнхий боловсролын 10 сургуулийн захирал, сурагчдын зөвлөлийн дарга, цагдаагийн байгууллагын хамтарсан гурвалсан гэрээг 2014 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр байгуулсан.<br>Сургуулийн орчинд эргүүлийн үүрэг гүйцэтгэн ажиллаж байгаа иргэнд хороо хариуцсан хэсгийн байцаагч нараас мэргэжлийн удирдлагаар хангаж, ерөнхий боловсролын сургуулийн орчинд сурагчдыг гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөх, хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд сурагчдын эцэг, эхийг татан оролцуулах ажлыг сургуулийн захиргаатай хамтран тогтмол зохион байгуулж, 220 удаагийн эргүүлийн үйл ажиллагааг өглөөний ээлж 07 цаг 30 минутаас 13 цаг 30 минут хүртэл, өдрийн ээлж 13 цаг 30 минутаас 19 цаг 30 минут хүртэл тус бүр 2 хүн оролцуулан сургуулийн орчимд эргүүлд ажиллуулж байна.<br>**Замын цагдаагийн тасгаас** Дүүргийн хөдөлмөр халамжийн хэлтэстэй хамтран эрсдэлтэй цэгийн судалгаа гарган нийт 20 цэгт 40 хөдөлгөөний аюулгүй байдлын туслах ажилтаны маршрут төлөвлөгөө гарган ажиллаж байна. Зуслангийн замд хөдөлгөөний ачаалал, зам тээврийн осол, хэрэг буурахгүй байгаа талаар хийгдэж буй ажил, үр дүнгийн талаар ETB, UBS,HD Монгол тв, МН25-р, Боловсрол тв-үүдэд мэдээ мэдээлэл сэрэмжлүүлэгийг иргэд олон нийтэд өгч ажиллалаа. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын сургуулиудын орчим School Police ажлуулж хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан хэрэгжилтэнд тогтмол хяналт тавьж ажиллаж байна. | | |
| 95 | | Гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг арилгуулахаар байгууллага, аж ахуйн нэгжид өгсөн албан даалгавар, мэдэгдэл, шаардлагын хэрэгжилтийг тооцож ажиллана. | ЦХ-1,2 | 100% |
| | | Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллага аж ахуй нэгжид 2500 албан мэдэгдэл шаардлага өгч мэдэгдлийн мөрөөр тодорхой ажил зохион байгуулаагүй 115 аж ахуй нэгж иргэнд.550,000 төгрөгний торгууль ногдуулж үр дүнг тооцлоо.<br>Гэмт хэрэгтэй тэмцэх тасгаас гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар 136 мэдэгдэл бичиж, 120 мэдэгдлийн хариуг авч биелэлтийг тооцон ажилласан.<br>Хэв журам хамгаалах тасгаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 32 удаагийн хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд 880 албан мэдэгдлийг аж ахуйн нэгж байгууллага, иргэнд өгч 760 мэдэгдэлийн хариуг авч 5000 санамж, сэрэмжлүүлэг тарааж, биелэлт, үр дүнг тооцож ажилласан байна. | | |
| 96 | | Цагдаагийн 2 дугаар хэлтсийн төв байранд иргэдийг хүлээж авах танхим байгуулж, оршин суугч иргэд, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл оролцсон уулзалт, зөвлөгөөнийг улирал бүр зохион байгуулж, гаргасан санал хүсэлтийн дагуу зохион байгуулсан ажлын талаар эргэж мэдэгдэж байна. | ЦХ-2 | 100% |
| | | Иргэдэд зориулсан иргэний танхимыг бүрэн тохижуулж, нийт 235 аж ахжйн нэгж байгууллагыг хүлээн авч уулзалт зохион байгуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамтран ажиллах гэрээг байгуулсан. Гэрээг дагуу улирал бүр дүгнэж үр дүнг тооцон ажиллаж байна. Иргэний танхимд байрлуулсан зурагтаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | сэрэмжлүүлэг, анхааруулга болон албан хаагчдын мэдээллийг тогтмол явуулж байна. | | |
| | | ***4.2. Иргэндээ ээлтэй эрүүл, аюулгүй, тохилог орчин бүрдүүлэх чиглэлээр:*** | | |
| 97 | 4.2.1 Нийтийн эзэмшлийн гудамж, талбай, явган зам, нийтийн үйлчилгээний газруудад гэрэлтүүлэг, аюулгүй байдлын хяналтын сүлжээ бий болгоно. Нийтийн эзэмшлийн газрыг баталгаажуулж, иргэдэд нийцсэн байдлаар тохижуулна. | Гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлж нийтийн эзэмшлийн гудамж талбай, орон сууцны хороолол, гэр хорооллын гудамж талбайн гэрэлтүүлэггүй гудамж талбайд LED гэрэлтүүлэг шинээр хийнэ. | ДБТХ | 100% |
| | | “Төгс гэрэлтүүлэг” ХХК, “Гэгээ групп” ХХК-ний 1, 5, 7, 8, 10, 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хийсэн лед гэрэлтүүлгийг улсын комисс хүлээн авах ажлууд зохион байгуулагдсан. Мөн 1-10 хороонд 167 байршилд НХОГ-аас хяналт тавьж гэрэлтүүлэг шинээр тавьсан. 12, 14 дүгээр хороонд “Новел нэтворк” ХХК 51 гэрэлтүүлэг, 15 дугаар хороо ар хустайд “Т.Болд” ХХК 37 байршид эрчим хүчний Лед гэрэлтүүлэг шинээр тус тус тавьсан болно. | | |
| 98 | | Нийтийн эзэмшлийн гудамж талбай, орон сууцны хороолол, гэр хорооллын гудамж талбайн гэрэлтүүлгийн шонгуудыг кодлож бүртгэлжүүлнэ. | ДБТХ | 90% |
| | | Гүйцэтгэгч байгууллагыг сонгон шалгаруулж 2015 онд хийхээр болсон. Бэлтгэл ажлууд хангагдсан болно. | | |
| 99 | | Нийслэл, дүүргийн гудамж талбайг теле-камерын хяналтын системд хамруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна. | ЦХ 1, 2 | 100% |
| | | **Цагдаагийн нэгдүгээр хэлтсээс** гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор харанхуй, гэрэлтүүлэг тавих шаардлагатай 35 орон сууц, 15 гудамж талбай орчмын судалгааг гаргаж Дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж гэрэлтүүлгийн асуудлыг шийдвэрлэх талаар саналыг оруулсан. Дүүргийн 1-16 дугаар хорооны нутаг дэвсгэрт “Нийслэлийн бүтээн байгуулалтын хүрээнд “Теле хяналтын систем суурлиулах ажлын зураг төсөв боловсруулж угсралтын ажил” гүйцэтгэх нэртэй СБД-ХААА/УЭШ13-001-030 ялгах дугаартай тендэр зарлаж “Сек-тек” ХХК шалгаран 2013 оны 11 дүгээр сараас 2014 оны 05 дугаар сарын хооронд 814,000,000 төгрөгөөр Тайваны “Surveon” фермын 3х камерийг 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт гэмт хэрэг гардаг, гарч болзошгүй 71 цэгт 142 ширхэг 1 чигийн камер суурлиулан, хэлтсийн байранд 55 инчийн 4 ширхэг дэлгэц, 5 иж бүрэн комьпютер, 1-9 дүгээр хорооны хэсгийн байцаагч нарын өрөөнд 1 ширээ, иж бүрэн компьютер байрлуулж “Хяналтын нэгдсэн төв”-ийн болон серверийн өрөөг бүрэн тохижуулсан. Одоогоор камерын хяналтын төвийг бүрэн хүлээж аваагүй, 2 алба хаагчийг 08:00-20:00 цагийн хооронд электрон эргүүлээр ажиллуулж байна. “Сек-тек” ХХК-ны ерөнхий менежрээр алба хаагч нарт сургалт зохион байгуулж камерын хяналтын журам боловсруулан ажиллаж байна.<br>**Цагдаагийн хоёрдугаар хэлтсээс** Дүүргийн Засаг даргын 2013 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 267 дугаар захирамжаар улсын төсвийн хөрөнгийн эх үүсвэрээр дүүргийн нутаг дэвсгэрт гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэхэд зориулж 10-16 дугаар хорооны нутаг дэвсгэрт теле хяналтын систем, камержуулалтын ажлыг эхлүүлж, 54 цэгт 108 камер суурилуулан ажиллагаанд оруулсан.<br>Цаашид 10-20-р хорооны нутаг дэвсэрийн 47 цэгт камер байрлуулах талаар саналаа хүргүүлж, техникийн нөхцлийг судлах ажлыг эхлүүлээд байна. | | |
| 100 | | Нийтийн эзэмшлийн орон сууцанд засвар үйлчилгээ хийнэ. | ДБТХ | 100% |
| | | ДОНХС-аар: Өргөн СӨХ-ны 31 дүгээр байр, Дэлгэр 81 СӨХ-ны 30 дугаар байр, баянбулаг 6 СӨХ-ны 4 дүгээр байр, Орд 789 СӨХ-ны 7 дугаар байрны 6, 7 дугаар орц, Хилчин СӨХ-ны 37 дугаар байр, Геодези 21 СӨХ-ны 21 дүгээр байр<br>ДОНТ-өөр: Өндөр өргөө СӨХ-ны 3 дугаар байр, Өгөөж СӨХ-ны 39,40 дүгээр байр, Бүрэн СӨХ-ны 45-47, 48 дугаар байр, Улаан байшин СӨХ-ны 21б байр, Эхлэл 2 СӨХ-ны 8 дугаар байр, Харш-10 СӨХ-ны 10 дугаар байрны 2-9 дүгээр орц, Уламдэлгэрэх СӨХ-ны 52 дугаар байр, Жаран дөрөв СӨХ-ны 10 дугаар байр, Хилчин СӨХ-ны 19 дүгээр байр, Хотхон | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | СӨХ-ны 18, 25, 38 дугаар байр орон сууцны байрны дээвэр Аврах гал унтраах 34 дүгээр анги нийт 21 байрны дээвэр засварлахаас Аврах гал унтраах 34 дүгээр анги, Өндөр өргөө СӨХны 3 дугаар байр, Эхлэл 2 СӨХ-ны 8 дугаар байр, Уламдэлгэрэх СӨХ-ны 52 дугаар байр, Бүрэн СӨХ-ны 45-47, 48 дугаар байр, Харш 10 СӨХ-ны 10 дугаар байрны дээврийн ажил бүрэн дуусч комисс хүлээн авсан. | | |
| 101 | 4.2.2 Сургууль, цэцэрлэгийн орчинд зам тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг автобусаар авч, хүргэж өгөх хөтөлбөр санаачилна. | Дүүргийн ИТХ-ын 109 дүгээр тогтоолын дагуу сайн дурын зохицуулагч ажиллуулна. | НХХ, ЗЦТ | 100% |
| | | Сургууль, цэцэрлэгийн хичээл цуглах, тарах үед замын хөдөлгөөн зохицуулах зорилгоор хүүхдүүдийг гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлж, гэмт хэрэг, захиргааны зөрчил гарсан тохиолдолд мэдээллийг цагдаагийн байгууллагад даруй мэдэгдэх үүрэгтэй сайн дурын зохицуулагч болон "School police" эцэг, эхийн эргүүл 07.30-13.30, 13.30-19.00 цагийн хооронд хоёр ээлжээр ажиллаж байна. НБГ, НЗЦГ-тай хамтран Ерөнхий боловсролын 1, 2, 3, 4, 6, 11, 16, 25, 29, 31, 35, 45, 58, 71, МОХ сургууль, МЭХ, АЗЭС, БТСДС сургуулиудын захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, эцэг эх, сурагчийн төлөөлөл нийт 84 оролцогчдод 2014 оны 01 сарын 14-нд "SCHOOL POLICE" сургалт зохион байгууллаа.<br>"SCHOOL POLICE" төслийг идэвхижүүлэх зорилгоор "Дэвжээ" тэмцээний финалын шалгаруулалт 2014.11.17-ны өдөр Улаанбаатар чуулгад зохион байгуулагдлаа. | | |
| 102 | | Алслагдсан сургуулийн хүүхдийг тээвэрлэх асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэнэ. | НХХ | 100% |
| | | Нийслэлийн Боловсролын Газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 35, 71 дүгээр сургуульд нэг бүр нь 90,0 сая төгрөгийн өртөг бүхий хүүхэд тээвэрлэх автобус олгосон. | | |
| 103 | 4.2.3 Явган зорчигчийн гүүрэн болон нүхэн гарцуудыг барьж байгуулна. | Гэр хорооллын далан дээгүүр явган хүний гүүр хийнэ. | ДБТХ | 100% |
| | | Дүүргийн ОНХСХ-р 16 дугаар хороо Ойчдын 1 дүгээр гудамжинд Ардчилал -16 Иргэдийн бүлэг явган хүний гүүр хийх ажлыг гүйцэтгэн ашиглалтанд хүлээлгэн өгөөд байна. 15 дугаар хороонд иргэдийн бүлгийн хийх явган хүний гүүрийн ажил гүйцэтгэлийн шатандаа явж байна. | | |
| 104 | | Хөдөлгөөний нягтрал ихтэй уулзварууд дээр явган зорчигчийн гарцыг шийдэж өгнө. | ДБТХ | 100% |
| | | 100 айлын гүүрэн гарцын тендерт ''ЗМЗ''ХХК шалгарсан. Явган хүнд зориулсан энэхүү гүүрэн гарцыг 09 дугаар сарын 02-нд ашиглалтад хүлээлгэж өгсөн. | | |
| 105 | 4.2.4 Дүүрэгт явган зорчигчийн гудамжийг бий болгож, тохижуулна. Цэцэрлэг хүрээлэн байгуулах замаар иргэдийн амрах тухтай орчинг бий болгоно. | Хотын төв, хороолол доторх элэгдэлд орсон гудамж талбайг шинэчилж засварлана. | ДБТХ ЗЦТ | 100% |
| | | Дүүргийн хэмжээнд 2014 онд зайлшгүй засварлах шаардлагатай авто замын судалгааг гаргаж, дүүргийн Засаг даргын албан тоотоор Нийслэлийн Засаг даргад холбогдох саналыг хүргүүлснээр улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хотын төвийн элэгдэлд орсон 1700м2 км авто замыг шинээр болон шинэчлэн засварлалаа. Үүнд:<br>Сөүлийн гудамжинд 300м2 авто замын засврын ажлыг ''Шаргын зам'' ХХК, Хүүхдийн паркийн хойд талаар 400м2 авто замын засврын ажлыг ''Арвин хангай'' ХХК,Содномын гудамжинд 300м2 авто замын ажлыг ''Өвгөдийн жим'' ХХК, Цагдаагийн гудамжинд 400м2 авто замын ажлыг ''Очир Тэнхлэг'' ХХК, Нарны зам дээр 300м2 авто замын засварын ажлыг ''Өргөн говь'' ХХК, 1-р хороо Чойдогийн гудамж, Улсын нийтийн номын сангийн уулзвараас Улсын клиникийн 1-р эмнэлэг хүртэлх замын өргөтгөл шинэчлэлтийн ажлын тендерийг зарлаж ДИ ВАЙ КЭЙ ххк шалгарч уг ажлын гүйцэтгэгчээр ажиллаж байна. /дуусах хугацаа-2014.09.25/, 6-р хороо 25,26 дугаар байрны өмнөх /хороолол доторх/ / | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | авто замын, 1-р хороо 25 дугаар байрны өмнөх /хороолол доторх/ 150м авто замын шинэчилэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>-1-р хороо Авто замчдын гудамжны 2 байршилд асфальтан нөхөөс, Сэлхийн авто замын нөхөөс, Энхтайваны өргөн чөлөөнд авто замын нөхөөсний ажлыг хийж гүйцэтгэсэн, 2,6 км замд авто замын хэвтээ тэмдэглэл, 178 ширхэг тэмдэг шинээр хийж 73 тэмдэгийг нөхөн сэргээлээ.<br>-Олимпийн гудамж, ЭМЯ-ны баруун талын замд борооны ус зайлуулах шугамыг шинээр хийж гүйцэтгэсэн.<br>-2013 онд Авто замчдын гудамжинд хийсэн авто замын сэтэлгээний ажлыг чанар муутай гүйцэтгэсний улмаас зорчих хэсэгт эвдрэл гарсныг Цогц зам ххк асфальтан хучилт хийж нөхөн сэргээх ажлыг хийж гүйцэтгэв.<br>-8-р хороо Бээжингийн гудамж, МУИС-н 2-р байрны зүүн урд уулзвараас сэлбийн гүүр хүртэлх замын өргөтгөл шинэчлэлтийн ажлын тендерийг зарлаж Бээжин констракшн инженеринг групп ххк шалгарч уг ажлын гүйцэтгэгчээр ажиллаж байна.<br>-Чингэлтэйн өргөн чөлөө 6-н буудалд байрлуулсан стандарт бус хурд сааруулагчийг шинэчлэх талаар албан тоотоор мэдэгдэл өгсний дагуу Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл ОНӨААТҮГ шинээр стандартын дагуу хурд сааруулагчийг хийж гүйцэтгэсэн. | | |
| 106 | | 5 сургууль цэцэрлэгийн орчныг эко орчин болгож тохижуулна. | ДБТХ | 100% |
| | | Дүүргийн ерөнхий боловсролын 2 сургууль, 3 цэцэрлэгийг эко сургууль цэцэрлэг болгох ажил дүүргийн орон нутгийн хөгжил сангийн хөрөнгөөр хийгдэж дүүргийн 25, 150 дугаар цэцэрлэг, Ерөнхий боловсролын 31, 58 дугаар сургуулиудыг эко сургууль , цэцэрлэг болгох ажлын гүйцэтгэл 100% дуусч ашиглалтанд хүлээн авлаа. Гүйцэтгэгчээр Инженерийн авьяас ХХК ажиллалаа. | | |
| 107 | | 2 сургууль, 2 цэцэрлэгийн гадна талбайг иж бүрэн тохижуулна. | ДБТХ | 100% |
| | | Дүүргийн ОНХСХ-өөр 25, 150 дугаар цэцэрлэгүүд, ЕБоловсролын 31, 58 дугаар сургуулиудад явган зам тавих, ногоон байгууламжийг нөхөн сэргээх, мод бут тарих ажлыг Инженерийн авьяас ХХК гүйцэтгэж байна. | | |
| 108 | | Хороодод ногоон байгууламж, спорт тоглоомын талбай, явган хүний зам зэрэг тохижилтын ажил хийнэ. | ДБТХ | 100% |
| | | Тохижилт бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж байна. 6 дугаар хорооны 27 дугаар байрны дундах талбай, 10 дугаар хорооны 17, 36 дугаар байрны урдах талбайн бичил тохижилтын ажлууд 100 хувь хийж гүйцэтгэн ашиглалтанд хүлээлгэн өгөөд байна. | | |
| 109 | 4.2.5.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг нэмэгдүүлнэ. | 3, 4, 8, 10, 12, 13, 14, 15, 17, 18, 19, 20 дугаар хороодын ажлын байр, 29 дүгээр сургуулийн байранд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу зам, зориулалтын шат, шатны бариул хийнэ. | НХХ | 100% |
| 110 | | 3, 4, 8, 10, 12, 13, 14, 15, 17, 18, 19, 20 дугаар хороодын болон 29 дүгээр сургуулийн байранд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор налуу зам, шат, шатны бариул хийлгэх саналыг шаардагдах төсвийн хамт дүүргийн ЗДТГ-ын Эдийн засаг төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн. Энэ ажлын хүрээнд Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төвтэй хамтран 3, 4, 8, 10, 12-15, 17-20 дугаар хорооны нийгмийн ажилтан, хэсгийн ахлагчид, 29 дүгээр сургуулийн нийгмийн ажилтан нийт 62 хүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан.<br>Дүүргийн ЗДТГ-ын НХХ-ийн хэлтсийн дарга С.Сайнбаяр, төсөвчин н.Батцэндтэй хамтран 4,14,15 дугаар хороодын ажлын байранд налуу шат хийхээр хэмжилт хийж, зураг төсөв гаргаж байна. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөгжүүлэхэд анхаарч урлаг, спортын олон улсын уралдаан тэмцээнд оролцох эрх авсан иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ | НХХ | 100% |
| 111 | | Дүүргийн 11-р хорооны иргэн, Параволейболын шигшээ багийн тамирчин С.Төмөрсүх АНУ-д дасгал бэлтгэл, нөхөрсөг тоглолтонд оролцоход дүүргийн Засаг даргын 2014 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/73 дугаар захирамжаар 800.000 төгрөг, Иран улс явахад дэлхийн зөн ОУБ-аас 1.500.000 төгрөг, 13 дугаар хорооны иргэн Б.Эрдэнэтөгсөд БНХАУ-д болох тэмцээнд оролцоход нь 1.200.000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. | | |
| | | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулиудын үйл ажиллагааг дэмжиж ажиллана. | БХ | 100% |
| | | Хараааны бэрхшээлтэй хүүхдийн 116 дугаар сургуулийн 1 давхрын засварыг Японы засгийн газрын “Өвсний үндэс” төслөөс 28,9 сая төгрөгөөр санхүүжүүлж засварыг 2013-2014 он дамжуулан Од-Орд ХХК гэрээгээр гүйцэтгэлээ.<br>29 дүгээр сургуулийн дулааны засварт улсын төсвөөс 126 сая, 25, 29, 116 дугаар сургуулиудад тус бүр 100 сая төгрөгийн 24 хүний суудалтай хүүхдийн автобусыг нийслэлийн төсвөөс,<br>29 дүгээр сургуулийн 311 сурагчдад Ард санхүүгийн байгууллага дүрэмт хувцас бэлэглэж, Эко констракшн ХХК номын сан, мэдээлэл зүйн кабинетыг засварлан, ширээ, сандал проектор өгч дэмжлэг үзүүллээ.<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд амжилттай сургаж буй сургууль, багшийн туршлагыг дэлгэрүүлэх сурталчлах ажлыг зохион байгууллаа. | | |
| 112 | | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтанд сургаж, төсөл хөтөлбөрт хамруулан зээл олгож, ажлын байраар хангана. | ХХ | 100% |
| | | Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвийн захирлын баталсан удирдамжийн дагуу дүүргийн хэмжээнд санхүүгийн дэмжлэгийн зар мэдээг иргэдэд хүргэн 80 гаруй иргэнд хэлтсээр зөвлөгөө мэдээлэл өгч, иргэдэд хөтөлбөрийн талаар танилцуулж, үүний үр дүнд нийт 40 сая төгрөгийн хүрээнд 65 төсөл хүлээн авч сонгон шалгаруулалт явуулж үйл ажиллагаатай нь газар дээр нь очиж танилцан 35 төсөл дэмжин үүнээс 42 ажлын байр гаргасан. Гарсан ажлын байранд 40 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн сургалтанд 3 иргэнийг үнэ төлбөргүй сургалтанд хамруулж байна. Санхүүгийн дэмжлэг авсан иргэдийг 3 удаагийн үзэсгэлэн худалдаанд хамруулсан байна. | | |
| 113 | 4.2.6. Эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй чанартай болгох, түргэн тусламжийн 103 үйлчилгээг байгуулна. | Эрүүл мэндийн нэгдэл, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг нэмэгдүүлнэ. | НХХ<br>ХААА | 100% |
| | | Дүүргийн ИТХ-ын 2013 оны 7/31 дүгээр тогтоолын дагуу 432,0 сая төгрөг шийдвэрлэж, тендерт шалгарсан Ашид буян, Баянгол мед ХХК-аас Эрүүл мэндийн нэгдэл болон Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 41 төрлийн эмнэлгийн тоног төхөөрөмж, тавилга, хэрэгслийг нийлүүллээ.<br>-Сүхбаатар дүүргийн ИТХ-ын төлөөлөгч Э.Ганбатын санаачлагаар JCIMongolia, JCI KOREA хамтарсан байгууллагын төслийн хүрээнд 15-20 дугаар хороодын ӨЭМТ-ийн эмч цусны даралтын аппарат, чихрийн шижин илрүүлэгч, халуун хэмжигч бэлэглэв.<br>-Шинээр баригдсан Клиник сувилалд эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах тендер зарлагдсан. | | |
| 114 | | Сүхбаатар ЭМН-д хүүхдийн түргэн тусламжийн автомашин олгоно. | ЭМН | 100% |
| | | -Нийслэлийн Засаг даргын 2013.12.03-ны А/1055 дугаар захирамж, нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2014.05.26-ны өдрийн А/57 дугаар тушаалын дагуу ЭМН-д 4 төрлийн аппаратаар тоноглогдсон хүүхдийн түргэн тусламжийн 84,9 сая төгрөгийн өртөг бүхий Hyundai STAREX H-1 AMBULANCE маркийн автомашин олгосон. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | -Дүүргийн Засаг даргын 2014.03.13-ны өдрийн А/97 дугаар захирамжаар 26,190,0 төгрөг шийдвэрлэж, Эрүүл мэндийн нэгдэлд дуудлага үйлчилгээний автомашин Mitsubishi delica маркийн бага оврын микробус олголоо. | | |
| 115 | | Дамбадаржаа дахь салбар амбулаторийн барилгыг засварлана. | ЭМН | 100% |
| | | Нийслэлийн төсвийн 60,625,187 төгрөгийн хөрөнгөөр Салбар амбулатори №2-ын барилгын иж бүрэн засварын ажлыг “Тамга өргөө” ХХК гүйцэтгэлээ.<br>Дамбадаржаа дахь Салбар амбулатори №2-ын барилгын засварыг НХААГ, НХОГ-аас тендерт шалгарсан “Тамга өргөө” ХХК ЭМЯ-ны 2014 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалт 60,6 сая төгрөгийн төсөвт өртгөөр 2014 оны 5- 8 дугаар сард хийж гүйцэтгэсэн. | | |
| 116 | | Эрүүл мэндийн нэгдлийн салбар амбулатори-1-ийн хуучин барилгыг шинэчлэх зураг төсвийг хийлгэнэ. | ЭМН | 90% |
| | | Нийслэлийн төсвийн 101,577,322 төгрөгийн хөрөнгөөр Салбар амбулатори №1-ийн барилгын сантехник, цахилгааны иж бүрэн засварын ажлыг “Тамга өргөө” ХХК, гүйцэтгэлээ.<br>- НХААГ, НХОГ-аас тендерт шалгаруулсан “Тамга өргөө”ХХК Салбар амбулатори №1-ийн дотор сантехникийн засварын ажил 2014 оны 5-8 дугаар сард хийгдсэн. ЭМС-ын багцад батлагдсан төсөвт өртөг 101.6 саятөгрөг.<br>- Салбар амбулатори №1-ийн хуучин барилгыг шинэчлэх, зураг төсвийг хийлгэх талаар 2015 оны саналд тусгасан. | | |
| 117 | | Саажилттай хүүхдийг хамгаалах чиглэлээр тодорхой ажил хийнэ. | ЭМН, НХХ | 100% |
| | | 2014 оны 1-р улиралд “Саажилтай хүүхдийг эрт илрүүлэх” сэдэвт өдөрлөгийг ЭМН-ийн байранд зохион байгуулав. Өдөрлөгийн үеэр нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өөрөө өөртөө туслах “Таван хуруу” бүлгийн эсгий урлалын үзэсгэлэн худалдаа, Тусгай 116 дугаар сургуулийн сурагчид оролцсон.<br>2 дугаар улиралд ЭМЯ-Италийн засгийн газрын бус АИФО байгууллага, Европын холбоотой хамтран хэрэгжүүлж буй “Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэмшүүлэхэд туслах” төслийн хүрээнд ЭМН-д “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сэргээн засах өрөө”, “ Нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн төв” шинээр нээн MOGUL LED 32 инчийн телевиз, MOGUL LED 32 инчийн телевизийн тогтоогч, зөөврийн компьютер, сургалтын ширээ 5 ширхэг сургалтын сандал 10 ширхэг, гурвалжин тамблформ, дөрвөлжин тамблформ , хагас саран хэлбэрийн тамблформ, конус тамблформ, паралельграмм тамблформ, бөмбөг /том, дунд, жижиг/ дэвсгэр, авирдаг шат, паралель баар, далайцын дугуй, тавцант сандал, булангийн сандал, зогсоогч сандал нийт **4085186 төгрөгийн** тоног төхөөрөмж хандивласан. Сэргээн засах өрөө шинээр нээсэнтэй холбогдуулан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гэр бүлийн орчинд сэргээн засах нь” сэдвээр саажилттай хүүхдийн эцэг эхэд сургалт явуулж, харвалтын дараа, хүүхдийн тархины саа, хүзүү нуруу, мөр тохой, өвдөг түнхний үений хөдөлгөөн засал эмчилгээнд 95 хүнийг давхардсан тоогоор 359 удаа эмчилгээнд хамруулсны үр дүнд эдгэрсэн-18,9%, сайжирсан-73,6% байна.<br>ЭМНэгдлээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор, тэргэнцэртэй иргэдэд зориулсан гадна налуу замыг шинээр хийж, встулын орох хаалгыг довжоогүй болгож засварласан.<br>АИФО төрийн бус байгууллагын санхүүжилтээр Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан “Сэргээн засалтын кабинет”-ыг шинээр нээлээ. Тус кабинетаар 15 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гэр бүлийн орчинд сэргээн засах" сэдэвт 7 хоногийн сургалт явуулж, асран хамгаалагч, эцэг эхчүүдэд мэдлэг олгон чадавхжуулсан. | | |

<table>
<tr><td rowspan="2">118</td><td rowspan="4">4.2.7. Дүүргийн спортын ордон байгуулж, дугуйн болон гүйлтийн зам, мөсөн гулгуурын талбай шинээр барьж иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцө-лийг бүрдүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.</td><td>Монголын бүх ард түмний спартакиадыг дүүргийн хэмжээнд зохион байгуулна.</td><td>БТСХ</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="3">-Монголын Үндэсний спортын V их наадмын хүрээнд явагдсан шагайн харвааны тэмцээнд 10 багийн 90 харваач оролцож, Д.Арсэд, С.Энхтөр, С.Батбаяр ахлагчтай баг эхний 3 байрт шалгарлаа. Дүүргийн аварга шалгаруулах уламжлалт харваачдын анхдугаар нээлттэй тэмцээнд 5 зайд 5 төрлийн байд тус бүр 5 сум тавин нийт 41 харваач оролцсон өрсөлдлөө.<br>-Иргэдийн спортын III наадмыг спортын 8 төрлөөр 2014 оны 03 дугаар сараас 11 сарын хооронд нийслэл, дүүргийн хэмжээнд 5 үе шаттайгаар зохион байгуулж, 12000 иргэд хамрагдсан. Наадмын нэгдсэн дүнгээр Сүхбаатар дүүрэг гуравдугаар байр, шилдэг хороогоор Ш.Батдорж даргатай 19-р хороо шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнуулсан.</td></tr>
<tr><td rowspan="2">119</td><td>Цэцэрлэгийн хүүхдүүдийг уран хөдөлгөөнт гимнастикаар эрүүлжүүлэх, уралдаант тэмцээн зохион байгуулна.Сурагчдыг чийрэгжүүлэх бялдаржуулах төв байгуулна.</td><td>БТСХ<br>НХХ</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="3">Дүүргийн аварга шалгаруулах сургууль, цэцэрлэгийн насны хүүхдүүдийн уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээнийг 2014 оны 3,4 дүгээр сард 2 дугаар сургууль дээр зохион байгуулж, 6 цэцэрлэг хамрагдсанаас эхний 3 байранд 135, 51, 143-р цэцэрлэгүүд шалгарлаа. Ерөнхий боловсролын сургуулийн 150 гаруй сурагчид оролцож, хөгжим хөдөлгөөний мэдрэмж, хурд, хүч, авхаалж самбаагаа сорилоо.</td></tr>
<tr><td rowspan="2">120</td><td rowspan="6">4.2.8 Иргэдийг өвчлөлтөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлж, хороодын Өрхийн эрүүл мэндийн төвийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.</td><td>Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, өдөрлөг зохион байгуулна.</td><td>ЭМН<br>НХХ</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="3">"Сүхбаатар" эрүүл мэндийн нэгдлээс Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг эрчимжүүлэх зорилгоор "Эрүүл зан үйл төлөвшүүлэх, мэдээлэл сургалт сурталчилгааны ажил"-ын 25 заалттай төлөвлөгөө гарган ЭМН-ийн даргаар баталгаажуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. 2014 оны эхний хагас жилд Иргэдэд эрүүл_мэндийн боловсрол олгох, сургалт сурталчилгаа, өдөрлөгийн үр дүнд: Өдөрлөг 33, сургалт 569, сургалтанд хамрагдсан хүний тоо 33057, үе тэнгийн сургагч багшаар 512, сайн дурын идэвхтэн 89 бэлтгэгдсэн.<br>"Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих жил", "Эх хүүхэд бүрт хүрч үйлчилье", "Сувилагчийн нэг өдөр", "Хороо ӨЭМТ хамтдаа" аяны хүрээнд олон ажил зохион байгуулж ажилласны үр дүнд 2013 оны эхний хагас жилтэй харьцуулахад мэдээлэл сургалт сурталчилгааны хэрэгжилт 51%-р дээшилсэн.<br>Хэвлэл мэдээллийн хэрэгслээр: LIKE HD телевизтэй бүтэн жилийн гэрээ байгуулан 7 хоног бүрийн лхагва гаригт шууд нэвтрүүлэг, 7 хоногт 3 удаа урьдчилан сэргийлэх мэдээг олон нийтэд хүргэж байна. Радио: FM-107,5, 99,5 МҮОНР-12 удаа, сонин Өнөөдөр, Үндэсний шуудан, Өдрийн сонин, Зууны мэдээ-д 5 удаа, сэтгүүл: Үдшийн шивнээ, Цахим хуудас-www.sbd.ub.gov.mn www.sbemn.ubhealth.mn www. olloo.mn зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажилласан.</td></tr>
<tr><td rowspan="2">121</td><td>Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг сайжруулна.</td><td>НХХ</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="3">Дүүргийн төсвийн 120,0 сая төгрөгийн хөрөнгөөр 20 хорооны Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нэн шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, тавилга, хэрэгсэл нийлүүллээ.</td></tr>
<tr><td rowspan="2">122</td><td>Стандартын шаардлага хангахгүй өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай засвар хийнэ.</td><td>ЭМН</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="3">8,10,13 дугаар хорооны ӨЭМТ шинэ цогцолбор байранд үйл ажиллагаа явуулж байна. Стандартын шаардлага хангахгүй 2,6,9-р хорооны ӨЭМТ-ийн байрыг шинээр барих асуудлыг 2015 оны төсөвт саналаа хүргүүлсэн. Дүүргийн төсвөөс 38,5 сая төгрөг шийдвэрлэж, 1,3,18 дугаар хорооны ӨЭМТ-дийн дээврийн засварын ажлыг хийж гүйцэтгэлээ.</td></tr>
</table>

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Дүүргийн төсвийн 120,0 сая төгрөгийн хөрөнгөөр 1-20 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нэн шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, тавилга, хэрэгсэл нийлүүлсэн. | | |
| 123 | 4.2.9 Өндөр настнуудад зориулсан чөлөөт цагаа өнгөрүүлэх танхим, өдөр өнжүүлэх төвүүдийг байгуулна. | Ахмадуудад зориулсан төв байгуулна. | НХХ | 100% |
| | | Дүүргийн Засаг даргын Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хөгжил хариуцсан орлогч дарга Л.Нармандахын баталсан хуваарийн дагуу тус дүүргийн 17 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Хапитат” байрны спорт зааланд ахмадууд 7 хоног бүрийн Лхагва, Бямба гаригуудад өдөрлөг, уулзалт, спортын тэмцээн уралдаан тогтмол зохион байгуулж байна. | | |
| 124 | 4.2.10. Мал амьтны гоц халдварт болон халдварт өвчний тандалт хяналтыг тогтмолжуулна. | Мал амьтныг мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулан, үр дүнг тооцно. | МЭҮА | 90% |
| | | Төл малыг бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд хамруулах тухай нийслэлийн Засаг даргын 2014 оны А/688 дугаар захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор 488 тугалд штамм-19 вакцин, 68 хурга, 123 ишгэнд рев-1 вакцин хийж төлөвлөгөө 55 хувийн биелэлтэй. Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтыг 1426 өрхийн 1714 нохойд , туулгалтыг 1119 нохойд хийж төлөвлөгөө өссөн дүнгээр 48 хувиар хэрэгжиж байна. Малын хашаа хороо , саравчийн 2146 м2 талбай , 61,5 тн өтөг бууцанд ариутгал халдваргүйжүүлэлт хийж Hi –сор 20кг , хлорын шохой 100 кг зарцуулсан дүнтэй байна. | | |
| 125 | | Малын гаралтай хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлын үзлэг шинжилгээг хэрэгжүүлж, журам заарын дагуу баталгаажуулалт гаргана. | МЭҮА | 90% |
| | | Мал эмнэлэг ариун цэврийн үзлэг шинжилгээг мал амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүнээр худалдаа үйлчилгээ үзүүлдэг иргэд, аж ахуйн нэгж байгууллагын 75.0 тонн махны 129 дээжинд MNS 4373-96 ,MNS 1161-2002 стандарт аргаар , 2180 литр сүүний 48 дээжинд MNS 453-83, MNS 400:83 , MNS 3503-83 зэрэг стандарт аргуудаар, мөн лактоскан багажаар шинжилгээ хийж мал эмнэлэг, ар иун цэврийн баталгаажилт гарган Хүнс хөдөө аж ахуйн сайдын 2002 оны А/92, 2005 оны А/35 дугаар тушаалаар батлагдсан журмыг баримтлан гэрчилгээ олгов. | | |
| 126 | | Мал амьтныг урьдчилан сэргийлэх вакцинжуулалт болон мал амьтны гаралтай түүхий эдийн чанар байдалд хяналт тавина. | МХХ | 100% |
| | | МХЕГ-ын даргын 01 тоот “Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай”, НОК-ын даргын 01 тоот тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тандалт үзлэгт мал бүхий 219 өрхийн 3126 толгой малыг хамруулсан байдалыг шалгахад хамрагдвал зохих мал 100 хувь хамрагдсан. Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/145 тоот, дүүргийн Засаг даргын 2014 оны А/93 тоот “Мал амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажил зохион байгуулах тухай”, захирамжийн хэрэгжилтэнд хяналт шалгалтыг хийхэд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Жиню баолин амьд бодисын эмийн үйлдвэрт үйлдвэрлэсэн 100 граммаар савлагдсан 4235001 серийн дугаартай “О”, “А”, “АЗИ-1” хэвшлийн 3 цэгт идэвхгүйжүүлсэн 2,7 л вакцинаар мал бүхий 232 өрхийн 2953 малыг вакцинжуулалтанд 100 хувь хамруулсан байна. | | |
| ***4.3. Авто зам, тээврийн сүлжээг хөгжүүлэх чиглэлээр:*** | | | | |
| 127 | 4.3.1 Дүүргийн авто зам, гэр хорооллол орон сууцны дундах авто замын сүлжээг | Хороолол доторх авто замыг засах, шинээр барих ажлыг үргэлжлүүлнэ ДБ-13 | ДБТХ | 100% |
| | | Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2014 онд хийгдэх орон сууцны хороолол доторх авто зам.<br>1. 1-р хороо, 25-р байрны өмнөх авто зам 160у/м | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | сайжруулна. | 2. 7-р хороо, 1-р байрны баруун талын авто замын шинэчлэлт 130у/м<br>3. 4-р хороо, 22б-р байрны өмнөх авто замын шинэчлэлт 110у/м<br>6-р хороо, 25,26-р байрнуудын өмнөх авто замын шинэчлэлт 240у/м. Эдгээр 4 байршил дээр авто ажлыг 9 сард хийхээр төлөвлөөд байна. | | |
| 128 | | Орон сууцны хороолол дундах авто замын арчилгаа цэвэрлэгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ. | ДБТХ | 100% |
| | | Дүүргийн Засаг даргын 2014 оны 02 сарын 25-ны өдрийн А/70 тоот захирамжаар 03 сарын 01-ны өдрөөс орон сууц, гэр хороодын дундах авто зам, явган замын цэвэрлэгээ үйлчилгээний ажлыг Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ-ын тохижилт цэвэрлэгээний албанд хариуцуулав.<br>Хороолол доторх авто замын арчлалт хамгаалалтыг Улаанбаатар нэгтгэл төрийн өмчит компани хариуцаж ажиллаж байна. | | |
| 129 | 4.3.2. Замын байгууламж, нүхэн гарц, газар доорх болон олон давхар авто зогсоолуудыг төлөвлөн барьж байгуулна. | Газар дээр болон доор авто зогсоол хийх ажлыг иргэд байгууллагатай хамтран зохион байгуулна. | ДБТХ | 100 % |
| | | 1, 3, 4, 7, 8, 9 дүгээр хороонд тус бүр 1 байршилд нийслэл дүүргийн ОНХС-гийн хөрөнгөөр авто зогсоол барихаар зураг төслийг гаргуулж байна. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Гурван гал худалдааны төвийн урд талын нийтийн эзэмшлийн талбайг тохижуулан газар доор 2 давхар авто зогсоол барих, Гадаад хэргийн яамны баруун талд газар доор авто зогсоол барих, 7 дугаар хороо 2 дугаар сургуулийн ард байрлах 86 гараажийг буулгаж газар доорх авто зогсоол барих, 11 дүгээр хороо, Улсын бүртгэлийн Ерөнхий газрын орчимд газар доор авто зогсоол барих, 8 дугаар хороо Улсын их сургуулийн замын урд талд авто зогсоол барихаар нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 11 дүгээр сарын 28-ний өдрийн 13/54 дугаар тогтоолоор баталсан байна.<br>Сүхбаатар дүүргийн 2,6,8,14 хороонуудад 4 гүүрэн гарц болон зорчих хэсгийг тусгаарлах хашлага, явганы хайс зэргийг хийлгэхээр холбогдох албан тушаалтанд хүргүүлэн ажиллаж байна. | | |
| | | ***4.4. Гамшгаас хамгаалах чиглэлээр:*** | | |
| 130 | 4.4.1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн бэлэн байдлыг нэмэгдүүлж, иргэдийг байгалийн гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор гамшгийн үед байрлах, хорогдох цэгүүдийг тогтоож, онцгой байдлын алба саадгүй хүрч ажиллах орчинг бий болгоно. | Дүүргийн нутаг дэвсгэрт гамшгийн үед хоргодох цэгүүдийг тогтоох, ашиглах боломжийг бүрдүүлнэ | ОБХ | 100% |
| | | Дүүргийн хэмжээнд байршуулах 23, гамшгийн үед хорогдох байрны зориулалтаар ажиглаж болох 3, гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх 5 байршлыг сонгон тогтоогоод байна. | | |
| 131 | | Дүүргийн гамшгаас хамгаалах ерөнхий төлөвлөгөөнд тохиолдож болзошгүй гамшгийн төрлүүдээр салбар төлөвлөгөөг батлуулна. | ОБХ | 100% |
| | | Дүүргийн гамшгаас хамгаалах ерөнхий төлөвлөгөөний газар хөдлөлтийн болон үер уснаас сэргийлэх төлөвлөгөөнд тодотгол 2014 оны 06 дугаар сарын 20-ны өдөр хийсний дагуу мөрдөн ажиллаж байна. | | |
| 132 | 4.4.2 Төвөөс алслагдсан | Аврах гал унтраах ангийн газрын зөвшөөрөл, барилгын зураг төсвийг батлуулна. | ОБХ | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | бүсийн иргэдэд үйлчлэх Аврах, гал унтраах анги байгуулна | Шинээр баригдах Аврах, гал унтраах ангийн газрын зөвшөөрөл, барилгын зураг төсвийг батлуулсан. | | |
| 133 | 4.4.3 Үерийн ус зайлуулах далан сувгийг сайжруулж, нэмж байгуулна. | 13, 14, 17 дугаар хороодод үерийн ус зайлуулах далан сувгийн ус нэвтрүүлэх чадварыг сайжруулна. | ОБХ | 100% |
| | | Шар ус болон үерийн аюулаас урьдчилан сэргийлэх үүднээс дүүргийн нутаг дэвсгэрт байрлах гэр хорооллын гудамж дундуур ус урсах сэргээн засварлах, шаардлагатай далангийн судалгаар Дэд бүтэц, тохижилтийн хэлтэстэй хамтран гаргаж, 7287 у/м даланг сэргээн засварлах шаардлагатай байгаа саналыг хүргүүлэн ажиллаж байна. Мөн Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын Нийслэлийн гал түймрийн тоо давтамжийг бууруулах урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах тухай тушаалын хүрээнд Аврах, гал унтраах 34 дүгээр ангийн албан хаагчдын хамтаар шар усны үерийн аюулд өртөх магадлалтай айл өрхүүд буюу гуу жалганы мэдээ мэдээллийг гаргаж ажиллаж байна | | |
| 134 | | 13, 14 дүгээр хорооны үерийн хамгаалалтын барилга байгууламж, хөрсний усны түвшин доошлуулах шугамын ажлын бэлтгэлийг хангана. | ОБХ | 100 % |
| | | 13, 14 дүгээр хорооны үерийн хамгаалалтын барилга байгууламж, хөрсний усны түвшин доошлуулах шугамын ажлын зураг төслийг Монгол менежмент төв ХХК гаргаж дууслаа. 13 дугаар хорооны рашааны 4, Ногоон талбайн 2 гудамжны ус зайлуулах хоолойн зураг төслийг дөрвөн тэнхлэг компаниар хийлгэж байна | | |
| | | **ТАВ. АВЛИГАГҮЙ ДҮҮРЭГ** | | |
| 135 | 5.1 Дүүргийн удирдла-гаас гарч байгаа шийдвэрийг ил тод байлган, гүйцэтгэлд нь хяналт тавих эрхийг иргэдэд олгохын зэрэгцээ дүүрэгт тулгамдаж буй асуудлаар иргэдийн дунд олон нийтийн санал асуулга явуулж, тэдний саналд үндэслэн шийдвэр гаргадаг болно. | Үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил тод болгож, гарсан шийдвэрийг цахим хуудсаар байнга мэдээлнэ. | ЗХХ НХҮХ | 100% |
| | | Иргэд үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалт, төлбөр, хураамж, нэг цонхны үйлчилгээ, санхүү, төсвийн болон нийгмийн халамж, шагнал урамшуулал болон дүүргээс явуулж буй үйл ажиллагааны талаар олон нийтэд цаг алдалгүй шуурхай мэдээлж байна.<br>Дүүргийн удирдлагаас гарч байгаа шийдвэрийг ил тод байлгах үүднээс Ийгл, Тм Тв10, Нийслэл таймс, Ардчилал, Зууны мэдээ<br>Үндэсний шуудан, Ноён пикчерс ХХК, Ханлиг студитэй хамтран ажиллаж www.sbd.ub.gov.com болон /Нээлттэй Сүхбаатар/ фэйс хуудас, www.ulaanbaatar.mn, www.zasag.mn, www.dorgio.mn, www.ikon.mn, www.mnb.mn, www.assa.mn www.mass.mn www.time.mn www.eagle.mn www.mminfo.mn www.bolod.mn www.undesten.mn нийт 12 цахим хуудсуудад 933 үйл явдлын мэдээ мэдээллийг 1321 удаагийн давтамжтай нийтлүүлж дүүргийн удирдах ажилтнуудын 18 удаагийн шуурхай зөвлөгөөний мэдээ, үүрэг даалгаврын биелэлт, худалдан авах ажиллагааны тухай 55 удаагийн тендер шалгаруулалтын зарлалыг байршууллаа. Телевизүүдээр Мэдээллийн хөтөлбөрөөр мэдээ дамжуулахаас гадна тодорхой нэвтрүүлэгт дүүргийн удирдлагууд болон холбогдох албан тушаалтныг оролцууллаа. Өдөр тутмын сонинуудтай хамтарч ажиллан 261 удаа, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр 2686 удаа мэдээ мэдээллүүдийг олон нийтэд хүргэлээ. | | |
| 136 | | Дүүргийн хөгжилд тулгамдаж байгаа асуудлаар санал асуулга авч, гарах шийдвэрт тусгаж хэрэгжүүлнэ. | ЗХХ | 100% |
| | | Сүхбаатар дүүргийн иргэдээс 2013 оноос 2014 оны эхний хагас жилийн хугацаанд нийт 6 удаагийн сэтгэл ханамжийн судалгаа буюу хэрэглэгчийн үнэлгээг дүүргийн 20-н хороонд (Зөвхөн судалгаанд хамрагдсан хороод) зохион байгуулж 5250 иргэн хамрагдан үнэлгээ өгсөн байна. Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтаар хийгдсэн ажлын чанар, үр дүн | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | /зам,бичил цэцэрлэг, усан оргилуур, ногоон байгууламж г.м/ 69.5 хувь, Хотын өнгө үзэмжийг сайжруулах чиглэлээр хийсэн ажил, түүний үр дүн /замын орц, гарц хаасан хашаа, ТҮЦ, павильон, рекламын самбаруудыг буулгах г.м/ 70.3 хувь, иргэдийн бизнесийн үйл ажиллагаа явуулахад дүүргийн зүгээс дэмжлэг туслалцаа үзүүлдэг эсэх 49.0 хувь, Гэрэлтүүлгийн өнгө үзэмж, чанар, хүчин чадал нь шаардлага хангаж байгаа эсэх 72.8 хувь, Дүүрэг болон таны оршин суугаа хорооны гудамж талбайн хог хаягдлыг цэвэрлэх чиглэлээр зохион байгуулж буй ажлын явц, үр дүн 85.4 хувь, Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцааны талаар өгөх таны үнэлгээ 77.2 хувь, Дүүрэг хороодын төрийн албан хаагчдын цаг ашиглалтын байдалд өгөх таны үнэлгээ 81.0 хувь, Иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэдэг эсэх 74.6 хувь, Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх, иргэдийн аюулгүй амьдрах орчин нөхцлийг сайжруулах талаар зохиож буй ажлын чанар, үр дүнгийн талаар 72.3 хувьтай үнэлгээг тус тус өгч нийт санал асуулгын дүнд 77.2 хувийн дундаж үнэлгээ өгсөн байна. | | |
| 137 | 5.2. Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудаас иргэд, аж ахуйн нэгжүүдэд үзүүлдэг ажил, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, цахим засаглалыг хөгжүүлнэ. | Байгууллагын захирамжлалын цаасан суурьтай баримтыг цахимжуулна. | ЗХХ | 100% |
| | | Байгууллагын захирамжлалын баримт бичгийн цахим санд Засгийн газрын тогтоол 6, Засгийн газрын тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгавар 1, нийслэлийн ИТХ-ын тогтоол 1, Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын тушаал 1, нийслэлийн Засаг даргын захирамж 5, УБ хотын захирагчийн ажлын албаны даргын тушаал 1, нийслэлийн Онцгой комиссын даргын тушаал 1, нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын тушаал 1, нийслэлийн ӨХГ-ын даргын тушаал 4, ДИТХ-ын тогтоол 3, ДИТХТ-ийн тогтоол 2, дүүргийн Засаг даргын А захирамж 106, Б захирамж 3, Тамгын газрын даргын А тушаал 41, Б тушаал 69-ийг цахим файлаар оруулаа.<br>Бүртгэлийн хэлтэс Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын 33820 баримтыг цахимжуулж дуусан дахин нягтлан шалгах ажлыг хийж байна.<br>Дүүргийн Засаг даргын 2013 оны 527 захирамжаас 301 захирамжийг, 2014 оны захирамжийн нууцад хамаарахаас бусад захирамжийг сайтад байршуулав.<br>Хөдөлмөрийн хэлтсийн олон нийтийн цахим хуудас /www.facebook.com Сүхбаатар дүүргийн Хөдөлмөрийн хэлтэс/ болон хэлтсийн www.sbd.hudulmur.gov.mn хуудсанд төсөл, хөтөлбөрийн мэдээлэл, дэмжигдсэн, зохион байгуулсан, зохион байгуулах үйл ажиллагааны зар мэдээллийг тогтмол оруулж иргэдэд нээлттэй хүргэж байна. Хэлтсээс хийж байгаа ажил, зар, мэдээллийг Хороодын ажлын албанд сар бүр бичгээр хүргүүлж байна. | | |
| 138 | | Мэдээллийн аюулгүй байдал, програм хангамжийн найдвартай байдлыг хангаж ажиллана. | ЗХХ | 100% |
| | | Өмч, газрын харилцааны албанаас өмчлөлийн програм LPIS, бүртгэлийн програм UBGIS, газрын эрхийн бүртгэлийн LandUK, ажлын зургийн AutoCad зэрэг програмын хэвийн ажиллагааг хангаж баяжилт хийн ажиллаж байна.<br>ЗДТГ-аас мэдээллийн аюулгүй байдал, програм хангамжийн өдөр тутмын найдвартай байдлыг хангаж ажиллаж байна | | |
| 139 | | Бүх төрлийн төсөл хөтөлбөр, ЖДҮ эрхлэгчдийн зээлийн мэдээллийг ил тод нээлттэй болгоно. | ХХ | 100% |
| | | Хэлтсийн facebook page болон sbd.hudulmur.gov.mn хаяганд шинэчлэл оруулан төсөл, хөтөлбөр, хөнгөлөлттэй зээлийн зарыг тухай бүр оруулан, дэмжигдсэн төслүүдийн мэдээллийг тухай бүр оруулж байна. /Мэдээллийг дээрх хуудаснуудаас авч болно/ Хөдөлмөрийн яамнаас вэб хуудсыг шинэчлэх талаар чиглэл өгсний дагуу вэб хуудсанд засвар оруулж байна. | | |
| 140 | 5.3. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэн өргөтгөж, төрийн | Төр, хувийн хэвшлийн түншлэлээр төрийн зарим ажил, үйлчилгээг хэрэгжүүлнэ. | НХХ | 100% |
| | | -Дүүргийн Засаг дарга, Эрүүл мэндийн нэгдлийн дарга, Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нартай хамтран ажиллах 3 талт гэрээ байгуулан, хяналт тавьж, хамтран ажиллаж байна. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ. | -Дүүргийн Ахмадын холбоотой хамтран Сар шинийн баяраар өдөрлөг зохион байгуулж, 20 хорооны 12051 ахмадыг хүлээн авч, урлагийн тоглолт үзүүлж, гарын бэлэг гардуулсан.<br>-Дүүргийн ЗДТГ, дүүргийн Ажил олгогч эздийн холбооны салбар холбоо, дүүргийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо хамтран ажиллах ажлын хүрээнд “Нийгмийн түншлэл, баялаг бүтээгчдийн анхдугаар чуулган” зохион байгуулахаар бэлтгэл ажлаа хангалаа.<br>-Японы засгийн газрын “Өвсний үндэс” төслөөс санхүүжүүлсэн Харааны бэрхшээлтэй хүүхдийн 116-р сургуулийн 1 давхрын бие засах өрөөний таславч хана, складны өрөө, чийрэгжүүлэлтийн өрөөний нийт 28,9 сая төгрөгний засварын ажлыг “Од-Орд” ХХК, 29-р сургуулийн засварын ажлыг “Гантранс-ХХК гүйцэтгэлээ<br>Мөн уг төслийн 170,0 сая төгрөгийн санхүүжилтаар ЭМН-ийн Гэр бүлийн хүчирхийллийн нэг цэгийн үйлчилгээний төвийн байрны засвар хийгдсэн. | | |
| 141 | | Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран ажиллах 3 талт гэрээ байгуулан, үр дүнг тооцож ажиллана. | НХХ | 100% |
| | | Дүүргийн Засаг даргын 2014 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/220 дугаар захирамжаар Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулсан гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг дүгнэх Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулав. Нийслэлийн Засаг даргын 2014 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/274 дүгээр захирамжаар батлагдсан “Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээ, дүгнэх журам, шалгуур үзүүлэлт”-ийн дагуу гэрээний биелэлтийг жилд 2 удаа дүгнэж байна. Гэрээний 2014 оны эхний хагас жилийн биелэлтээр 11-р хорооны Дотны туслагч ӨЭМТ 91.7 оноо, 9-р хорооны Энхийн санаа ӨЭМТ 90.0 оноо, 8-р хорооны Манай эмч ӨЭМТ 88.5 оноо, 4-р хорооны Өөдрөг энх ӨЭМТ 88.4 оноо, 2-р хорооны Ачит гар ӨЭМТ 87.7 оноо, 5-р хорооны Түвшин хүч ӨЭМТ 87.5 оноотой дүгнэгдэж, эхний 5 байр эзэлсэн байна.<br>Нийслэлийн Засаг даргын 2014 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн “Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээ, дүгнэх журам, шалгуур үзүүлэлт”-ийг батлах тухай” А/274 дүгээр захирамжийн дагуу Дүүргийн засаг дарга, ЭМТ, ӨЭМТ-үүдийн 3 талт гэрээг 5 сарын 15 өдөр байгуулсан. ЭМСайдын 2014 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 363 тоот тушаалыг ДЗДТГ, ӨЭМТ-ийн дарга нарт танилцуулж, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах талаар хэлэлцэж, 2015 онд тусгахаар шийдвэрлэсэн.<br>2014 оны эхний хагас жилийн гэрээ дүгнэлт: 11-р хорооны Дотны туслагч ӨЭМТ 91.7 оноо, 9-р хорооны Энхийн санаа ӨЭМТ 90.0 оноо, 8-р хорооны Манай эмч ӨЭМТ 88.5 оноо, 4-р хорооны Өөдрөг энх ӨЭМТ 88.4 оноо, 2-р хорооны Ачит гар ӨЭМТ 87.7 оноо, 5-р хорооны Түвшин хүч ӨЭМТ 87.5 оноотой дүгнэгдэж эхний 5 байр эзэлсэн ба 17-р хорооны ӨЭМТ, хангалтгүй , ажил сайжруулах үнэлгээтэй дүгнэгдсэн. Жилийн эцсийн 3 талт гэрээг 12 дугаар сарын 25-ны дотор дүгнэж, ДЗДТГ-т хэлэцүүлнэ. | | |
| 142 | | Хүн ам гэр бүлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд, ОУБ, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулж Хүн ам гэр бүлийн чиглэлээр хамтран 2 төсөл хэрэгжүүлнэ | НХҮХ | 100% |
| | | Хамтран ажилладаг иргэн, ТББ-уудын судалгаа хийж, мэдээллийн сан бүрдүүлсэн. Уг мэдээллийн санд ТББ-н хаяг байршил танилцуулга үйл ажиллагааны чиглэл ажлын туршлага зэргийг дэлгэрэнгүйгээр бүртгэн гаргаж мэдээллийг өөрийн байгууллагын сайтанд байрлуулсан. 2014 оны жилийн эцсийн байдлаар хамтран ажиллахаар гэрээ хийсэн 25 төрийн бус байгууллага болон аж ахуйн нэгж байна. Үүнээс 2014 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн аж ахуйн нэгжийн болон төрийн бус 10 байгууллага Сүхбаатар дүүргийн нийгмийн халамжийн зорилтод бүлгийн гишүүдэд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлж байна. Байгууллагуудын талаарх мэдээллийг ХҮМ | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | програмд оруулж, үйлчилгээнд хамрагдсан иргэдийг мэдээллийн санд тогтмол оруулан ажиллаж байна.<br>Кейс менежерийн болон Сайн дурын нийгмийн үйлчилгээг зохион байгуулахад хамтран оролцсон нийт 42 төрийн болон төрийн бус байгууллагыг үйл ажиллагааны чиглэлээр нь мэдээллийн санд оруулсан. Хийсэн ажил үйлчилгээгээ дүгнэж 21 Төрийн бус байгууллагад өргөмжлөл гардуулсан<br>**Үр дүн:** Бүртгэл мэдээллийн сан байнга баяжуулан ажиллаж 2014 онд нийт 67 ТББ болон иргэнтэй хамтран ажилласан.<br>Төрийн бус байгууллага, Олон улсын байгууллагуудтай хамтран Хүн ам, гэр бүлийн хөгжлийн чиглэлээр “Итгэл сэтгэл” төслийг хэрэгжүүлсэн. Уг төсөлд хийж бүтээх, хөдөлмөрлөх хүсэлтэй, амьдралын төлөө тэмцэлтэй иргэдийг сонгож оролцуулсан. Төсөлд хамрагдаж байгаа зарим иргэдэд зориулсан үзэсгэлэн худалдааг 2014 оны 01 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд “Моннис цамхаг” болон “Моннис бьюлдинг” оффест зохион байгуулсан.<br>Дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран хэрэгжүүлж буй “Итгэл сэтгэл” төслийн хүрээнд Жи Эл Эф ХХК –тай хамтран нэн ядуу орон гэргүй долоон өрхийн иргэдэд санхүүгийн тусламж олгов. Энэ тусламжийг цаашид сар бүр тогтмол олгохоор болсон юм. Амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой хагас болон бүтэн өнчин хүүхэдтэй 20 өрхөд MJT-ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА тай хамтран насны онцлогт тохирсон эрүүл хоол хүнсээр хөнгөлөлттэй үнээр хангах зорилгоор 2014 оны 04 сарын 01- нээс эхлэн сар бүр 50000 төгрөгийн тусламжийг олгож байна. .<br>Тус дүүргийн 16 хороонд байрладаг “ТЕРЕЗА ЭХ” буяны байгууллагатай хамтран амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой бага насны олон хүүхэдтэй өрхүүдэд нөхцөл байдлын үнэлгээ хийн сонгож 30 өрхөд сар бүр шаардлагатай хүнсний бүтээгдэхүүн болох ургамлын тос, гурил будаа, сахар, давс зэрэг бүтээгдэхүүнүүдийг 2014 оны 10 дугаар сарын 01 –нээс 2015 оны 05 сар хүртэл олгож эхэлсэн<br>**Үр дүн:** Дүүргийн амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой бага насны олон хүүхэдтэй 57 өрх хүүхдүүдийнхээ насны онцлогт тохирсон эрүүл хоол хүнсээр хангагдаад байна. | | |
| 143 | 5.4. Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг жил бүрийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, олон нийтэд ил тод мэдээлэн, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлдэг болно. | 2015 онд төсвийн хөрөнгөөр хийх бүтээн байгуулалтын ажилд иргэд оршин суугчдаас санал авч хэлэлцүүлнэ. | ЗХХ | 100% |
| | | Дүүргийн Засаг даргын 2014 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын талаар нээлттэй санал асуулга зохион байгуулах тухай” А/114 дүгээр захирамжийн дагуу ОНХС-ийн хөрөнгөөр 2015 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөх зорилгоор иргэдээс нээлттэй санал асуулга авах ажлыг 2014 оны 03 дугаар сарын 29-ний өдрөөс 04 дүгээр сарын 15-ны өдрүүдэд зохион байгуулж , нийт 30000ш саналын хуудсыг хороодын өрх хүн амын тоонд харьцуулан хуваарилж өрхүүдэд хүргүүлэх чиглэл өгч ажиллан нийт саналын хуудаснаас 25910 буюу 83.3%-ийг өрхүүдэд хүргүүлснээс 20538 буюу 79,2% саналаа ирүүлсэн бөгөөд гарсан саналыг иргэдээр эрэмбэлүүлэх хэлэлцүүлгийг Дүүргийн Засаг даргын 2014 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/288 дугаар захирамжийн дагуу 06 дугаар сарын 26-аас 29-ны өдрүүдэд зохион байгуулан хороодоос ирүүлсэн ИНХ-ын тогтоол, хэлэлцүүлгийн тэмдэглэлийг нэгтгэн холбогдох хэлтэст хүргүүлэв. Засаг даргын А/500 дугаартай захирамж, ЗДТГ-ын даргын А/202 дугаартай тушаалын дагуу “Санал, асуулт зохион байгуулах тухай” ажлыг 2014 оны 11 дүгээр сарын 21,22-ны өдрүүдэд зохион байгуулж Дүүргийн 2015 оны хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээнд тусгах, “Иргэн таны санал” санал, асуултыг нийт 23851 өрхөөс авч нийт иргэдийн 88% нь хамрагдсан байна. | | |
| 144 | 5.5 Тендерийн будлиан, авилга, хээл хахуулийг | Батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан сонгон шалгаруулалтыг | ХААА | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | халах зорилгоор төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг онлайн хэлбэрт шилжүүлж, иргэд, олон нийтийн хяналт дор ил тод явуулна | зохион байгуулан ажиллана. | | |
| | | Тус алба нь 2014 онд 22,4 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 285 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаар зохион байгуулах төлөвөлгөөтэй ажилласан бөгөөд төсвийн жилийн явцад хөрөнгө оруулалтын төлөвлөлтөнд тодорхой хэмжээний өөрчлөлт орж, захиалагчийн шийдвэрээр зарим төсөл арга хэмжээ хэрэгжих боломжгүй болж зогсоогдсон бөгөөд нийт 20,6 тэрбум төгрөгийн 259 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаар бүрэн зохион байгуулж хэрэгжүүлбэл зохих худалдан авах ажиллагаар бүрэн зохион байгууллаа.<br>Дүүргийн Засаг даргын захирамжаар 85 үнэлгээний хороо байгуулагдан, худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг хуулийн хүрээнд зохион байгуулснаар 506,7 сая төгрөгийн төсвийн хэмнэлт үүсгэсэн байна.<br>Ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон тендер шалгаруулалтын урилга, холбогдох мэдээллийг Сангийн яамны худалдан авах ажиллагааны газрын болон дүүргийн вэб хуудас, өдөр тутмын Өдрийн сонин, Нийслэл таймс сонингуудад байршуулан ажиллахын зэрэгцээ дүүргийн ЗДТГ-ын мэдээллийн самбарт шинэ мэдээллийг тухай бүр байршуулж ажиллалаа.<br>2014 оны 06 дугаар сарын 06-ны өдөр болон 2014 оны 09 дүгээр сарын 06-ны өдрүүдэд нээлттэй хаалганы өдөрлөгийг Чингисийн талбайд зохион байгуулж, дүүргийн хэмжээнд 2013 онд төсвийн хөрөнгөөр зохион байгуулсан хөрөнгө оруулалтын ажлын худалдан авах ажиллагаа, түүний үр дүн, 2014 оны худалдан авах ажиллагааны явцын талаар танилцуулж, худалдан авах ажиллагаанд төрөөс хэрэгжүүлж буй бодлого болон албаны үйл ажиллагааг иргэд, олон нийтэд танилцуулж, гарын авлага, зөвлөмжийг тарааж үйл ажиллагаагаа сурталчлан ажиллав. | | |
| 145 | | Худалдан авах ажиллагааны хүний нөөцийг 2013-2016 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд худалдан авах ажиллагаг зохион байгуулахад оролцож буй мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтанд үе шаттай хамруулна. | ХААА | 100% |
| | | Тус алба нь “Худалдан авах ажиллагааны хүний нөөцийг 2013-2016 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд 2014 онд хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөөг батлуулан мөрдөн ажиллаж байна.<br>Төлөвлөгөөний дагуу төсөвчний анхан шатны мэдлэг олгох 14 хоногийн хугацааны сургалтанд 1 мэргэжилтнийг хамрууллаа. Мөн нийслэлийн ХААГ-аас зохион байгуулагдаж буй богино хугацааны сургалтанд албаны мэргэжилтнүүд тогтмол хамрагдаж, мэргэжлийн мэдлэгээ дээшлүүлэн ажиллалаа. | | |
| 146 | | Төлөвлөгдсөн худалдан авах ажиллагааны 20-иос доошгүй хувийг цахим тендерийн хэлбэрээр зохион байгуулна. | ХААА | 70% |
| | | Төлөвлөгдсөн худалдан авах ажиллагааны 20-иос доошгүй хувийг цахим тендерийн хэлбэрээр зохион байгуулах зорилтын хүрээнд 2013 оны эцэст цахим тендер зарласан нь дүүргүүдээс анхны Цахим тендер шалгаруулалт зохион байгуулсан дүүрэг болсон болно. Энэхүү амжилтыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж 2014 онд 253,9 сая төгрөгийг өртөг бүхий 2 төсөл арга хэмжээг цахим тендер шалгаруулалтын хүрээнд зохион байгуулав. | | |
| 147 | | Тендерт оролцогч байгууллагуудын мэдээллийн санг бүрдүүлж, тендертэй холбоотой мэдээллийг олон нийтэд мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ. | ХААА | 100% |
| | | Эрх бүхий аж ахуйн нэгж байгууллагуудыг дүүргийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын сонгон шалгаруулах ажиллагаанд өргөнөөр оролцуулах зорилгоор өдөр тутмын сонингуудад хамтран ажиллах саналын урилгыг удаа дараа байршуулан ажиллалаа. Үүний үр дүнд дүүргийн ЗДТГ, ХААА-тай хамтран ажиллах санал, хүсэлт, компанийн дэлгэрэнгүй танилцуулга, мэдүүлгийг 555 аж ахуйн нэгж байгууллагаас хүлээн авч нэгтгэн, мэдээллийн сан | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | бүрдүүлж, худалдан авах ажиллагааны зохион байгуулалтанд ашиглалаа.<br>Албаны худалдан авах ажиллагааны зохион байгуулалтын талаарх гүйцэтгэлийн мэдээллийг журам зааврын дагуу боловсруулж, мэдээ мэдээллийн үнэн зөв, ил тод байдлыг хангаж ажиллаж Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендер шалгаруулалтын урилга, холбогдох мэдээллийг Сангийн яамны худалдан авах ажиллагааны газрын e-procurement.mn, нийслэл дүүргийн цахим хуудаст байршуулан мэдээлэн ажиллаж байна. | | |
| 148 | 5.6 Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудад хууль дээдлэх ёсыг бодитой хэрэгжүүлж, төрийн албан хаагчдыг сонирхлын зөрчил, авилгад өртөхгүй байх, урьдчилан сэргийлэх эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | Иргэдэд хууль эрх зүйн сургалт сурталчилгааг тогтмол хийж, эрхзүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлнэ | ЗХХ | 100% |
| | | Цагдаагийн 1 дүгээр хэлтсээс 4 удаагийн “Хууль сурталчлах өдөр”-өөр 95 иргэнд хуулийн зөвлөгөө өгч, хорихоос өөр төрлийн ялтай 75 иргэнтэй уулзалт зохион байгуулж хуулийн зөвлөгөө өглөө.<br>4 дүгээр хорооны Иргэдэд үйлчлэх төвөөр цагдаагийн дэд хурандаа Даваажамц өдрийн 8 цагаар иргэдэд хууль эрх зүйн мэдээлэл зөвлөгөөг өгч байна.<br>Өмч, газрын харилцааны албанаас 16 дугаар хорооны НЦҮ-ний төвд 2 удаа ажиллаж, иргэдэд газар өмчлөлийн талаар эрх зүйн зөвлөгөө өгөв.<br>ЗДТГ-аас Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийг тохиолдуулан 6, 7, 8, 9, 10 дугаар хороодын нийгмийн ажилтнууд, 40 гаруй иргэдэд Үндсэн хуулийн үүсэл хөгжил, хүний эрх, эрх чөлөө сэдвээр мэдээлэл хийж, “Согтууруулах ундааны хяналтын тухай” хуулийн хэлэлцүүлгийг иргэд, төрийн албан хаагч, аж ахуйн нэгж байгууллагын дунд зохион байгууллаа.<br>Төлбөрийн чадваргүй яллагдагчдад хууль зүйн туслалцаа үзүүлэх хууль 1 сарын 1-нээс эхлэн хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Эрх зүйн туслалцааны төвийн үйлчилгээний хүрээг өөрчлөн 2 сарын 1-нээс эхлэн иргэний болон захиргааны эрх зүйн хэрэгт хамааралгүй болж, зөвхөн гэмт хэрэгт буруутгагдан шалгагдаж байгаа этгээдэд үйлчилж эхэллээ. Эрх зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч 22 сэжигтэн, яллагдагчийг шүүхийн шатанд өмгөөллөө. | | |
| 149 | | Төрийн албан хаагчдад хэрэгцээ шаардлагатай хууль журам зааврыг тогтмол сурталчилж, гарын авлагаар хангана. | ЗХХ | 100% |
| | | 20 хороодод Төрийн мэдээлэл сэтгүүлийг захиалан, ашиглуулж байна.<br>ЗДТГ болон бүх хэлтсүүд төрийн албан хаагчдад авлигаас ангид хувийн болон сонирхлыг зөрчилгүй ажиллах талаар Авлигатай тэмцэх газар болон ТББ-ын сургагч нараар, архив албан хэрэг хөтлөлтийн талаар хичээл сургалт явууллаа.<br>Бүртгэлийн хэлтсийн 2014 оны сургалтын төлөвлөгөөний дагуу хороодын улсын бүртгэгч нарт “Иргэний улсын бүртгэл хөтлөлт” иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 25 албан хаагчид, Албан хэрэг хөтлөлтийн стандартаар 23 албан хаагчдад сургалт хийв. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 34, 35 дугаар тушаалыг хэрэгжүүлж цагдаагийн алба хаагчдад 3 сэдвээр сургалт зохион байгууллаа. | | |
| 150 | | Батлан хамгаалах хууль тогтоомж, бодлого үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан Цэргийн штабын нээлттэй байдлыг хангаж ажиллана. | ЦШ | 100% |
| | | Нийслэлийн Засаг даргын захирамжийг үндэслэн 2014 оны бэлтгэл офицер, цэргийн үүрэгтний бүртгэлийг шинэчлэн статистик мэдээгээр тоо бүртгэлд хамрагдвал зохих 35195 эрэгтэй иргэдээс 34043 нь бүртгэгдэж хамрагдвал зохих бүрэлдэхүүний 96,7 % нь цэргийн тоо бүртгэлд хамрагдлаа.<br>Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу Шилжүүлэх байрын сургалтыг бэлтгэл, онол ба дадлагын хэлбэрээр 2 үе шаттай явууллаа. Дүүргийн дайчилгааг удирдах бүлгийн гишүүдийг томилгоожуулж 4 гишүүнийг дүрэмт хувцсаар хангаж, дайчилгаа удирдах бүлэг, хороодын | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалтыг 2014 оны 3 дугаар сарын 20, 21-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний 011 дүгээр ангид зохион байгуулж, нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний дайчилгааны бэлтгэл нөөцийн сургалтын бэлтгэл ажлын биелэлт 91,2% байна.<br>2014 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Чингисийн талбайд “Энхийг сахиулагчдын өдөр” 2013 оны нэгдүгээр ээлжээр хугацаат цэргийн албанд татагдаж хугацаа дуусган халагдаж ирсэн дайчдыг хүлээн авах үйл ажиллагааг дүүргийн Хөдөлмөрийн хэлтэстэй хамтран зохион байгуулж ажлын байр мэргэжлийн сургалт дамжаанд зуучлан ажилласан.<br>2014 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагын ажлыг 2014 оны 05 дугаар сарын 9-11 өдрүүдэд амжилттай зохион байгуулан явуулж дээд байгууллагаас өгөгдсөн хяналтын тоон даалгаварыг 100 хувь биелүүлсэн.<br>Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар явагдсан “Оюутан цэрэг” хөтөлбөрийг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн их дээд сургууль, коллежуудад суралцдаг 18-25 насны 100 оюутнуудыг хамрагдуулсан.<br>Монгол Улсын Засгийн газрын 2013 оны мн/150 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2013 оны мн/10 дугаар тушаалын дагуу дайчилгаатай тусгай тактикийн хээрийн сургуулийг зохион байгуулж явуулсан. | | |
| 151 | | Төрийн албан хаагчдыг ёс зүй болон хувийн ашиг сонирхлын зөрчилд автахаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна. | ЗХХ | 100% |
| | | Цагдаагийн 1 дүгээр хэлтсээс алба хаагчдын дунд Авлигын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар сургалт зохион байгуулж, хэлтсийн алба хаагчдын ажлын чиг үүрэг, овог нэр, өрөө утасны дугаар бүхий самбарыг иргэдийг хүлээн авах байранд байрлуулав.<br>Замын цагдаагийн тасаг Пүрэв гараг бүрт тасгийн хурал, улиралд 1 удаа сахилгын зөвлөгөөний хурлыг хийж хэвшүүллээ.<br>ӨГХА-наас албан хаагчдад Авлигын эсрэг хуулийг сурталчилж, “Шударга залуу хүний 7 дадал” сэдвээр соён гэгээрүүлэх илтгэлийн уралдаан зарлаж дүгнэв.<br>НХҮХ Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ХАСХОМын мэдээг хуулийн хугацаанд тайлагнан шинээр ажилд томилогдохоор нэр дэвшигчийг АТГ-тай хамтран томилон ёс зүйтэй холбоотой мэдээлэл авах 350575 дугаарын утсыг ажиллуулж байна.<br>ЗДТГ-ын Ёс зүйн хороо эхний хагас жилд 2 удаа хуралдаж, 12 албан хаагчийн ёс зүйн зөрчлийг хэлэлцэж гаргасан дүгнэлтийг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлснээс 7 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулан 1 сарын хугацаатай Ёс зүйн хорооны мэдээллийн самбарт байршуулав. Үнэлгээний хуудсаар төрийн албан хаагчдыг үнэлэх санал авч байна. | | |
| 152 | | Татварын хэлтсийн үйл ажиллагааг бэхжүүлж, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, татвар төлөгчдөд ил тод нээлттэй, авилгагүй, шударга, шуурхай үйлчилгээг нэвтрүүлнэ. | ТХ | 100% |
| | | Хэлтсийн хэмжээнд авлига, хээл хахуультай тэмцэх хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хэлтсийн дотоод хяналт, ажлын зохион байгуулалтыг сайжруулж, сахилга, дэг журмыг чанд сахиж, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажиллаж байна. Татвар төлөгчидтэй зөв боловсон хүндэтгэлтэй харилцаж, аливаа асуудалд ил тод түргэн шуурхай байдлыг хангаж ажилласнаар тодорхойгүй, хүндрэлтэй асуудал үүсгэхгүйгээр ажиллаж байгаа нь авлига, сонирхолын зөрчил үүсэхгүй байх нөхцөлүүдийг бүрдүүлж байна. Тайлангийн хугацаанд хөтөлбөрийн хүрээнд доорх ажлуудыг хийж гүйцэтгээд байна. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 1. Хувийн ашиг сонирхолын болон хєрєнгє орлогын мэдүүлгийг хэрхэн бєглєх, ямар хариуцлага хїлээлгэх талаар тасаг тасгаар нь болон ганцаарчилсан зєвлєгєєг давхардсан тоогоор 62 тєрийн албан хаагчидад єгсєн. 2014 он гарсаар их хэмжээний єєрчлєлтєє 11 албан хаагч, албан тушаал єєрчлєгдсєн томилогдсон 12 албан хаагч шинээр мэдїїлснийг ХАСХОМ-ын програмд шивж мэдээг хугацаанд нь хїргїїлсэн. ХАСХОМ-той холбоотой 4 тайланг 2014 оны 1 сарын 25-ны дотор мэдээлж хїргїїлсэн.<br>2. Татварын ерєнхий газрын даргын 2014 оны 05 сарын тоот тушаалаар батлагдсан Татварын албаны їйлчилгээний стандарт, татварын албаны "Дотоод журам" зэргийг бїх тасгуудад хувилж єгсєнєєс гадна бїх албан хаагчдад танилцуулж гарын їсэг зуруулсан байна. Дээрх стандарт, журмуудыг хэлтсийн шаре болон е-оффист байршуулсан. үйлчилгээний стандарт, татварын албаны дотоод журмын хїрээнд сургалт зохион байгуулахад 665 албан хаагч оролцсон.<br>3. Хэлтэст авлигын эсрэг хууль бусад хууль тотоомж, журмуудыг сурталчлах зорилгоор шинээр Мэдээллийн самбар хийж байршуулсан. Энэ самбарт авлига, ашиг сонирхлын зєрчилийн талаар 3 удаа мэдээлэл тавьсан байна.<br>4. Хэлтсийн їйл ажиллагааг бэхжїїлж, сахилга, хариуцлагыг дээшлїїлэх, татвар тєлєгчдєд ил тод, нээлттэй, авлиггїй, шударга шуурхай їйлчилгээг нэвтрїїлэхэд чиглэгдсэн бодлого, тєлєвлєгєєг боловсруулан хэрэгжїїлж ирсэн. Хэлтсийн даргын нийт 90 тушаалын хуулийн їндэслэлийг хянаж, хуульд нийцүүлж аливаа зєрчлєєс сэргийлж ажилласан.<br>5. Авлига, ашиг сонирхлын зєрчил гаргахгїй байх талаар хэлтэст ажиллаж байгаа ОТББайцаагч нарт мэдээлэл хийж 2013-2014 онуудын їнэт цаасны тайланг дахин хянан шалгаж баримт боловсруулахтай холбогдуулан зєрчил гаргахгїй ажиллахыг зєвлєсєн.<br>6. 2014 онд хэлтсийн нийт албан хаагчдын 40 хувийг сэлгэж ажилласан. Энэ нь нэг ажил дээр удаан ажилласан болон ажлын їр дїн гарахгїй байгаа байцаагчид хамрагдаж байгаагаас гадна 62 татварын улсын байцаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчилж ажлын хуваарилалтыг єєрчилсєнєєр ажлын їр дїн сайжирсан байна. Хяналт шалгалтын їйл ажиллагаанд програм нэвтэрч байцаагч нарын шалгалтын хуваарь, томилгоог санамсаргїйгээр хийж хяналт шалгалтын їйл ажиллагааны їе шат бїрийг програмчилсан нь шинэ дэвшил болсон байна.<br>7.Хэлтсийн нэг цэгийн їйлчилгээний танхимд санал хїсэлтийн хайрцаг ажиллуулж ирсэн ба Засгийн газрын 1111, нийслэлийн санал авах утсанд 9 татварын улсын байцаагчтай холбоотой ирсэн єргєдєл, гомдлуудыг ахлах ажилтнуудыг нь байлцуулан хэлэлцэж зєрчил гаргасан ажилтнаар тайлбар гаргуулан гарсан гомдлыг бїрэн барагдуулж татвар тєлєгч нарт эргэн бичгээр болон утсаар мэдэгдэж тайланг НТГазарт єгч ажиллаж байна.<br>8. Дүүргийн ЗДТГазраас жил бїр уламжлал болгон Авлигагүй дүүрэг Уриан дор зохион байгуулагдаж ирсэн Илтгэл, эссэ бичлэгийн уралдаанд хураагч Ч.Халиун, Б.Даваасүрэн нар оролцож 2 дугаар шатанд шалгаран амжилттай оролосон байна.<br>9. ТЕГазраас зохион байгуулсан Авлигын тухай хуулийг сурталчлах АХА тэмцээнд тус хэлтсийн ТХШТасгийн 20 байцаагч амжилттай оролцож 5 байцаагч шалгаран дараагийн шатны тэмцээнд оролцсон байна. . | | |
| 153 | 5.7 Улаанбаатар хотын | Хотын дүрэм боловсруулах ажилд иргэдийг татан оролцуулна. | ЗХХ | 10% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | дүрэмд дүүргийн онцлог асуудлуудыг иргэдийн оролцоотой боловсруулж, оруулна. | Улаанбаатар хотын багц дүрэм нь 58 дүрэм журмаас бүрдэх бөгөөд агентлагууд болон нутгийн захиргааны байгууллагуудаар дамжуулан иргэдээс санал авч нийслэлийн Засаг даргын тамгын газар нэгтгэгдэж байгаа одоогоор 18 төслийг Нийслэлийн ИТХ-д батлуулахаар өргөн барихад бэлэн болоод байгаа юм. Тус дүүргээс Улаанбаатар хотын багц дүрэмд өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан тухай бүр санал өгч ажиллаж байна. | | |
| 154 | 5.8 Дүүргээс олгодог тусгай эрх, зөвшөөрөл авахад тавигдах шаардлага шалгуурыг хялбаршуулна. | Тусгай зөвшөөрлөөр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын мэдээллийг дүүргийн цахим хуудсаар байнга мэдээлнэ. | ХҮХ<br>ЗХХ | 100% |
| | | Тамхины хяналтын хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг үндэслэн дүүргийн Засаг даргын А/36, А/180, А/318, А/343, А/374, А/444 тоот нийт 6 удаагийн захирамжуудаар Худалдааны газар, түүний үйлчилгээ MNS 5021-2007 стандартын шаардлага хангасан 9 газрын тусгай зөвшөөрлийг сунгаж, 11 газарт шинээр тусгай зөвшөөрөл олгож, худалдаа үйлчилгээний салбарт тавигдах үндсэн шаардлага, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар мэргэжлийн заавар зөвлөгөө өгч ажилласан. Дүүргийн хэмжээнд 2014 оны жилийн эцсийн байдлаар 121 хүнсний дэлгүүр тамхи худалдаалах тусгай зөвшөөрөлтэй байна.<br>Мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хуулийн дагуу иргэд, аж ахуйн нэгжүүдэд тусгай зөвшөөрөлтэй холбоотой гаргаж байгаа дүүргийн Засаг даргын шийдвэрийг түргэн шуурхай хүргэх, иргэдэд мэдээллийг нээлттэй байлгах зорилгоор Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн тушаалаар согтууруулах ундаа худалдаалах тусгай зөвшөөрөл олгосон газруудын судалгаа, дүүргийн Засаг даргын захирамжаар тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгосон захирамж, тамхи худалдаалах тусгай зөвшөөрөлтэй худалдааны газруудын судалгааг дүүргийн цахим хуудаст нийт 14 удаа байрлуулсан. | | |
| 155 | 5.9 Төр захиргааны байгууллагуудын үйлчилгээг төвлөрүүлж иргэд, аж ахуйн нэгжид үйлчилгээг чирэгдэлгүй болгоно. | Нэгдсэн удирдлагын цахим програм хангамжийг шинээр бий болгоно. | ЗХХ | 100% |
| | | Дүүргийн нэгдсэн удирдлагын програм хангамжийн техникийн нөхцөл, бэлтгэл ажлыг хангаж, удирдлагад танилцуулан хянуулж байна. | | |
| 156 | | НЦҮ-ний нэр төрөл хүрээг өргөтгөж, чанарын өндөр түвшинд хүргэнэ. | ЗХХ | 100% |
| | | “Нэг цонхны үйлчилгээ”-ний төвийн ажиллагсад болон үйлчлүүлэгчдэд тав тухтай, бүх үйлчилгээ тодорхой байх орчныг бүрдүүлэх, таатай уур амьсгал бий болгох, харилцааны соёл, харилцагчаа дээдэлсэн үйлчилгээг хэвшүүлэх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай, соёлч боловсон үзүүлэх зорилт тавин ажиллаж, харъяа хэлтсүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж, ажлын хэрэгжилт, гүйцэтгэлд байнгын хяналт тавьж, ажилтнуудын эрх үүрэг, ажлын цагийн хуваарийг баримтлан ажиллаж байна. Нийгмийн даатгал, Нийгмийн халамж үйлчилгээ, Нотариат, Кадастр, Банкны үйлчилгээг үзүүлж байна. 3 дугаар сараас автомашины татвар хураалттай холбогдуулан Татварын хэлтэс түр хугацаанд ажиллан нийтдээ 44996 иргэнд төрийн үйлчилгээг хүргэлээ.<br>Төрийн үйлчилгээний цахим машиныг 5 сараас эхлэн ажиллуулж төрсний бүртгэлийн, иргэний үнэмлэхний, гэрлэлтийн, татварын, үл хөдлөх хөрөнгийн лавлагаа, оршин суугаа хаягийн тодорхойлолт, хуулийн этгээдийн улсын бүртгэл, цахилгааны төлбөр, орон сууц захиалах хүсэлт, хэвлэл захиалга гэх мэт үйлчилгээг үзүүлж байна. | | |
| 157 | | Төрийн цахим үйлчилгээний ТҮЦ машиныг нэмэгдүүлнэ. | БүХ | 100% |
| | | Төрийн үйлчилгээний цахим машиныг 5 сараас эхлэн ажиллуулж төрсний бүртгэлийн, иргэний үнэмлэхний, гэрлэлтийн, татварын, үл хөдлөх хөрөнгийн лавлагаа, оршин суугаа хаягийн тодорхойлолт, хуулийн этгээдийн улсын бүртгэл, цахилгааны төлбөр, орон сууц захиалах хүсэлт, хэвлэл захиалга гэх мэт үйлчилгээг үзүүлж байна. Тус дүүргийн хэмжээнд цахим үйлчилгээний ТҮЦ 15 ш машин суурилуулж иргэдэд зарим төрлийн үйлчилгээг ТҮЦ машинаас үзүүлж | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | байна.<br>2014 онд дүүргийн 10 хороо онлайнд холбогдож одоогийн байдлаар хороодод гэрлэлтийн 62 ,гэрлэлт цуцлуулсны бүртгэл 4 ,гэрчилгээ дахин олгосон 361 иргэний үнэмлэхийн дэлгэрэнгүй лавлагаа 183 нийт 613 бүртгэл хийсэн байна.Мөн хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн хөрөнгөтэй эсэх лавлагааг онлайнд холбогдсон хороодоос олгох ажлыг эхлүүлээд байна. Иргэний үнэмлэхийн захиалгыг ТҮЦ машинаар авч тус дүүргийн хэмжээнд 493 иргэний захиалга хүлээн авч үнэмлэхийг олгоод байна.Мөн ухаалаг гар утсанд бүртгэлийн үйл ажиллагааны чиглэл байршил,бүртгэлийн үйлчилгээний мэдээлэл зэргийг багтаасан програм зохион хэрэгжүүлж эхлээд байна. | | |
| 158 | | Хороодод төрсний гэрчилгээний дахин олголтын бүртгэлийг хөтлөнө. | БХ | 100% |
| | | 2014 онд төрөлтийн 3268, эцэг тогтоосны 1506 үрчлэлтийн 56,овог нэр өөрчилсний 216,гэрлэсний 796,гэрлэлт цуцлалтын 249 ,гэрчилгээ дахин олгох 846,гэрлэсний гэрчилгээ дахин олгох 125,засвар өөрчлөлтийн бүртгэл 56 нийт иргэний бүртгэлийн чиглэлээр 7118, үнэмлэх бүртгэл 7664,шилжилт хөдөлгөөний 12985 бүртгэл хийсэн байна.Бүртгэлийн үйлчилгээгээр 17,4 сая,үнэмлэх бүртгэл 138,4 сая,торгуулийн арга хэмжээ 20,9 сая төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.<br>Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 28073 мэдүүлэг хүлээн авч үүнээс анхны бүртгэл 2978,өмчлөх эрх шилжих гэрээний бүртгэл 3007, барьцааны гэрээний бүртгэл 11774,Бусад гэрээ 38,бүртгэлд өөрчлөлт оруулах 558,урьдчилсан тэмдэглэл 33,лавлагаа хуулбар 3755 олгох бүртгэлүүдийг хийгээд байна.Бүртгэлийн үйлчилгээгээр тэмдэгтийн хураамжаар 55,7 сая,татварын орлогод 1 тэрбум 910,4 төгрөгийн орлого төвлөрүүлээд байна. | | |
| 159 | | Дүүргийн 4 хороонд “Иргэдэд нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор байр”-ыг барих асуудлыг шийдвэрлэж, ашиглалтанд хүлээн авна. | ЗХХ | 100% |
| | | 13 дугаар хорооны цогцолбор байрыг 6 дугаар сард ашиглалтад хүлээн авна. 7, 2 дугаар хорооны байр барих газрын асуудлыг шийдвэрлүүллээ. | | |
| 160 | | Өөрийн байртай хороодод шинээр “Иргэний танхим” байгуулж, ажиллах нөхцөл боломжоор хангах асуудлыг судалж шийдвэрлэнэ | ЗХХ | 70% |
| | | Өөрийн байртай 10 хороодод иргэний танхим байгуулахаар тендер зарлагдсан. | | |
| 161 | | Хороодын ажлын албаны ажиллах нөхцөлийг сайжруулж, шаардлагатай засвар, тохижилтыг хийнэ. | ЗХХ | 70% |
| | | 14 дүгээр хороонд 79,493,000 17 дугаар хороонд 35,173,130 төгрөгийн өвөлжилтийн бэтгэл хангаж засвар хийхээр болсон. Цаг үеийн шаардлагатай урсгал засварын ажлуудыг тогтмол хийгдэж байна. Үүнд: 18,20-р хороодын гадна хаалгыг сольж, 00-ын өрөөний бочки, суултуур холигч, шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг хороодоос авч гэрэл, цоож, уртасгагч мэтийг хүлээлгэн өгсөн.Өвөлжилтийн бэлтгэл ажилтай холбогдуулан галлагаатай хороодын сангийн хоолой паарыг техникийн содоор угаах бэлтгэлийг бүрэн хангасан. Хөшиггүй хороодын судалгааг авч хороодыг 100% цонхны хөшигтэй болгохоор компани нь шалгараад гэрээгээ байгуулж байна. | | |
| 162 | 5.11 Дүүргийн гадаад харилцааг сайжруулж, өндөр хөгжилтэй орны хот, дүүргүүдтэй харилцаа тогтоож, төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ. | Хүүхэд солилцооны хөтөлбөрийг өргөжүүлнэ. | ЗХХ | 100% |
| | | Японы Нагано мужийн Саку хоттой хамтран хэрэгжүүлдэг хүүхэд солилцооны хөтөлбөрийн дагуу 2014 оны 07 дугаар сарын 30-ний өдрөөс 08 сарын 06-ны өдрүүдэд Саку хотын 8 сурагч, 4 албан хаагчийг хүлээн авч Монголын соёл, зан заншилтай танилцах хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүллээ. Уг хөтөлбөрийн дагуу Сүхбаатар дүүргээс дунд сургуулийн 8 сурагчийг Саку хот руу 2014 оны 10 дугаар сарын 27-ний өдрөөс 11 сарын 03-ний өдрүүдэд явуулахаар бэлтгэл ажлыг хангаж явуулсан. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Мөн 1996 оноос хойш уламжлалт харилцаатай ажиллаж ирсэн Сөүл хотын Жонг но дүүрэгтэй Сүхбаатар дүүрэг анх удаа Хүүхэд солилцооны хөтөлбөрийг 2014 оны 08 дугаар сарын 08-ны өдрөөс 16-ны өдрүүдэд зохион байгууллаа. Хоёр дүүргийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй анхны хөтөлбөрт Сүхбаатар дүүргээс дунд сургуулийн 3 сурагч 2014 оны 08 дугаар сарын 8-12-ны өдрүүдэд Жонг но дүүрэгт зохион байгуулсан сурагч солилцооны хөтөлбөрт оролцсон бол Сөүл хотын Жонг но дүүргийн дунд сургуулийн 3 сурагч 2014 оны 08 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд Сүхбаатар дүүрэгт ирж Монголын соёл, ёс заншилтай, монгол ахуйтай танилцах хөтөлбөрт оролцсон юм. | | |
| 163 | | Эрүүл мэнд боловсролын салбарын ажилтнуудыг харилцаат дүүргүүдэд туршлага солилцуулна. | ЗХХ ЭМН, БХ | 100% |
| | | 1. Эрүүл Мэндийн Хөгжлийн Төв, БНСУ-ын Сөүлийн их сургууль, “Рафаел Интернэшнл Клиник” ТББ-тай хамтран хэрэгжүүлж буй “Мэргэжилтнийг хөгжүүлэх тасралтгүй хөтөлбөр” төслийн хүрээнд 3 сургагч багш 102 эмч мэргэжилтнийг хүүхэд, зүрх судас, эх барих эмэгтэйчүүд, мэдрэл, дотоод шүүрэл, яаралтай тусламж сэдвээр давтан сургалтанд хамруулж, мэдлэг мэргэжлийг дээшлүүлсэн.<br>**2.** АШУИС, СБЭМТ “Хамтын ажиллагааны гэрээ” байгуулах ёслолын ажиллагаа 2014 оны 1 сарын 10-нд ЭМШУИС-ийн Эрдмийн Зөвлөлийн өргөөнд болж, хамтын ажиллагааны хүрээнд эрүүл мэндийн салбарт эмчилгээ оношилгооны дэвшилтэт технологийг хамтран нэвтрүүлэн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй болгох, төгсөлтийн өмнөх болон дараах сургалтанд хамтран ажиллаж, эмч, эмнэлгийн мэргэжилтэнг бэлтгэх, давтан сургах, эмч нарыг эрдэм шинжилгээ, судалгааны ажилд хамруулан чадавхижуулах чиглэлээр ажилласан.<br>3. АШУҮИС, Канад улсын Саймон Фрейзэрийн Их сургууль, СЭМТ-ийн хамтран “Агаарын бохирдол ургийн хөгжилд нөлөөлөх нь” Угаар төсөл 2 үе шаттайгаар хэрэгжүүлж байна.<br>4. Япон улсын ЭСЯ “Өвсний үндэс” төсөлд хамрагдаж, байгууллагын цонх, хаалга, хоол зүйн кабинет, эмч, ажиллагчдын эмчилгээний кабинет, хүчирхийлэлд өртөгсдөд тусламж үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний өрөөг бүрэн засварласнаар үйлчүүлэгчийн нийгэм хамгааллын асуудал, хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах орчин нөхцлийг сайжруулж, сэтгэл ханамжийг дээшлүүлсэн.<br>5. Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээнд ДЗОУБ-тай хамтран дүүргийн алслагдсан хороодод “Гал голомт хөтөлбөр, Эх хүүхэд бүр т хүрч үйлчилье” аян “Орчны эрүүл ахуй, түүнээс гарах халдварт өвчнөөс сэргийлье” өдөрлөг, “Эрэмбэлэн ангилах, яаралтай тусламж” сургалт, НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр хүүхдийн дархлаажуулалтын кабинет тохижуулах төсөл зэргийг амжилттай хэрэгжүүлснээр эхний 10 сард нялхсын эндэгдэл өмнө оны мөн үеэс 6 тохиолдол буюу 2.31 промилоор буурсан буюу нийслэлийн дунджаас 2.03 промилоор доогуур, 1-5 насны хүүхдийн эндэгдэл өмнө оны мөн үеэс 2 тохиолдол буюу 0.71 промилоор бага, нийслэлийн дундажтай харьцуулахад 0.85 промилоор доогуур, осол гэмтлээс шалтгаалсан эндэгдэл 4 буюу урьд оны мөн үеэс 3 тохиолдлоор багассан үр дүн гарсан.<br>**6.** Зүрх судасны өвчний оношилгоо, эмчилгээ, хяналтын чанарыг дээшлүүлэх, 3 дахь шатлалын эмнэлгүүдийн ачааллыг бууруулах зорилгоор “Зүрх судасны төв, эх нярайн эрүүл мэнд ба цахим эрүүл мэндийн өргөжил” Люксембургийн MON/005 төслийн хүрээнд Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн зүрх судасны кабинетад зүрхний өнгөт ЭХО аппарат, пульсоксиметр, автомат дуслын систем, иж бүрэн комьпютер,сканнер зэрэг нийт 86 | | |

| | | |
|---|---|---|
| | | сая төгрөгний тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн нь тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдэж, зүрх судасны эмгэгийг оношлох, эмчлэх чанар сайжирч, өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангасан орчин үеийн үйлчилгээг ард иргэдэд үзүүлэх боломжтой болсон. |

ТАНИЛЦСАН: ЗАСАГ ДАРГА Д.БАДАРСАН
ХЯНАСАН: ЗДТГ-ын ДАРГА Д.БААСАНБАТ
НЭГТГЭСЭН: ЗАХИРГАА, ХУУЛИЙН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Б.БАТЦЭЦЭГ